EPSON
EXCEED YOUR VISION

XP-255/257 Series

Хэрэглэгчийн Заавар

NPD5907-00 MN

Зохиогчийн эрх

Seiko Epson Corporation-н урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрлийг авалгүйгээр энэхүү хэвлэмэл материалын ямар нэгэн хэсгийг дахин боловсруулах, эсвэл мэдээллийн системд хадгалах болон ямар нэг хэлбэрээр, эсвэл ямар нэгэн байдлаар, электрон, механик, фото хуулбар, бичлэг, эсвэл өөр замаар дамжуулж болохгүй. Энд агуулагдсан мэдээллийг ашиглахтай холбоотойгоор ямар нэг патентийн хариуцлагын асуудал үүсэхгүй. Түүнчлэн, энд агуулагдсан мэдээллийг ашиглахаас үүдэн гарсан хор хохирлыг хариуцахгүй. Энд агуулагдсан мэдээлэл нь зөвхөн Epson-н бүтээгдэхүүнийг ашиглахад зориулан гаргасан болно. Бусад бүтээгдэхүүнийг хэрэглэхийн тулд энэхүү мэдээллийг ямарваа байдлаар хэрэглэсэн хариуцлагыг Epson хүлээхгүй.

Осол зөрчил гаргасан, буруу хэрэглэсэн, эсвэл буруугаар ашигласан, дур мэдэн өөрчлөлт оруулсан засвар хийсэн, эсвэл энэхүү бүтээгдэхүүнд өөрчлөлт оруулсан, эсхүл (АНУ-с бусад газар) Seiko Epson Corporation-н ашиглалт, засвар үйлчилгээний зааварчилгааг чанд мөрдөж чадаагүйгээс энэхүү бүтээгдэхүүний худалдан авагч, гуравдагч этгээдийн гаргасан хор хохирол, алдагдал, зардал, зарлагыг энэхүү бүтээгдэхүүнийг худалдан авагч, эсвэл гуравдагч этгээдийн өмнөөс Seiko Epson Corporation болон түүний салбар компаниуд хариуцахгүй.

Epson-н үндсэн бүтээгдэхүүн, эсвэл Epson-н Seiko Epson Corporation-р баталгаажуулсан бүтээгдэхүүн гэж тогтоосноос бусад ямарваа хэрэглээний бүтээгдэхүүн, эсвэл аливаа ашиглах сонголтоос үүдэн гарах ямарваа хор хохирол, асуудал бэрхшээлийг Seiko Epson Corporation болон түүний салбар компани хариуцахгүй.

Seiko Epson Corporation-н Epson-н баталгаажуулсан бүтээгдэхүүн гэж тодорхойлсноос бусад интерфэйсийн кабель утсыг ашигласнаас үүдэх цахилгаан соронзон цохилтоос үүдэн гарах ямарваа хор хохирлыг Seiko Epson Corporation хариуцахгүй.

© 2017 Seiko Epson Corporation

Энэхүү заавар, энэхүү бүтээгдэхүүний техникийн тодорхойлолтын агуулгыг аливаа мэдэгдэл өгөлгүйгээр өөрчилж болно.

Худалдааны тэмдэг

- EPSON® нь бүртгэлтэй худалдааны тэмдэг бөгөөд EPSON EXCEED YOUR VISION буюу EXCEED YOUR VISION нь Seiko Epson Corporation-н худалдааны тэмдэг болно.
- PRINT Image Matching™ болон PRINT Image Matching логонууд нь Seiko Epson Corporation-н худалдааны тэмдэг болно.Copyright © 2001 Seiko Epson Corporation. All rights reserved.
- Epson Scan 2 software is based in part on the work of the Independent JPEG Group.
- libtiff

  Copyright © 1988-1997 Sam Leffler

  Copyright © 1991-1997 Silicon Graphics, Inc.

  Permission to use, copy, modify, distribute, and sell this software and its documentation for any purpose is hereby granted without fee, provided that (i) the above copyright notices and this permission notice appear in all copies of the software and related documentation, and (ii) the names of Sam Leffler and Silicon Graphics may not be used in any advertising or publicity relating to the software without the specific, prior written permission of Sam Leffler and Silicon Graphics.

  THE SOFTWARE IS PROVIDED "AS-IS" AND WITHOUT WARRANTY OF ANY KIND, EXPRESS, IMPLIED OR OTHERWISE, INCLUDING WITHOUT LIMITATION, ANY WARRANTY OF MERCHANTABILITY OR FITNESS FOR A PARTICULAR PURPOSE.

  IN NO EVENT SHALL SAM LEFFLER OR SILICON GRAPHICS BE LIABLE FOR ANY SPECIAL, INCIDENTAL, INDIRECT OR CONSEQUENTIAL DAMAGES OF ANY KIND, OR ANY DAMAGES WHATSOEVER RESULTING FROM LOSS OF USE, DATA OR PROFITS, WHETHER OR NOT ADVISED OF THE POSSIBILITY OF DAMAGE, AND ON ANY THEORY OF LIABILITY, ARISING OUT OF OR IN CONNECTION WITH THE USE OR PERFORMANCE OF THIS SOFTWARE.
- Microsoft®, Windows®, and Windows Vista® are registered trademarks of Microsoft Corporation.
- Apple, Macintosh, Mac OS, OS X, Bonjour, Safari, iPad, iPhone, iPod touch, and iTunes are trademarks of Apple Inc., registered in the U.S. and other countries.
- Google Cloud Print, Chrome, Chrome OS, and Android are trademarks of Google Inc.
- QR Code is a registered trademark of DENSO WAVE INCORPORATED in Japan and other countries.
- Adobe and Adobe Reader are either registered trademarks or trademarks of Adobe Systems Incorporated in the United States and/or other countries.
- Intel® is a registered trademark of Intel Corporation.
- Ерөнхий тэмдэглэл: Энд хэрэглэсэн бусад бүтээгдэхүүний нэр нь зөвхөн үзүүлэнгийн зориулалттай бөгөөд зохих эзэмшигчийн худалдааны тэмдэг болно.Epson нь тэдгээр худалдааны тэмдгийн ямарваа болон бүх эрхээс татгалзана.

Агуулга

Зохиогчийн эрх

Худалдааны тэмдэг

Энэхүү гарын авлагын тухай

Гарын авлагын танилцуулга. 8
Мэдээллийг хайх гарын авлагыг ашиглах. . . . 8
Тэмдэг тэмдэглэгээ. 10
Энэхүү гарын авлагад ашигласан тодорхойлолт. 10
Үйлдлийн системийн лавлагаа. 10

Чухал заавар

Аюулгүй байдлын заавар. 12
Принтерийн зөвлөгөө, анхааруулга. 13
Принтерийг тохируулах/ашиглах зөвлөгөө, анхааруулга. 13
Утасгүй холболт бүхий принтерийг ашиглах зөвлөгөө ба анхааруулга. 14
Хувийн мэдээллээ хамгаалах. 14

Принтерийн үндсэн мэдээлэл

Эд ангийн нэр ба функцууд. 15
Хяналтын самбар. 17

Сүлжээний тохиргоо

Сүлжээний холболтын төрлүүд. 19
Wi-Fi холболт. 19
Wi-Fi Direct (Энгийн AP) холболт. 19
Компьютертай холбогдох. 20
Ухаалаг төхөөрөмжтэй холбох. 21
Принтерээс Wi-Fi тохиргоог хийх. 21
Түлхэх товчийг тохируулж Wi-Fi-н тохиргоог тохируулах. 22
PIN код оруулж Wi-Fi тохиргоог хийх (WPS). 23
Wi-Fi Direct (Энгийн AP) холболтын тохиргоог хийх. 24
Сүлжээний холболтын төлөвийг шалгах. . . . 25
Сүлжээний гэрлийг ашиган сүлжээний төлөвийг шалгах. 25
Сүлжээний холболтын тайланг хэвлэх. . . . 25
Сүлжээний төлөвийн хуудсыг хэвлэх. 31
Шинэ нэвтрэх цэгийг солих, нэмэх. 32
Компьютерт холбох аргыг өөрчлөх. 32
Принтерийн хянах самбараас Сүлжээний тохиргоог сэргээх. 33

Цаас ачаалах

Цаас ашиглахтай холбоотой анхааруулга. . . 34
Бэлэн байгаа цаас ба багтаамж. 35
Цаасны төрлийн жагсаалт. 36
Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах. 37

Сканнерын Шил дээр эх хувийг байрлуулах

Нэгэн зэрэг олон зургийг сканнердахаар тавих. 41

Хэвлэх

Компьютероос хэвлэх. 42
Принтерийн үндсэн мэдээлэл — Windows. 42
Хэвлэх үндсэн алхмууд Mac OS. 43
Хоёр тал дээр хэвлэх (Windows-т зөвхөн). 46
Нэг хуудсан дээр хэд хэдэн хуудсыг хэвлэх. 47
Цаасны хэмжээнд тааруулж хэвлэх. 48
Олон тооны файлыг хамт хэвлэх (Windows-т зөвхөн). 50
Нэг зургийг олон хуудсан дээр хэвлэж зурагт хуудас үүсгэх (зөвхөн Windows). . . 51
Дээд зэргийн тохиргоог ашиглан хэвлэх. . 57
Epson Easy Photo Print ашиглаж фото зураг хэвлэх. 60
Ухаалаг төхөөрөмжөөс хэвлэх. 60
Epson iPrint ашиглах. 60
Хэвлэхийг цуцлах. 62
Хэвлэхийг цуцлах — Принтерийн товч. . . .62
Хэвлэхийг цуцлах — Windows. 62
Хэвлэхийг цуцлах — Mac OS. 62

Хуулбарлах

Хуулбарлах үндсэн мэдээлэл. 63
Олон тооны хуулбар хийх. 63

Скандах

Хяналтын самбараас скандах. 64
Компьютероос скандах. 64
Epson Scan 2 ашиглан сканнердах. 64
Ухаалаг төхөөрөмжөөс сканнердах. 71
Epson iPrint Суулгах. 71
Epson iPrint ашиглан сканнердах. 71

Хорны картриджийг солих

Бэхний Түвшинг Шалгах. 73
Бэхний түвшинг шалгах - Windows. 73
Бэхний Түвшинг Шалгах — Mac OS. 73
Хорны картриджийн код. 73
Хорны картриджтай харьцах урьдчилсан санамж. 74
Хорны картриджийг солих (Гэрэл асаалттай эсвэл анивчиж байгаа үед). 77
Хорны картриджийг солих (Гэрэл унтраалттай байгаа үед). 81
Түр зуур хар хороор хэвлэх. 84
Түр зуур хар хороор хэвлэх — Windows. . .85
Түр зуур хар хороор хэвлэх — Mac OS. . . .86
Хар хор дуусаж эхлэнгүүт хэмнэх (Зөвхөн Windows). 87

Принтерийг хадгалах

Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх. 88
Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх — Принтерийн товчлуур. 88
Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх — Windows. 89
Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх — Mac OS. 89
Принтерийн толгойг тохируулна. 90
Принтерийн толгойг тохируулах — Windows. 90
Принтерийн толгойг тохируулна — Mac OS. 90
Цаас дамжих замыг цэвэрлэх. 91
Сканнерын Шил-г цэвэрлэх. 91
Тунгалаг хальсийг цэвэрлэх. 92
Эрчим хүч хэмнэх. 94
Эрчим хүч хэмнэх — Windows. 94
Цахилгаан хэмнэх — Mac OS. 94

Сүлжээний үйлчилгээ болон программын мэдээлэл

Epson Connect үйлчилгээ. 96
Web Config. 96
Web Config-г вэб хөтөч дээр ажиллуулах. .97
Web Config-г Windows дээр ажиллуулах. . .97
Web Config-г Mac OS дээр ажиллуулах. . . .98
Windows принтерийн драйвер. 98
Windows принтерийн драйверын заавар. . 99
Windows принтерийн драйверт ашиглалтын тохиргоог хийх. 101
Mac OS принтерийн драйвер. 101
Mac OS принтерийн драйверын заавар. . 102
Mac OS принтерийн драйверт ашиглалтын тохиргоог хийх. 104
Epson Scan 2 (Сканнерийн драйвер). 104
Epson Event Manager. 105
Epson Easy Photo Print. 105
E-Web Print (зөвхөн Windows-д зориулсан). 106
Easy Photo Scan. 106
EPSON Software Updater. 107
Программ хангамжийг суулгах. 108
Программ хангамжийг устгах — Windows. 108
Програм суулгах- Mac OS. 108
Программ хангамжийг устгах. 109
Программ хангамж, компанийн программыг шинэчлэх. 110

Асуудлыг шийдэх

Принтерийн төлөвийг шалгах. 111
Принтер дээрх алдаа заагчийг шалгах. . .111
Принтерийн төлөвийг шалгах — Windows. 113
Принтерийн төлөвийг шалгах — Mac OS. 113
Бөглөрсөн цаасыг салгах. 113
Арын Цаасны Дайз дотроос бөглөрсөн цаасыг салгах. 114
Гаргах тавиураас бөглөрсөн цаасыг салгах. 114
Принтер дотроос бөглөрсөн цаасыг салгах. 114
Цаас зөв татагдахгүй байвал. 116
Цаас гацалт. 116
Цаас хазайж татагдаж байвал. 117
Нэг дор хэд хэдэн хуудас татагдвал. 117
Тэжээл ба хяналтын самбарын асуудал. . . .117

Агуулга

Тэжээл асахгүй байна. 117
Тэжээл унтрахгүй байна. 117
Компьютероос хэвлэх боломжгүй. 117
Холболт шалгах (USB). 117
Холболт шалгах (Сүлжээ). 118
Программ хангамж ба өгөгдлийг шалгах 119
Компьютероос принтерийн төлөвийг шалгах (Windows). 121
Компьютероос принтерийн төлөвийг шалгах (Mac OS). 122
Сүлжээний тохиргоо хийж чадахгүй бол. . . 122
Хэдийгээр сүлжээний тохиргоонд асуудал гараагүй ч төхөөрөмжөөс холбогдох боломжгүй байх. 122
Утасгүй интернэтийн (Энгийн AP) шууд холболтыг ашиглан холбогдохгүй байгаа бол. 124
Принтертэй холбоотой SSID-г шалгах. . . 125
Компьютерын SSID-г шалгах. 126
Хэвлэмэл материалын асуудал. 127
Хэвлэгдсэн зүйл зурагдсан эсвэл өнгөгүй байх. 127
Судал эсвэл санаандгүй өнгүүд харагдана. 127
Ойролцоогоор 2.5 см-ийн зайтай өнгөт судлууд гарч ирнэ. 127
Бүдэг хэвлэлт, Босоо судал, Далий. 128
Хэвлэлтийн чанар муу байвал. 128
Цаас балархайтах буюу үнгэгдсэн байвал. 129
Хэвлэсэн фото зураг наалдамхай байвал 130
Зураг юмуу фото зураг хэвийн бус өнгөөр хэвлэгдэж байвал. 130
Өнгөнүүд дэлгэц дээр харагддагаасаа өөр байдаг. 131
Эргэн тойрон хүрээгүй хэвлэх боломжгүй. 131
Хүрээгүй хэвлэх явцад зургийн ирмэгийг тайрсан. 131
Хэвлэмэл материалын байрлал, хэмжээ, хүрээ буруу байх. 131
Хэвлэсэн тэмдэгт бурууу, ташаа байх. . . . 132
Хэвлэсэн зураг буруу харах. 132
Хэвлэлтийн Мозайк маягийн хээ угалз. . . 132
Ижил бус өнгө, бохирдол, цэг, эсвэл шулуун шугамууд хуулбарласан зураг дээр гарч ирэх. 132
Хуулбарласан зураг дээр муар (хөндлөн зураас)-н дүрс харагдах. 133
Эх хувийн эсрэг талын зураг хуулбарласан зураг дээр гарах. 133
Хэвлэмэл материалын асуудал шийдэгдэхгүй байх. 133
Хэвлэх бусад асуудал. 133
Хэт удаан хэвлэх. 133
Үргэлжилсэн Хэвлэлтийн Үед Хэвлэлт Удаашрах. 134
Сканыг эхлүүлж чадахгүй байна. 134
Хяналтын самбар ашиглаж байхад сканыг асааж чадахгүй байна. 135
Скандсан зурагны асуудал. 135
Сканерын шил дээрээс сканердахад жигд бус өнгө, тоос шороо, толбо зэрэг гарч ирвэл. 135
Зургийн чанар муу. 135
Оффсет зургийн ар талд харагдана. 136
Бичвэр бүдгэрэх. 136
Муар хээ (аалзны тор шиг сүүдэртсэн хээ) гарч ирвэл. 136
Сканнерийн шилэн дээрх зөв бүсийг сканнердаж болохгүй. 137
Жижиг зураг-д урьдчилан харах боломжгүй. 137
Бичвэр нь Хайлт хийж болох PDF хэлбэрээр хадгалах үед зөв танигдаагүй 137
Сканнердсан зургийн асуудлуудыг шийдвэрлэж чадахгүй байх. 138
Скандах бусад асуудал. 139
Хэт удаан скандаж байна. 139
PDF/Multi-TIFF руу скандах үед скандах ажиллагаа зогсоод байна. 139
Бусад асуудал. 139
Принтерт хүрэхэд бага зэргийн тог цохиж байна. 139
Ажиллагаа чанга дуутай байвал. 139
Программ хангамжийг Firewall хаах (Windows-т зөвхөн). 140

Хавсралт

Техникийн тодорхойлолт. 141
Принтерийн үзүүлэлт. 141
Сканнерийн үзүүлэлт. 142
Интерфэйсийн үзүүлэлт. 142
Сүлжээний функцийн жагсаалт. 143
Wi-Fi Үзүүлэлтүүд. 143
Аюулгүй байдлын протокол. 144
Дэмждэг гуравдагч талын үйлчилгээ. . . . 144
Хэмжээс. 144
Цахилгааны Үзүүлэлтүүд. 144
Орчны үзүүлэлт. 145
Системийн шаардлага. 145

Агуулга

Хууль журмын мэдээлэл. 146
Европ загварын стандарт болон зөвшөөрөл. 146
Хуулбарлахад тавигдах хязгаарлалт. . . . 146
Принтерийг зөөвөрлөх. 147
Хаанаас тусламж авах вэ. 149
Техник туслалцааны вэбсайт. 149
Epson-н тусламжтай холбогдох. 149

Энэхүү гарын авлагын тухай

Гарын авлагын танилцуулга

Дараах гарын авлагууд нь таны Epson принтерт дагалдаж ирсэн байгаа. Түүнчлэн эдгээр гарын авлагаас гадна Epson-н төрөл бүрийн программ хангамжид агуулагдсан тусламжуудыг бас лавлаарай.

❏ Энд эхэл (хэвлэмэл гарын авлага)

Принтерийг тохируулах, программ хангамжийг суулгах, принтерийг ашиглах, асуудлыг шийдвэрлэх зэрэг мэдээллийг танд өгнө.

❏ Хэрэглэгчийн Заавар (дижитал гарын авлага)

Энэхүү гарын авлага. Принтерийг сүлжээнд ашиглах тухай ерөнхий мэдээлэл ба зааврыг принтерийг сүлжээнд ашиглан асуудлыг шийдэх үед өгнө.

Та дээрх гарын авлагуудын хамгийн сүүлийн хувилбарыг дараах аргуудаар олж авах боломжтой.

❏ Хэвлэмэл гарын авлага

Epson Европ вэбсайтад http://www.epson.eu/Support хаягаар, эсвэл Epson дэлхий дахины вэбсайтад http://support.epson.net/ хаягаар зочлоорой.

❏ Дижитал гарын авлага

Компьютер дээрээ EPSON Software Updater-ийг эхлүүл. EPSON Software Updater нь Epson програм хангамж болон дижитал гарын авлагын боломжит шинэчлэлүүдийг шалгаж, хамгийн сүүлийн хувилбарыг татах боломжийг олгоно.

Холбогдох мэдээлэл

➡ 107 хуудас дээрх “EPSON Software Updater”

Мэдээллийг хайх гарын авлагыг ашиглах

PDF гарын авлага түлхүүр үгээр хайж байгаа мэдээллийг хайх боломж олгох ба мөн номын хавчуурга ашиглан тодорхой хэсэгт шууд очих боломжтой.Та мөн зөвхөн хэрэгтэй хуудсуудаа хэвлэх боломжтой.Энэ хэсэг нь таны компьютер дээр Adobe Reader X ашиглан нээгдсэн PDF гарын авлагыг хэрхэн ашиглахыг тайлбарлана.

Энэхүү гарын авлагын тухай

Түлхүүр үгээр хайх

Засах > **Нарийн хайлт** товш.Хайх цонхоос хайхыг хүсэж байгаа мэдээллийнхээ түлхүүр үг (бичвэр)-ийг оруулж, дараа нь **Хайх** товш.Хайлт жагсаалт хэлбэрээр харагдана.Харуулсан хайлтын нэгийг товшиж тухайн хуудас руу үсэр.



Номын хавчуургаас шууд үсрэх

Нэр дээр товшиж тухайн хуудас руу үсэр.+ эсвэл > товшиж тухайн хэсгийн доод түвшний нэрийг хар.Өмнөх хуудас руу буцахын тулд гар дээр байгаа дараах үйлдлийг гүйцэтгэ.

❏ Windows: **Alt**-г удаан дарж, дараа нь ← дар.

❏ Mac OS: Командын түлхүүрийг барьж, ← дар.



Зөвхөн хэрэгтэй хуудсаа хэвлэ

Та зөвхөн хэрэгтэй хуудсуудаа гаргаж хэвлэх боломжтой.**Хэвлэх** дээр **Файл** цэсээс товшиж, **ХуудсуудХэвлэх хуудсууд** дээрээс хэвлэхийг хүссэн хуудсуудыг тодорхой зааж өгнө үү.

❏ Цуврал хуудсуудыг тодорхой зааж өгөхийн тулд эхлэл ба төгсгөл хуудасны хоорондох зайг оруул.

Жишээ: 20 – 25

❏ Цувралд байхгүй хуудсуудыг тодорхой зааж өгөхийн тулд таслалаар хуудсуудыг заагла.

Жишээ: 5, 10, 15



Тэмдэг тэмдэглэгээ

> ***Болгоомжтой:***
> *Биедээ гэмтэл авахгүйн тулд анхааралтай дагах ёстой заавар.*

> ***Чухал:***
> *Принтертээ гэмтэл учруулахаас сэргийлэхийн тулд дагах ёстой заавар.*

Тэмдэглэл:
Нэмэлт, лавлагааны чанартай мэдээллээр хангана.

➡ Холбогдох мэдээлэл

Холбогдох хэсэг рүү хөтлөх холбоос.

Энэхүү гарын авлагад ашигласан тодорхойлолт

❏ Принтерийн драйверын дэлгэцийн дүрслэл болон Epson Scan 2 (сканнер драйвер) дэлгэц нь Windows 10 эсвэл macOS High Sierra-с гарсан. Дэлгэц дээр дүрсэлсэн зүйлс загвар, нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байдаг.

❏ Энэхүү гарын авлагад ашигласан принтерийн зураглал зөвхөн жишээний үүрэгтэй. Загвараас шалтгаалан бага зэргийн ялгаа байж болох ч, ажиллуулах арга ажиллагаа адил байна.

Үйлдлийн системийн лавлагаа

Windows

Энэхүү гарын авлагад дурдсан "Windows 10", "Windows 8.1", "Windows 8", "Windows 7", "Windows Vista", "Windows XP" зэрэг нэршил нь дараах үйлдлийн системийг илэрхийлсэн болно. Түүнчлэн, "Windows" нь бүх хувилбарыг илэрхийлнэ.

❏ Microsoft® Windows® 10 үйлдлийн систем

❏ Microsoft® Windows® 8.1 үйлдлийн систем

❏ Microsoft® Windows® 8 үйлдлийн систем

❏ Microsoft® Windows® 7 үйлдлийн систем

❏ Microsoft® Windows Vista® үйлдлийн систем

❏ Microsoft® Windows® XP үйлдлийн систем

❏ Microsoft® Windows® XP Professional x64 Edition үйлдлийн систем

Энэхүү гарын авлагын тухай

Mac OS

Энэ гарын авлагад, "Mac OS" нь macOS High Sierra, macOS Sierra, OS X El Capitan, OS X Yosemite, OS X Mavericks, OS X Mountain Lion, Mac OS X v10.7.x болон Mac OS X v10.6.8 зэргийг илэрхийлнэ.

Чухал заавар

Аюулгүй байдлын заавар

Энэхүү принтерийг аюулгүй ашиглахын тулд дараах зааврыг уншиж даган мөрдөнө үү. Энэхүү гарын авлагыг ирээдүйд ашиглахын тулд хадгална уу. Түүнчлэн, энэхүү принтер дээр тэмдэглэсэн бүх анхааруулга, зааврыг мөрдөж биелүүлнэ үү.

- ❏ Таны принтерт хэрэгдэгдэж байгаа зарим таних тэмдгүүд нь принтерийг зөв, аюулгүй ашиглахад зориулагдсан байдаг. Уг таних тэмдгүүдийн утга учрын талаар мэдэхийн тулд дараах веб сайтад зочилно уу.

  http://support.epson.net/symbols

- ❏ Энэхүү принтертэй цуг ирсэн тэжээлийн утсыг зөвхөн ашиглаж, аливаа бусад тоног төхөөрөмжийн тэжээлийн утсыг ашиглахаас татгалзана уу. Энэхүү принтерт бусад төхөөрөмжийн цахилгаан утсыг ашиглах, эсвэл цуг ирсэн тэжээлийн утсыг өөр бусад тоног төхөөрөмж дээр ашиглах нь гал түймэр, цахилгаанд цохиулах аюулгүй бий болгоно.

- ❏ АС тэжээлийн утас дотоодын аюулгүй ажиллагааны зохих стандартад нийцэж байгаа эсэхийг шалгана уу.

- ❏ Принтерийн гарын авлага дээр тодорхой зааснаас бусад тохиолдолд тэжээлийн утас, залгуур, принтерийн эд анги, сканнерийн эд ангийг өөрийн мэдлээр хэзээ ч бүү задалж, өөрчлөн, засахыг оролдох хэрэггүй.

- ❏ Дараах тохиолдолд принтерийг тэжээлээс салгаж, ур чадвар бүхий үйлчилгээний ажилтнаар засвар үйлчилгээ хийлгэнэ үү:

  Тэжээлийн утас, эсвэл залгуур эвдэрсэн; принтерт шингэн нэвтэрсэн; принтерийг унагаасан, эсвэл гаднах хайрцаг эвдэрсэн; принтер ердийн байдлаар ажиллахгүй эсвэл ажиллагаанд нь онцгой өөрчлөлт орсон. Ашиглалтын зааварт ороогүй хяналтын үйл ажиллагааг тохируулж болохгүй.

- ❏ Залгуурыг хялбар холбож болохоор байрлалд ханын залгуурт ойр принтерийг байрлуулна.

- ❏ Их хэмжээний тоос шороо, ус, халууны эх үүсвэр бүхий гадаа байрлалд принтерийг тавихгүй байх, эсвэл цахилгаанд цохиулах, чичиргээнд өртөх өндөр температур, чийгтэй газар тавьж болохгүй.

- ❏ Принтер дээр шингэн асгахгүй байхад анхаарал хандуулж, принтерт нойтон гараар хүрч ажиллуулахгүй байх.

- ❏ Зүрхний хэм хэмжигчээс принтерийг 22 см-с доошгүй зайд байрлуулна. Энэхүү принтерээс гарах радио долгион зүрхний хэм хэмжигчийн ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх боломжтой.

- ❏ Бэх нийлүүлэх портны эргэн тойронд тодорхой хэмжээний бэх үлдсэн байдаг тул та ашигласан бэхний картриджтай ажиллах үед болгоомжтой байна уу.

  - ❏ Бэхийг арьсандаа хүргэвэл, уг газраа саван, усаар сайтар угаана.

  - ❏ Бэхийг нүдэндээ оруулбал, нэн даруй усаар зайлж угаана. Сайн зайлсны дараа ч таагүй байдал мэдрэгдэж, сайтар харахгүй байвал, эмчид яаралтай үзүүлнэ.

  - ❏ Бэхийг амандаа оруулбал, нэн даруй эмчид үзүүлнэ.

- ❏ Бэхний картриджийг задалж болохгүй, эс тэгвээс бэх таны нүдэнд орж, эсвэл арьсан дээр асгарна.

- ❏ Бэхний картриджийг хэт хүчтэй савлаж, унагааж болохгүй. Түүнчлэн, бэхний савыг шахахгүй, эсвэл шошгыг нь урахгүй байхад анхаарал хандуулна. Ингэвэл, принтерийн бэх гоожиход хүргэж болно.
- ❏ Бэхний картриджийг хүүхдийн гар хүрэхгүй газар хадгална.

Принтерийн зөвлөгөө, анхааруулга

Принтер болон өөрийн эд хөрөнгөө эвдрэл гэмтлээс сэргийлэхийн тулд дараах зааврыг дагаж мөрдөнө үү. Энэхүү гарын авлагыг ирээдүйд ашиглахын тулд хадгална уу.

Принтерийг тохируулах/ашиглах зөвлөгөө, анхааруулга

- ❏ Принтерийн хоолой, нээлхийг хааж, таглахгүй байх.
- ❏ Принтерийн шошго дээр заасан тэжээлийн эх үүсвэрийн төрлийг ашиглах.
- ❏ Байнга асаж унтарч байдаг хувилагч машин, эсвэл агаарын хяналтын систем зэрэгтэй нэг хэлхээнд байрлах залгуурт залгахгүй байх.
- ❏ Ханын унтраалга, эсвэл автомат цаг зэргийн удирддаг цахилгаан залгуур хэрэглэхээс зайлсхийх.
- ❏ Чанга яригч, утасгүй телефон утасны үүр зэрэг цахилгаан соронзон нөлөөлөл бүхий боломжит эх үүсвэрээс компьютерийн ерөнхий системийг хол байрлуулах.
- ❏ Эрчим хүчний тэжээлийн цахилгаан утсыг зулгарах, зүсэгдэх, эрчлэх, хугарах, нугаларахаас сэргийлж байрлуулна. Эрчим хүчний тэжээлийн цахилгаан утсан дээр эд юмс тавьж болохгүй бөгөөд эрчим хүчний тэжээлийн цахилгаан утсан дээр гишгэх гүйхийг хориглоно. Трансформатор руу орж байгаа болон гарч байгаа төгсгөлийн хэсэг дээр эрчим хүчний тэжээлийн цахилгаан утсыг шулуун байлгахад онцгой анхаарал хандуулна.
- ❏ Принтер дээр уртасгагч цахилгаан утас ашиглах бол, уртасгагч утсанд залгах төхөөрөмжийн нийт ампер нь цахилгаан утасны амперийн хэмжээнээс хэтрэхгүй байхад анхаарал хандуулна. Түүнчлэн, ханын залгуур залгасан бүх төхөөрөмжийн амперийн хэмжээ ханын залгуурын нийт амперийн хэмжээнээс хэтрэхгүй байхад анхаарна.
- ❏ Та энэхүү принтерийг Герман улсад ашиглахаар төлөвлөж байгаа бол, принтерийн богино холболтын хамгаалалт, хэт гүйдлийн хамгаалалтын зохих түвшинг хангахын тулд ашиглах барилга дээрх суурилуулалтыг 10 эсвэл 16 амперын хэлхээ таслагчаар хамгаалах ёстой.
- ❏ Принтерийг компьютер болон бусад төхөөрөмжтэй кабель утсаар холбох үед холболт зөв чиглэлтэй хийгдсэн эсэхийг бататгах хэрэгтэй. Холбогч бүрт холболтын цорын ганц зөв чиглэл байдаг. Холбогчийг буруу чиглэлээр хийх нь кабель утсаар холбосон хоёр төхөөрөмжийн аль алинд эвдрэл гэмтэл учруулах боломжтой.
- ❏ Принтерийг принтерийн сууриас бүх чиглэлд сунгах боломжтой тэгш, тогтвортой гадаргуу дээр байрлуулна. Принтерийг тодорхой өнцгөөр хазайлгасан үед зохих ёсоор ажиллахгүй.
- ❏ Принтерийг хадгалж, тээвэрлэх үед, үүнийг хазайлгах, босоо байрлалд тавих, хөмөрч тавихаас болгоомжлох хэрэгтэй.
- ❏ Цаасны тагийг бүрэн нээх боломжтой байхын тулд принтерийн дээд хэсэгт зайтай байлгах.
- ❏ Цаасыг бүрэн гаргаж авах боломжтой байхын тулд принтерийн урд талд хангалттай зай үлдээх.
- ❏ Температур, чийгшлийн эрс өөрчлөлт бүхий газарт байрлуулахаас зайлсхийх. Түүнчлэн, принтерийг нарны шууд тусгал, хурц гэрэл, халууны эх үүсвэрээс хол байлгана.
- ❏ Принтерийн сувгаар дамжуулж эд юмс оруулахгүй байх.

Чухал заавар

- ❏ Хэвлэж байхад принтер дотор гараа оруулахгүй байх.
- ❏ Принтерийн дотор талын цагаан хавтгай кабель утсанд гараа хүргэхгүй байх.
- ❏ Принтерийн дотор талд болон эргэн тойронд шатамхай хий агуулсан аэрозолын бүтээгдэхүүн ашиглахгүй байх. Тэдгээрийг ашигласнаар гал түймэр гарч болно.
- ❏ Принтерийн толгойг гараар хөдөлгөхгүй байх; эс тэгвээс, та принтерт эвдрэл гэмтэл учруулж болно.
- ❏ Сканнерийн эд ангийг хаахдаа гараа хавчуулахаас болгоомжилно уу.
- ❏ Эх хувийг тавихдаа сканнерын шил дээр хэт чанга дарахгүй байх.
- ❏ Үргэлж ⏻ товчийг ашиглаж принтерийг унтрааж байх. ⏻ гэрэл анивчихаа болих хүртэл принтерийн залгуурыг салгахгүй, эсвэл тэжээлийг залгуураар унтраахгүй байх.
- ❏ Принтерийг тээвэрлэхээс өмнө, принтерийн толгой үндсэн (баруун өнцөг) байрлалд байгааг мөн бэхний картридж байгаа эсэхийг шалгах.
- ❏ Та принтерийг удаан хугацаагаар ашиглахгүй бол, тэжээлийн цахилгаан утсыг цахилгааны залгуураас салгахаа мартуузай.

Утасгүй холболт бүхий принтерийг ашиглах зөвлөгөө ба анхааруулга

- ❏ Энэхүү принтерээс гарч буй радио долгион эрүүл мэндийн электрон тоног төхөөрөмжид сөрөг нөлөө үзүүлж, тэдгээрийг бүрэн гүйцэд ажиллагаанд саад учруулж болно.Эрүүл мэндийн байгууламж, эсвэл эрүүл мэндийн тоног төхөөрөмжийн ойролцоо тус принтерийг ашиглахдаа, эрүүл мэндийн байгууламжийг төлөөлж буй эрх бүхий ажилтны өгсөн зааварчилгааг дагаж, эрүүл мэндийн тоног төхөөрөмжийн бүх анхааруулга, санамжийг дагах хэрэгтэй.
- ❏ Энэхүү принтерээс гарч буй радио долгион автомат хаалга болон галын дохио зэрэг автомат хяналттай төхөөрөмжийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай ба үйл ажиллагааны доголдлоос болж осол зөрчилд хүргэж болно.Энэхүү принтерийг автомат хяналттай төхөөрөмжийн дэргэд ашиглахдаа, тэдгээр төхөөрөмжийн бүх анхааруулга, санамжийг дагаж мөрдөнө үү.

Хувийн мэдээллээ хамгаалах

Та тус принтерийг хэн нэгэнд өгөх, эсвэл хаяхдаа, хяналтын самбар дээрх товчлуурыг дарангаа ⏻ товчлуураар принтерийг асааснаар принтерийн санах ойд хадгалагдсан сүлжээний тохиргоогоо арилгаж болно.

Принтерийн үндсэн мэдээлэл

Эд ангийн нэр ба функцууд



1	Ирмэг заагч	Цаасыг шууд принтерт татна. Цаасны ирмэгт тултал гулгуул.
2	Арын цаасны дайз	Цаасыг ачаална.
3	Цаасны тулгуур	Ачаалсан цаасанд тулгуур болно.
4	Татагчийн хаалт	Принтерт гадны биет орохоос сэргийлнэ. Энэхүү хаалтыг байнга хаалттай байлга.
5	Гаралтын тэвш	Гаргасан цаасыг тогтооно.
6	Хяналтын самбар	Принтерийг ажиллуулна.



1	Сканнерийн нэгжийн дэмжлэг	Сканнерийн нэгжийг дэмжинэ.

Принтерийн үндсэн мэдээлэл

❷	Хорны картриджийн суурь	Хорны картриджийг суурьлуулах. Принтерийн хошуу толгойноос хор гарсан байна.



❶	Баримтын таг	Сканнердаж байхад гадны гэрлийг хаана.
❷	Сканнерын шил	Эхийг байрлуул.
❸	Сканнерийн нэгж	Байрлуулсан эхийг сканнердана. Принтер доторх гацсан цаасыг авах эсвэл хорны картриджийг солихын тулд үүнийг онгойлго.



❶	AC оролт	Тэжээлийн залгуурыг холбоно.
❷	USB порт	Компьютерт холбогдох USB кабелийг холбоно.

Хяналтын самбар



❶		Зүүн, баруун гэрэл нь сүлжээний төлөвийг харуулна. ❑ (Ногоон гэрэл — зүүн): Принтер утасгүй (Wi-Fi) сүлжээнд холбогдох үед асаж, холбоо тогтоох зуур анивчина. ❑ (Улбар шар гэрэл — баруун): Принтер утасгүй интернетийн шууд горимын сүлжээнд (Энгийн AP) холбогдох үед асна. Сүлжээний тохиргоог эхлүүлж, холбож байхдаа дээрх гэрлүүд ээлжлэн, эсвэл хамтдаа анивчина.
❷		Принтерийг асааж унтраана. Тэжээлийн гэрэл анивчиж байхад унтрааж болохгүй (принтер ажиллаж, эсвэл өгөгдөл дамжуулж байхад). Тэжээлийн гэрэл унтарсан үед тэжээлийн залгуурыг салгана.
❸	Wi-Fi	Сүлжээний алдаа гарсан үед, энэ товчийг дарвал алдаа цуцлагдана. WPS-н даралтат товчлуур ашиглан Wi-Fi-н автомат тохиргоог хийхийн тулд энэхүү товчийг 3 секундээс удаан дарна.
❹		Принтерийг сүлжээнд ашиглах үеэр гарсан аливаа асуудлыг тодорхойлох сүлжээний холболтын тайланг хэвлэнэ. Хэрэв танд илүү нарийн сүлжээний тохиргоо, холболтын статус хэрэгтэй байгаа бол энэ товчийг 10 секунд удаан дарж сүлжээний статусын хуудсыг хэвлэнэ үү.
❺		A4 хэмжээтэй ердийн цаасан дээр монохромт хуулбарыг хийж эхэлнэ. Хуулбарын тоог өсгөхийн тулд (20 хүртэлх хуулбар) нэг секундын зайтайгаар энэ товчийг дар.
❻		A4 хэмжээтэй ердийн цаасан дээр өнгөт хуулбарыг хийж эхэлнэ. Хуулбарын тоог өсгөхийн тулд (20 хүртэлх хуулбар) нэг секундын зайтайгаар энэ товчийг дар.
❼		Одоогийн үйл ажиллагааг зогсооно. Принтерийн толгойны цэвэрлэгээг эхлүүлэхийн тулд товч анивчих хүртэл 3 секунд энэхүү товчийг дарна уу. гэрэл асангуут, энэ товчийг дарж хорны картриджийг соль. гэрэл анивчиж, унтрангуут, энэ товчийг хорны картридж тогтоогч хөдлөх хүртэл зургаан секунд удаан дарж картриджийг соль.
❽		Цаас дуусах, эсвэл цаас бөглөрсөн үед асаж, анивчина.
❾		Хорны картридж алдаа заавал тухайлбал хорны картриджийг солих хэрэгтэй бол асна. Хор дуусаж эхлэнгүүт анивчина.

Принтерийн үндсэн мэдээлэл

Товчнуудын янз бүрийн хослолын тусламжтайгаар нэмэлт үүрэг ажиллагааг ашиглах боломжтой.

+	ба товчуудыг зэрэг дарж USB-с холбогдсон компьютер дээрх программ хангамжийг ажиллуулж PDF файл хэлбэрээр скандана.
Wi-Fi +	Wi-Fi товчийг дарж байгаад, товчийг гэрэл ба гэрэл зэрэг анивчтал дарж бариад PIN Кодны тохиргоог (WPS) эхлүүл.
Wi-Fi +	Wi-Fi товчийг дарж байгаад, товчийг гэрэл ба гэрэл зэрэг анивчтал дарж бариад Wi-Fi Direct (Энгийн AP) тохиргоог эхлүүл.
+	Сүлжээний үндсэн тохиргоог сэргээхийн тулд товчийг дарж принтерийг асаана. Сүлжээний тохиргоог сэргээх үед принтер асаж, сүлжээний статус улбар шар ба ногоон өнгөөр анивчина.
+	Хошуу шалгах дүрсийг хэвлэхийн тулд товчийг дарж принтерийг асаана.

Холбогдох мэдээлэл

➡ 111 хуудас дээрх “Принтер дээрх алдаа заагчийг шалгах”
➡ 23 хуудас дээрх “PIN код оруулж Wi-Fi тохиргоог хийх (WPS)”
➡ 33 хуудас дээрх “Принтерийн хянах самбараас Сүлжээний тохиргоог сэргээх”

Сүлжээний тохиргоо

Сүлжээний холболтын төрлүүд

Та дараах холболтын аргуудыг ашиглаж болно.

Wi-Fi холболт

Принтер, компьютер, ухаалаг төхөөрөмжөө нэвтрэх цэг рүү холбо. Энэ нь компьютерууд нэвтрэх цэгээр дамжуулж Wi-Fi-аар холбогдсон байдаг гэр, оффисын сүлжээний холболтын ердийн арга юм.



Холбогдох мэдээлэл

➡ 20 хуудас дээрх “Компьютертай холбогдох”

➡ 21 хуудас дээрх “Ухаалаг төхөөрөмжтэй холбох”

➡ 21 хуудас дээрх “Принтерээс Wi-Fi тохиргоог хийх”

Wi-Fi Direct (Энгийн AP) холболт

Та ажил болон гэртээ Wi-Fi ашиглахгүй байгаа үедээ эсвэл принтер компьютер болон ухаалаг төхөөрөмжийг шууд холбохыг хүсвэл энэ холболтын аргыг ашиглаарай. Энэ горимд принтер нь нэвтрэх цэгийн үүргийг гүйцэтгэх ба стандарт нэвтрэх цэгийг ашиглахгүйгээр принтерт хамгийн дээд тал нь 4 төхөөрөмж холбох боломжтой. Хэдийгээр төхөөрөмжүүд нь принтерт шууд холбогдсон ч принтерээр дамжин бие биетэйгээ холбогдож чадахгүй.

Сүлжээний тохиргоо

Тэмдэглэл:
Wi-Fi Direct (Энгийн AP) Холболт нь Ad Hoc горимыг солиход зориулсан холболтын арга юм.



Принтер нь Wi-Fi болон Wi-Fi Direct (Энгийн AP) холболтоор зэрэг холбогдсон байх боломжтой. Гэхдээ, хэрэв та Wi-Fi Direct (Энгийн AP) холболтоор сүлжээний холболтыг эхлүүлбэл, принтер Wi-Fi-р холбогдох үед Wi-Fi-г түр салгана.

Холбогдох мэдээлэл

➡ 24 хуудас дээрх “Wi-Fi Direct (Энгийн AP) холболтын тохиргоог хийх”

Компьютертай холбогдох

Бид компьютерт принтерийг холбоход суулгагчийг ашиглахыг санал болгодог.Та дараах суулгагчийн аргуудын нэгийг ашиглан суулгах боломжтой.

❏ Вэбсайтаас тохируулах

Дараах вэбсайтаас нэвтэрч бүтээгдэхүүний нэрээ оруулна уу.**Тохируулга** орж, дараа нь суурилуулж эхэл.

http://epson.sn

❏ Программ хангамжийн диск ашиглан суулгах (зөвхөн диск драйвтай компьютертой хэрэглэгч болон програм хангамжийн дисктэй загваруудад зориулагдсан)

Компьютерт программ хангамжийн дискийг оруулаад дэлгэцэн дээрх зааварчилгааг дага.

Холболтын аргуудыг сонгох

Дараахыг дэлгэцэн дээр харуулах хүртэл дэлгэцэн дээрх зааварчилгааг дагаад компьютерт принтерийг холбох аргыг сонго.

Холболтын төрлийг сонгоод **Дараах** товш.



Дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Ухаалаг төхөөрөмжтэй холбох

Та ухаалаг төхөөрөмжийг холбосонтойгоо адилхан Wi-Fi сүлжээ (SSID)-д принтерийг холбосон бол ухаалаг төхөөрөмжөөс принтерийг ашиглах боломжтой. Ухаалаг төхөөрөмжөөс принтерийг ашиглахын тулд дараах вэбсайтаас суулгана уу. Та принтерээ холбохыг хүсэж байгаа ухаалаг төхөөрөмжөөсөө вэбсайтанд нэвтэрнэ үү.

http://epson.sn > **Тохируулга**

Тэмдэглэл:
Та компьютер болон ухаалаг төхөөрөмжөө нэгэн зэрэг Принтерт холбохыг хүсэж байвал эхлээд компьютероо холбохыг бид зөвлөж байна.

Принтерээс Wi-Fi тохиргоог хийх

Та принтерийн хянах самбараас хэд хэдэн аргаар сүлжээний тохиргоог хийх боломжтой.Таны ашиглаж буй орчин нөхцөл байдалтай тохирч байгаа холболтын аргыг товш.

Хэрэв нэвтрэх цэг WPS дэмждэг бол та түлхэх товчны тохиргоо ашиглан тохиргоог хийх боломжтой.

Принтерийг сүлжээнд холбосны дараа хэрэглэхийг хүсэж байгаа төхөөрөмжөөсөө принтерийг холбо (компьютер, ухаалаг төхөөрөмж, таблет гэх мэт)

Хөдөлгөөнгүй IP хаяг ашиглан сайжруулсан сүлжээний тохиргоо хий.

Холбогдох мэдээлэл

➡ 22 хуудас дээрх “Түлхэх товчийг тохируулж Wi-Fi-н тохиргоог тохируулах”

➡ 23 хуудас дээрх “PIN код оруулж Wi-Fi тохиргоог хийх (WPS)”

➡ 24 хуудас дээрх “Wi-Fi Direct (Энгийн AP) холболтын тохиргоог хийх”

Түлхэх товчийг тохируулж Wi-Fi-н тохиргоог тохируулах

Та нэвтрэх цэг дээрх товчийг дарснаар Wi-Fi сүлжээг автоматаар тохируулах боломжтой.Дараах нөхцөл биелсэн бол, та энэхүү аргыг ашиглаж тохиргоо хийх боломжтой.

❏ Нэвтрэх цэг нь WPS (Wi-Fi-ийн хамгаалалттай тохиргоо)-тай нийцсэн байх.

❏ Нэвтрэх цэг дээрх товчийг дарснаар одоогийн Wi-Fi холболтыг тогтоосон.

Тэмдэглэл:
Та товчийг олохгүй эсвэл програм ашиглан тохиргоо хийж байгаа бол, нэвтрэх цэгтэй цуг ирсэн баримт бичгийг үзнэ үү.

1. Хамгаалалтын гэрэл анивчих хүртэл нэвтрэх цэг дээрх [WPS] товчийг удаан дарна.



   Та [WPS] товчийг хаана байгааг мэдэхгүй байгаа бол, мөн нэвтрэх цэг дээр товч байхгүй бол, дэлгэрэнгүй мэдээллийг нэвтрэх цэгтэй цуг ирсэн баримт бичгээс үзнэ үү.

2. гэрэл, гэрэл анивчих хүртэл принтер дээрх Wi-Fi товчийг дарна (ойролцоогоор 3 секунд).

   Холболтын тохиргоо хийгдэж эхэлнэ.Холболт үүсэхэд гэрэл асна.



Тэмдэглэл:
болон гэрэл зэрэг анивчиж байвал принтер нь холболтын алдааны төлөвтэй байна.Принтер дээрх Wi-Fi товчийг дарж принтерийн алдааг зассаны дараа, нэвтрэх цэгийг дахин эхлүүлж, принтертэй ойр байрлуулан дахин оролдоно.Хэрэв ажиллахгүй бол сүлжээний холболтын тайланг хэвлэж шийдлийг шалгана уу.



Холбогдох мэдээлэл

➡ 25 хуудас дээрх "Сүлжээний холболтын төлөвийг шалгах"

➡ 122 хуудас дээрх "Сүлжээний тохиргоо хийж чадахгүй бол"

PIN код оруулж Wi-Fi тохиргоог хийх (WPS)

Та сүлжээний төлөвийн хуудсан дээр хэвлэгдсэн PIN кодыг ашигласнаар нэвтрэх цэгтэй холбогдох боломжтой.Нэвтрэх цэг нь WPS (Wi-Fi-н хамгаалалттай тохиргоо)-ийн чадавхитай бол та энэхүү аргыг тохиргоо хийхэд ашиглаж болно.Нэвтрэх цэгт PIN кодыг оруулахдаа компьютер ашиглана уу.

1. Цаасаа ачаална.

2. Принтер дээрх товчийг дор хаяж 10 секунд удаан дар.

   Сүлжээний төлөвийн хуудсыг хэвлэнэ.

   Тэмдэглэл:

   Хэрэв та товч дээр 10 секундаас бага дарвал сүлжээний холболтын тайлан хэвлэгдэнэ.PIN кодын мэдээллийг энэ тайлан дээр хэвлээгүй болохыг анхаарна уу.

3. Wi-Fi товчийг дарж байгаад, товчийг гэрэл ба гэрэл зэрэг анивчтал дарж барина.

4. Сүлжээний төлөвийн хуудасны багана [WPS-PIN Code]-н дээр хэвлэгдсэн PIN код (8 оронтой тоо)-ыг нэвтрэх цэгт 2 минутын дотор оруулахдаа компьютер ашиглана.

   Холболт үүсэхэд гэрэл асна.

   Тэмдэглэл:

   - *PIN код оруулах талаарх дэлгэрэнгүй мэдээллийг нэвтрэх цэгтэй цуг ирсэн баримт бичгээс үзнэ үү.*
   - *болон гэрэл зэрэг анивчиж байвал принтер нь холболтын алдааны төлөвтэй байна.Принтер дээрх Wi-Fi товчийг дарж принтерийн алдааг зассаны дараа, нэвтрэх цэгийг дахин эхлүүлж, принтертэй ойр байрлуулан дахин оролдоно.Хэрэв ажиллахгүй бол сүлжээний холболтын тайланг хэвлэж шийдлийг шалгана уу.*



Холбогдох мэдээлэл

➡ 31 хуудас дээрх "Сүлжээний төлөвийн хуудсыг хэвлэх"

➡ 25 хуудас дээрх "Сүлжээний холболтын төлөвийг шалгах"

➡ 122 хуудас дээрх "Сүлжээний тохиргоо хийж чадахгүй бол"

Wi-Fi Direct (Энгийн AP) холболтын тохиргоог хийх

Энэ арга нь нэвтрэх цэггүйгээр принтерийг төхөөрөмжүүдэд шууд холбохыг танд зөвшөөрнө.Принтер нь нэвтрэх цэгийн үүргийг гүйцэтгэдэг.

> ***Чухал:***
> *Wi-Fi Direct (Энгийн AP) холболтыг ашиглан ухаалаг төхөөрөмж болон компьютероосоо принтерт холбогдох үед принтер нь ухаалаг төхөөрөмж болон компьютерийн адил Wi-Fi сүлжээ (SSID)-д холбогдсон бол тэдний хооронд холбоо үүснэ.Принтер унтарсанаас хойш компьютер болон ухаалаг төхөөрөмж нь автоматаар бусад боломжит Wi-Fi сүлжээнд холбогддог ч принтерийг хэрэв асаавал Wi-Fi нь дахин өмнөх сүлжээндээ холбогддоггүй.Компьютер болон ухаалаг төхөөрмжөөсөө Wi-Fi Direct (Энгийн AP) холболтонд зориулсан принтерийн SSID-д дахин холбогдоно.Хэрэв та байнга принтерээ асааж унтраахыг хүсэхгүй байгаа бол бид танд Wi-Fi сүлжээ ашиглан нэвтрэх цэгүүдэд принтерээ холбохыг санал болгож байна.*

1. Wi-Fi товчийг дарж байгаад, товчийг гэрэл ба гэрэл зэрэг анивчтал дарж барина.

   Үйлдэл дуустал хүлээнэ үү.

   Холболт үүсэхэд гэрэл асна.

2. Цаасаа ачаална.

3. Принтер дээрх товчийг дор хаяж 10 секунд удаан дар.

   Сүлжээний төлөвийн хуудсыг хэвлэнэ.Та Wi-Fi Direct (Simple AP)-н нууц үг болон SSID-гаа энэ хуудаснаас шалгаж болно.

   Тэмдэглэл:

   Хэрэв та товч дээр 10 секундаас бага дарвал сүлжээний холболтын тайлан хэвлэгдэнэ.Wi-Fi Direct (Simple AP)-н нууц үг болон SSID нь энэ тайлан дээр хэвлэгдээгүй болохыг анхаарна уу.

4. Компьютерийн сүлжээний холболтын дэлгэц эсвэл ухаалаг төхөөрөмжийн Wi-Fi дэлгэц дээрээс сүлжээний төлөвийн хуудас дээр харуулсан SSID-г сонго.



5. Сүлжээний төлөвийн хуудсанд хэвлэгдсэн нууц үгийг компьютер эсвэл ухаалаг төхөөрөмжиндөө оруулна.

   Та Wi-Fi Direct-н төлөвийг сүлжээний төлөвийн хуудас дээр баталгаажуулна.

Тэмдэглэл:
Та ухаалаг төхөөрөмжөөс Wi-Fi Direct холболтыг ашиглан холбогдох үед (Андройдод)

Та Андройдын төхөөрөмжөөр Wi-Fi Direct-г ашиглан принтерт холбогдох үед принтер дээр *гэрэл болон* *гэрэл зэрэг асах болно.*

Холболтын хүсэлтийг хүлээн авах бол Wi-Fi *товчийг дар.*

Холболтын хүсэлийг үл хүлээн авах бол *товчийг дар.*

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах цахим хуудасны Зөвлөмжүүд хэсгийг харна уу.

http://epson.sn > ***Дэмжлэг***

Холбогдох мэдээлэл

➡ 31 хуудас дээрх "Сүлжээний төлөвийн хуудсыг хэвлэх"

➡ 25 хуудас дээрх "Сүлжээний гэрлийг ашиган сүлжээний төлөвийг шалгах"

➡ 124 хуудас дээрх "Утасгүй интернэтийн (Энгийн AP) шууд холболтыг ашиглан холбогдохгүй байгаа бол"

Сүлжээний холболтын төлөвийг шалгах

Сүлжээний гэрлийг ашиган сүлжээний төлөвийг шалгах

Принтерийн хянах самбар дээр байгаа сүлжээний гэрлийг ашиглан сүлжээний холболтын төлөвөө шалгах боломжтой.

Холбогдох мэдээлэл

➡ 17 хуудас дээрх "Хяналтын самбар"

Сүлжээний холболтын тайланг хэвлэх

Та хэвлэгч ба нэвтрэх цэг хоорондын төлөвийг шалгахын тулд сүлжээний холболтын тайланг хэвлэх боломжтой.

1. Цаасаа ачаална.
2. товчийг дарна.

   Сүлжээний холболтын тайлан хэвлэгдэнэ.

Холбогдох мэдээлэл

➡ 26 хуудас дээрх "Сүлжээний холболтын тайлан дахь мессеж болон гарцууд"

Сүлжээний холболтын тайлан дахь мессеж болон гарцууд

Сүлжээний холболтын тайланд гарч буй мессежүүд болон алдаа заалтуудыг харан алдааг шийдвэрлэх гарцыг дагах.



a. Алдааны код

b. Сүлжээний орчин дахь мэдээлэл

Холбогдох мэдээлэл

➡ 27 хуудас дээрх “E-1”
➡ 27 хуудас дээрх “E-2, E-3, E-7”
➡ 28 хуудас дээрх “E-5”
➡ 28 хуудас дээрх “E-6”
➡ 29 хуудас дээрх “E-8”
➡ 29 хуудас дээрх “E-9”
➡ 29 хуудас дээрх “E-10”
➡ 30 хуудас дээрх “E-11”
➡ 30 хуудас дээрх “E-12”
➡ 31 хуудас дээрх “E-13”
➡ 31 хуудас дээрх “Сүлжээний орчин дахь мэдээлэл”

Сүлжээний тохиргоо

E-1

Мэдээлэл:

Confirm that the network cable is connected and network devices such as hub, router, or access point are turned on.

Шийдэл:

- ❏ Ethernet кабель нь таны принтер, төв, бусад төхөөрөмжтэй найдвартай холбогдсон эсэхийг шалгах.
- ❏ Таны төв эсвэл бусад сүлжээний төхөөрөмж асаалттай байгаа эсэхийг шалгах.
- ❏ Хэрэв та принтерийг Wi-Fi-аар холбохыг хүсэж байвал идэвхгүй болсон Wi-Fi тохируулгыг принтерт хий.

E-2, E-3, E-7

Мэдээлэл:

No wireless network names (SSID) found. Confirm that the router/access point is turned on and the wireless network (SSID) is set up correctly. Contact your network administrator for assistance.

No wireless network names (SSID) found. Confirm that the wireless network name (SSID) of the PC you wish to connect is set up correctly. Contact your network administrator for assistance.

Entered security key/password does not match the one set for your router/access point. Confirm security key/password. Contact your network administrator for assistance.

Шийдэл:

- ❏ Нэвтрэх цэгийг асаалттай байгаа эсэхийг шалгах.
- ❏ Компьютер болон төхөөрөмж нэвтрэх цэгтэй зөв холбогдсон эсэхийг нягтлах.
- ❏ Хандах цэгийг унтраана. 10 секунд хүлээгээд, дараа нь асаана.
- ❏ Принтерийг хандах цэгтэйгээ ойр байрлуулж, хооронд байрлах саадыг зайлуулна.
- ❏ Хэрвээ SSID-г гараар оруулсан бол зөв оруулсан эсэхээ шалгаарай. Сүлжээний холболтын тайлангийн **Network Status** хэсгээс SSID-г шалгаарай.
- ❏ Хэрвээ нэвтрэх цэг нь хэд хэдэн SSID-тай бол гарч ирсэн SSID-г сонго. Хэрэв SSID нь нийцэлгүй давтамж ашиглаж байгаа бол тэдгээрийг принтер автоматаар харуулахгүй.
- ❏ Сүлжээний холболт хийхдээ даралтат товчлуурын тохиргоо ашиглаж байгаа бол, таны хандалтын цэг нь WPS-г дэмждэг эсэхийг шалгана. Таны хандалтын цэг WPS-г дэмждэггүй бол та даралтат товчлуурын тохиргоо ашиглаж чадахгүй.
- ❏ Таны SSID нь зөвхөн ASCII тэмдэгт хэрэглэдэг эсэхийг шалгана (тоо, үсэг болон бусад ялгах тэмдэгтүүд). ASCII бус тэмдэгт агуулсан SSID-г принтер харуулж чаддаггүй.
- ❏ Нэвтрэх цэгтэй холбогдохын өмнө SSID болон нууц үгээ нягтал. Хэрэв та өөрийн өгөгдмөл тохиргоотой нэвтрэх цэгийг ашиглах гэж байгаа бол нэвтрэх цэг дээрх шошгон дээр байгаа SSID болон нууц үгийг ашигла. Хэрэв та SSID болон нууц үгийг мэдэхгүй бол нэвтрэх цэгийг тохируулдаг хүнтэй холбогдох эсвэл нэвтрэх цэгт өгөгдсөн бичиг баримтыг хараарай.
- ❏ Ухаалаг төхөөрөмжийн тетеринг функцээс үүсгэсэн SSID-тай холбогдож байгаа бол ухаалаг төхөөрөмжтэй дагалдан ирдэг гарын авлагаас SSID болон нууц үгийг шалга.

Сүлжээний тохиргоо

❏ Таны Wi-Fi холболт гэнэт салбал, доорх нөхцлийг шалгана. Эдгээр нөхцлийн аль нэг нь хамаарч байвал, дараах вэбсайтаас програм хангамж татаж, ажиллуулах замаар сүлжээний тохиргоогоо дахин сэргээнэ.

http://epson.sn > **Тохируулга**

❏ Түлхэх товчний тохиргоо ашиглан сүлжээнд дахин нэг ухаалаг төхөөрөмж нэмэгдлээ.

❏ Wi-Fi сүлжээг түлхэх товчний тохиргооноос өөр тохиргоогоор тохируулсан.

E-5

Мэдээлэл:

Security mode (e.g. WEP, WPA) does not match the current setting of the printer. Confirm security mode. Contact your network administrator for assistance.

Шийдэл:

Нэвтрэх цэгийн хамгаалалтын хэлбэр нь доорх тохиргоонуудын аль нэг нь байгаа эсэхийг шалга.Хэрвээ тийм биш бол хамгаалалтын хэлбэрээ нэвтрэх цэг дээрээ өөрчлөн, принтерийн сүлжээний тохиргоог дахин сэргээх шаардлагатай.

❏ WEP-64 бит (40 бит)

❏ WEP-128 бит (104 бит)

❏ WPA PSK (TKIP/AES)*

❏ WPA2 PSK (TKIP/AES)*

❏ WPA (TKIP/AES)

❏ WPA2 (TKIP/AES)

* WPA PSK-г мөн Хувийн WPA гэдэг.WPA2 PSK-г мөн Хувийн WPA2 гэдэг.

E-6

Мэдээлэл:

MAC address of your printer may be filtered. Check whether your router/access point has restrictions such as MAC address filtering. See the documentation of the router/access point or contact your network administrator for assistance.

Шийдэл:

❏ MAC хаяг шүүгч нь идэвхгүй байгаа эсэхийг шалга.Хэрвээ идэвхтэй байвал принтерийн MAC хаягийг бүртгүүлж шүүлтийг болиул.Дэлгэрэнгүй мэдээллийг нэвтрэх цэгтэй хамт ирсэн баримт бичгийг үзнэ үү.MAC хаягийг сүлжээ холболтын тайлангийн **Network Status** хэсгээс шалгах боломжтой.

❏ Хэрвээ нэвтрэх цэгийн дундын баталгаажуулалт нь WEP -ын хамгаалалтын хэлбэрт идэвхжсэн бол баталгаажуулах түлхүүр болон индекс нь зөв байгаа эсэхийг шалга.

❏ Хэрвээ нэвтрэх цэг дээрх холбож болох төхөөрөмжийн тоо таны холбохыг хүссэн сүлжээний төхөөрөмжийн тооноос бага байвал, холбож болох төхөөрөмжийг тоог өсгөхийн тулд нэвтрэх цэг дээр тохиргоо хийнэ үү.Тохиргоо хийхийн тулд нэвтрэх цэгтэй хамт ирсэн баримт бичгийг үзнэ үү.

Сүлжээний тохиргоо

E-8

Мэдээлэл:

Incorrect IP address is assigned to the printer. Confirm IP address setup of the network device (hub, router, or access point). Contact your network administrator for assistance.

Шийдэл:

- ❏ Принтерийн IP хаягийн тохиргоог **Автоматаар** тохируулсан бол нэвтрэх цэг дээр DHCP-г идэвхжүүл.
- ❏ Хэрвээ принтерийн IP хаягийн тохиргоог гараар тохируулсан бол, тааруулсан IP хаяг нь зохих хэмжээнээс илүү гарч хүчингүй (жишээ нь: 0.0.0.0) болсон байдаг.Принтерийн хянах самбараас эсвэл Web Config ашиглаж зөв IP хаягийг тохируул.

E-9

Мэдээлэл:

Confirm the connection and network setup of the PC or other device. Connection using the EpsonNet Setup is available. Contact your network administrator for assistance.

Шийдэл:

Дараахыг шалгах.

- ❏ Төхөөрөмжүүд асаалттай байна.
- ❏ Принтертэй холбохыг хүссэн төхөөрөмжүүдээсээ нэг сүлжээгээр интернэт, бусад компьютер болон сүлжээний төхөөрөмжүүдтэй холбогдох боломжтой.

Принтер, сүлжээний төхөөрөмжөө холбоогүй бол, дээрхийг нягталсны дараа хандах цэгийг унтраана.10 секунд хүлээгээд, дараа нь асаана.Дараа нь, дараах вэбсайтаас суулгагч татаж, ажиллуулах замаар сүлжээний тохиргоогоо дахин сэргээнэ.

http://epson.sn > **Тохируулга**

E-10

Мэдээлэл:

Confirm IP address, subnet mask, and default gateway setup. Connection using the EpsonNet Setup is available. Contact your network administrator for assistance.

Шийдэл:

Дараахыг шалгах.

- ❏ Сүлжээн дээрх бусад төхөөрөмж асаалттай байна.
- ❏ Хэрвээ принтерийн IP хаягийг механикаар авахаар тааруулсан бол сүлжээний хаягууд (IP хаяг, дэд нэтийн маск, өгөгдмөл гарц) зөв гэсэн үг.

Хэрвээ эдгээр нь буруу бол сүлжээний хаягаа шинээр тохируул.Та сүлжээний холболтын тайлан дээрх **Network Status** хэсгээс IP хаяг, дэд нэт маск, өгөгдмөл гарцыг шалгах боломжтой.

Сүлжээний тохиргоо

Хэрэв DHCP-г идэвхжүүлсэн бол, принтерийн IP хаягийн тохиргоог **Автоматаар** авахаар өөрчил.Хэрвээ IP хаягийг механик аргаар үүсгэхийг хүсвэл сүлжээ холболтын тайлангийн **Network Status** хэсгээс принтерийн IP хаягийг шалгаж сүлжээний тохиргооны дэлгэцнээс гар аргаар оруулах гэсэн өгөгдлийг сонго.Дэд нэтийн маскыг [255.255.255.0] болгон тохируул.

Принтер, сүлжээний төхөөрөмжөө холбоогүй бол, хандах цэгийг унтраана.10 секунд хүлээгээд, дараа нь асаана.

E-11

Мэдээлэл:

Setup is incomplete. Confirm default gateway setup. Connection using the EpsonNet Setup is available. Contact your network administrator for assistance.

Шийдэл:

Дараахыг шалгах.

- ❏ Принтерийн TCP/IP тохируулгын тохиргоог гараар тохируулсан бол өгөгдмөл гарцын хаяг нь зөв байна.
- ❏ Өгөгдмөл гарцаар тохируулсан төхөөрөмж асаалттай байна.

Зөв өгөгдмөл гарцын хаягийг тохируул.Та принтерийн өгөгдмөл гарцын хаягийг сүлжээний холболтын тайлан дээрх **Network Status** хэсгээс шалгах боломжтой.

E-12

Мэдээлэл:

Confirm the following -Entered security key/password is correct -Index of the security key/password is set to the first number -IP address, subnet mask, or default gateway setup is correct Contact your network administrator for assistance.

Шийдэл:

Дараахыг шалгах.

- ❏ Сүлжээн дээрх бусад төхөөрөмж асаалттай байна.
- ❏ Гараар оруулж байгаа бол сүлжээний хаяг (IP хаяг, дэд нэт маск, өгөгдмөл гарц) зөв байна.
- ❏ Бусад төхөөрөмжийн сүлжээний хаягууд (дэд нэт маск ба өгөгдмөл гарц) нь мөн адилхан.
- ❏ Энэ IP хаяг бусад төхөөрөмжтэй зөрчилгүй байна.

Принтер, сүлжээний төхөөрөмжөө холбоогүй бол, дээрхийг нягталсны дараа дараахыг хийж үз.

- ❏ Хандах цэгийг унтраана.10 секунд хүлээгээд, дараа нь асаана.
- ❏ Суулгагч ашиглан сүлжээний тохиргоог дахин хийнэ.Та дараах вэбсайтаас үүнийг ажиллуулах боломжтой.

  http://epson.sn > **Тохируулга**
- ❏ WEP хамгаалалтын хэлбэрийг хэрэглэдэг нэвтрэх цэг дээр хэд хэдэн нууц үгийг бүртгүүлэх боломжтой.Хэрвээ нэгээс дээш нууц үг бүртгүүлсэн бол эхний нууц үг нь принтер дээр тохируулсан эсэхийг шалга.

E-13

Мэдээлэл:

Confirm the following -Entered security key/password is correct -Index of the security key/password is set to the first number -Connection and network setup of the PC or other device is correct Contact your network administrator for assistance.

Шийдэл:

Дараахыг шалгах.

❏ Сүлжээний төхөөрөмжүүд болох нэвтрэх цэг, төв болон роутер нь асаалттай байна.

❏ Сүлжээний төхөөрөмжүүдийн TCP/IP тохиргоонуудийг механик аргаар тохируулаагүй.(Бусад сүлжээний TCP/IP тохиргоо нь гар аргаар харин принтерийн TCP/IP тохиргоо нь автомат байвал принтерийн сүлжээ нь бусад төхөөрөмжүүдийн сүлжээнээс өөр байх магадлалтай.)

Дээрхийг шалгаад ч ажиллахгүй бол дараах үйлдлүүдийг хийгээрэй.

❏ Хандах цэгийг унтраана.10 секунд хүлээгээд, дараа нь асаана.

❏ Суулгагчийг ашиглан принтер болон компьютер хоёрын сүлжээний тохиргоог ижил болго.Та дараах вэбсайтаас үүнийг ажиллуулах боломжтой.

http://epson.sn > **Тохируулга**

❏ WEP хамгаалалтын хэлбэрийг хэрэглэдэг нэвтрэх цэг дээр хэд хэдэн нууц үгийг бүртгүүлэх боломжтой.Хэрвээ нэгээс дээш нууц үг бүртгүүлсэн бол эхний нууц үг нь принтер дээр тохируулсан эсэхийг шалга.

Сүлжээний орчин дахь мэдээлэл

Мэдээлэл	Шийдэл
*Multiple network names (SSID) that match your entered network name (SSID) have been detected. Confirm network name (SSID).	Нэг ижил SSID нь олон нэвтрэх цэг дээр тохируулсан байх магадлалтай. Тиймээс, нэвтрэх цэгээ шалгаад SSID-г өөрчил.
The Wi-Fi environment needs to be improved. Turn the wireless router off and then turn it on. If the connection does not improve, see the documentation for the wireless router.	Принтерээ нэвтрэх цэгтэй ойр байрлуулан, аливаа саадыг үгүй болгосны дараа нэвтрэх цэгээ унтраагаарай. 10 секунд хүлээгээд, дараа нь асаана. Хэрвээ холбогдохгүй бол нэвтрэх цэгтэй хамт дагалдан ирдэг гарын авлагыг хараарай.
*No more devices can be connected. Disconnect one of the connected devices if you want to add another one.	Нэгэн зэрэг холбогдож болох компьютер ба ухаалаг төхөөрөмж нь Wi-Fi Direct (Энгийн AP) холболтдо бүрэн холбогдсон. Дахин өөр компьютер эсвэл ухаалаг төхөөрөмж нэмэхийн тулд холбоотой байгаа аль нэг төхөөрөмжөө эхлээд салга. Та нэгэн зэрэг холбогдож болох утасгүй төхөөрөмжийн тоо болон холбогдсон төхөөрөмжийн тоог сүлжээний төлвийн хуудас эсвэл принтерийн хаянах самбарыг шалган баталгаажуул.

Сүлжээний төлөвийн хуудсыг хэвлэх

Та үүнийг хэвлэж нарийн сүлжээний мэдээллийг шалгах боломжтой.

Сүлжээний тохиргоо

1. Цаасаа ачаална.
2. Принтерийн хянах самбар дээрх товчийг дарж дор хаяж 10 секунд барина.

   Сүлжээний төлөвийн хуудсыг хэвлэнэ.

   Тэмдэглэл:

   Хэрэв та товч дээр 10 секундаас бага дарвал сүлжээний холболтын тайлан хэвлэгдэнэ.

Шинэ нэвтрэх цэгийг солих, нэмэх

Нэвтрэх цэгийг сольсон, эсвэл нэвтрэх цэгийг нэмсэн, шинэ сүлжээний орчинг нэмснээс болж SSID өөрчлөгдсөн бол, Wi-Fi тохиргоогоо дахин тохируулна.

Холбогдох мэдээлэл

➡ 32 хуудас дээрх “Компьютерт холбох аргыг өөрчлөх”

Компьютерт холбох аргыг өөрчлөх

Суулгагчийг ашиглан өөр холболтын аргыг шинээр тохируул.

❏ Вэбсайтаас тохируулах

Дараах вэбсайтаас нэвтэрч бүтээгдэхүүний нэрээ оруулна уу.**Тохируулга** орж, дараа нь суурилуулж эхэл.

http://epson.sn

❏ Программ хангамжийн диск ашиглан суулгах (зөвхөн диск драйвтай компьютертой хэрэглэгч болон програм хангамжийн дисктэй загваруудад зориулагдсан)

Компьютерт программ хангамжийн дискийг оруулаад дэлгэцэн дээрх зааварчилгааг дага.

Холболтын аргуудын өөрчлөлтийг сонгох

Дараах дэлгэц гарч иртэл дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Холболтын аргыг өөрчлөх буюу дахин тохируулах-г Програм Суулгалтыг Сонгох дэлгэц дээр сонгож **Дараах** товш.



Принтерийн хянах самбараас Сүлжээний тохиргоог сэргээх

Та сүлжээний бүх тохиргоог үндсэн хэлбэрт нь буцааж сэргээх боломжтой.

1. Принтерийг унтраана.
2. товчийг дарж байгаад, товчийг гэрэл ба гэрэл зэрэг анивчтал дарж барина. гэрэл болон гэрэл унтарвал сэргээлт амжилттай болно.

Цаас ачаалах

Цаас ашиглахтай холбоотой анхааруулга

❏ Цаастай цуг ирэх зааврын хуудсыг унших.

❏ Ачаалахаас өмнө цаасны өнцгийг имэрч эгнүүлэх. Фото цаасыг имэрч нугалж болохгүй. Тэгсэн тохиолдолд цаасны хэвлэх талд гэмтэл учруулна.



❏ Хэрэв цаас нугаларсан бол ачаалахаас өмнө түүнийг тэнийлгэж, эсрэг талаар нь бага зэргээр нугална. Нугаларсан цаасан дээр хэвлэх нь хэвлэх үед цаасыг бөглөрөх, бохирдоход хүргэнэ.

❏ Үрчийсэн, урагдсан, зүссэн, нугалсан, чийгтэй хэт зузаан, эсвэл хэт нимгэн наалт наасан цаасыг ашиглахгүй. Эдгээр төрлийн цаасыг ашигласнаас цаас бөглөрөх, хэвлэмэл материал бохирдоход хүргэнэ.

❏ Ачаалахаас өмнө дугтуйн өнцгийг имэрч эгнүүлэх. Давхарласан дугтуйн дотор зай орсон бол, ачаалахаас өмнө тэдгээрийг доош нь дарж агаарыг гаргана.



❏ Үрчийсэн, эсвэл нугаларсан дугтуйг ашиглахгүй. Эдгээр дугтуйг ашигласнаас цаас бөглөрөх, хэвлэмэл материал бохирдоход хүргэнэ.

❏ Дугтуй, нэвт харагддаг дугтуйн дээрх наалдамтгай гадаргуутай дугтуйг ашиглахгүй.

❏ Хэт нимгэн дугтуй нь хэвлэх явцад нугаларах магадлалтай тул ашиглахаас зайлсхийх.

Холбогдох мэдээлэл

➡ 141 хуудас дээрх “Принтерийн үзүүлэлт”

Бэлэн байгаа цаас ба багтаамж

Өндөр чанартай хэвлэлтийг гаргахын тулд жинхэнэ Epson цаасыг ашиглахыг Epson зөвлөж байна. Хянах самбараас хэвлэх боломжтой цаасны хэмжээ нь A4, цаасны төрөл нь ердийн цаас.

Жинхэнэ Epson цаас

Хэрэгслийн Нэр	Хэмжээ	Ачаалах Багтаамж (Хуудас)	Гар аргаар 2 талд нь хэвлэх	Хүрээгүй хэвлэх
Epson Bright White Ink Jet Paper	A4	40*	✓	–
Epson Ultra Glossy Photo Paper	A4, 13×18 см (5×7 инч), 10×15 см (4×6 инч)	10	–	✓
Epson Premium Glossy Photo Paper	A4, 13×18 см (5×7 инч), 16:9 өргөн хэмжээтэй (102×181 мм), 10×15 см (4×6 инч)	10	–	✓
Epson Premium Semigloss Photo Paper	A4, 10×15 см (4×6 инч)	10	–	✓
Epson Photo Paper Glossy	A4, 13×18 см (5×7 инч), 10×15 см (4×6 инч)	10	–	✓
Epson Matte Paper-Heavyweight	A4	20	–	✓
Epson Photo Quality Ink Jet Paper	A4	40	–	–

* Гар аргаар 2-талтай хэвлэхэд, нэг талд нь аль хэдийн хэвлэсэн 15 хүртэлх хуудсыг ачаалах боломжтой.

Тэмдэглэл:
Цаасны олдоц байрлалаас шалтгаалж ялгаатай байна. Өөрийн бүсийн цаасны олдцын талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээллийг авахын тулд Epson тусламж үйлчилгээтэй холбоо барина уу.

Худалдаанд бэлэн байгаа цаас

Хэрэгслийн Нэр	Хэмжээ	Ачаалах Багтаамж (Хуудасны тоо)	Гар аргаар 2 талд нь хэвлэх	Хүрээгүй хэвлэх
Ердийн цаас*1	Захидал, A4, B5, A5, A6	Ирмэг заагч дээрх гурвалжин тэмдгийн заасан шугам хүртэл.*2	✓	–
	Legal	1		
	Хэрэглэгчийн Тодорхойлсон			

Цаас ачаалах

Хэрэгслийн Нэр	Хэмжээ	Ачаалах Багтаамж (Хуудасны тоо)	Гар аргаар 2 талд нь хэвлэх	Хүрээгүй хэвлэх
Дугтуй	Дугтуй #10, Дугтуй DL, Дугтуй C6	5	–	–

*1 Урьдчилан цоолсон цаасны ачаалах чадамж нэг хуудас.

*2 Гар аргаар 2-талтай хэвлэхэд, нэг талд нь аль хэдийн хэвлэсэн 15 хүртэлх хуудсыг ачаалах боломжтой.

Холбогдох мэдээлэл

➡ 149 хуудас дээрх “Техник туслалцааны вэбсайт”

Цаасны төрлийн жагсаалт

Хамгийн шилдэг хэвлэмэл материалыг гаргахын тулд цаасанд тохирсон цаасны төрлийг сонгоно.

Хэрэгслийн Нэр	Хэрэгслийн төрөл*2
Epson Bright White Ink Jet Paper*1	Ердийн цаас
Epson Ultra Glossy Photo Paper*1	Epson Ultra Glossy
Epson Premium Glossy Photo Paper*1	Epson Premium Glossy
Epson Premium Semigloss Photo Paper*1	Epson Premium Semigloss
Epson Photo Paper Glossy*1	Photo Paper Glossy
Epson Matte Paper-Heavyweight*1	Epson Matte
Epson Photo Quality Ink Jet Paper*1	Epson Matte
Ердийн цаас*1	Ердийн цаас
Дугтуй	Дугтуй

*1 Принтерийн драйвераар хэвлэх үед эдгээр цаасны төрөл нь Exif Print ба PRINT Image Matching-тай тохирсон байдаг. Дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд Exif Print ба PRINT Image Matching-тай тохирох дижитал зургийн аппараттай цуг ирэх баримт бичгийг үзнэ.

*2 Ухаалаг төхөөрөмжийн хувьд Epson iPrint-г ашиглаж хэвлэх үед эдгээр хэрэгслийн төрлийг сонгож болно.

Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах

1. Тэжээлийн хаалтыг нээж, цаасны тулгуурыг сунгаж, буцаан эргүүлнэ.



2. Төгсгөлийн чиглүүлэгчийг зүүн тийш нь гулгуулна.



3. Хэвлэх талыг дээш нь харуулж арын цаасны дайз-н баруун талын хажуугаар цаасыг ачаална.



> ***Чухал:***
>
> *Цаасанд тогтоосон хуудасны дээд тооноос илүүг ачаалахгүй байх. Ердийн цаасны тухайд, хүрээний чиглүүлэгч дээрх гурвалжин тэмдгээр харуулсан шугамаас дээш гаргаж ачаалахгүй байх.*

Цаас ачаалах

❏ Дугтуй



❏ Урьдчилан цоолсон цаас



Тэмдэглэл:

❏ *Дээд, доод цоолсон нүхийг холбохгүйгээр нэг хуудас цаасыг ачаална.*

❏ *Цоолсон нүхэн дээгүүр хэвлэхээс сэргийлж файлынхаа хэвлэх байрлалыг тохируулна.*

4. Хүрээний тохиргоог цаасны өнцөг хүртэл гулсуулах ба улмаар тэжээлийн хаалтыг хаана.



Цаас ачаалах

5. Хэвлэх тавцанг гулсуулна.



Тэмдэглэл:
Улдсэн цаасыг боодолд нь эргүүлж хийнэ. Та цаасыг принтер дээр үлдээвэл, цаас үрчийж, эсвэл хэвлэлийн чанар буурч магадгүй.

Холбогдох мэдээлэл

➡ 34 хуудас дээрх “Цаас ашиглахтай холбоотой анхааруулга”

➡ 35 хуудас дээрх “Бэлэн байгаа цаас ба багтаамж”

Сканнерын Шил дээр эх хувийг байрлуулах

> ***Чухал:***
> *Ном зэрэг том оврын эх хувийг байрлуулахдаа сканнерын шил дээр гадны гэрэл шууд тусахаас сэргийлнэ.*

1. Баримтын тагийг нээнэ.



2. сканнерын шил дээрх аливаа тоос, толбыг арилгана.

3. Эх хувийн нүүрийг доош харуулж, өнцгийн тэмдэг рүү шахаж тавина.



Тэмдэглэл:
сканнерын шил-н доод эсвэл баруун ирмэгээс 1.5 мм-н зайд буй хэсгийг сканнердахгүй.

4. Тагийг зөөлөн хаана уу.

> ***Чухал:***
> *сканнерын шил эсвэл бичиг баримтын гадар дээр хэт дарж болохгүй.Эс бөгөөс тухайн зүйлс гэмтэж болно.*

5. Сканнердсаны дараа эх хувийг арилгана уу.

Тэмдэглэл:
Эх хувийг сканнерын шил дээр удаан хугацаагаар байлгавал, тэдгээр нь шилний гадаргуутай наалдах аюултай.

Нэгэн зэрэг олон зургийг сканнердахаар тавих

Та **Фото Горим**-г Epson Scan 2-с ашиглан нэгэн зэрэг олон зураг сканнердан хадгалах боломжтой. Зургуудыг сканнерын шил-н хэвтээ болон босоо захаас 4.5 мм зайд байрлуулж, бие биеэсээ доод тал нь 20 мм зайд байрлуул. Зургууд нь 15×15 мм-ээс том байх хэрэгтэй.

Тэмдэглэл:
*Урьдчилан харах цонхны дээд талд байрлах **Жижиг зураг** чагтыг идэвхжүүл.*



Хэвлэх

Компьютероос хэвлэх

Принтерийн үндсэн мэдээлэл — Windows

Тэмдэглэл:

- ❏ *Тохиргооны хэсгүүдийн тайлбарыг онлайн тусламжаас харна уу. Тухайн хэсэг дээр хулганы баруун товчоор дарж, **Тусламж**-г дарна.*
- ❏ *Програмаас шалтгаалж үйлдлүүд нь ялгаатай байна. Дэлгэрэнгүй мэдээллийг програмын тусламжаас үзнэ үү.*

1. Принтерт цаасыг ачаал.
2. Хэвлэхийг хүссэн файлаа нээ.
3. **Хэвлэх** эсвэл **Хэвлэх Тохируулга**-г **Файл** цэснээс сонгоно.
4. Принтерээ сонгоно.
5. Принтерийн драйверын цонход хандахын тулд **Тохируулгууд** эсвэл **Шинж чанар**-г сонгоно уу.



6. Дараах тохиргоог хийнэ үү.
   - ❏ Баримтын Хэмжээ: Принтерт ачаалсан цаасны хэмжээгээ сонгоно.

- ❏ Хүрээгүй: Зургийн эргэн тойрон хүрээгүй хэвлэх бол сонгоно уу.

  Хүрээгүй хэвлэх үед хэвлэх өгөгдөл цаасны хэмжээнээс бага зэрэг томрох тул, цаасны ирмэг дагуу ямар ч хүрээ хэвлэгдэхгүй. **Тохиргоо** дээр дарж томруулах хэмжээг сонгоно.
- ❏ Чиг: Программ хангамжид тохируулсан чиглэлээ сонгоно уу.
- ❏ Цаасны Төрөл: Ачаалсан цаасны төрлөө сонгоно уу.
- ❏ Чанар: Принтерийн чанарыг сонгоно уу.

  Өндөр гэснийг сонгох нь илүү өндөр чанараар хэвлэх боловч, хэвлэх хурд удаан байж магадгүй.
- ❏ Өнгө: Хар, эсвэл саарал сүүдэр дээр хэвлэхийг хүсэж байгаа бол **Грейскейл**-г сонгоно уу.

Тэмдэглэл:
*Дуплексийн дээр хэвлэх үед, **Хэвтээ**-г **Чиг** тохиргоо болгож сонгоно уу.*

7. **OK** товчийг дарж принтерийн драйверын цонхыг хаана.
8. **Хэвлэх** товчийг дар.

Холбогдох мэдээлэл

➡ 35 хуудас дээрх “Бэлэн байгаа цаас ба багтаамж”
➡ 37 хуудас дээрх “Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах”
➡ 99 хуудас дээрх “Windows принтерийн драйверын заавар”
➡ 36 хуудас дээрх “Цаасны төрлийн жагсаалт”

Хэвлэх үндсэн алхмууд Mac OS

Тэмдэглэл:
Энэ хэсгийн тайлбарт TextEdit-ийг жишээ болгон хэрэглэсэн.Програмаас шалтгаалж үйлдлүүд болон дэлгэцний байдал нь ялгаатай байна.Дэлгэрэнгүй мэдээллийг програмын тусламжаас үзнэ үү.

1. Принтерт цаасыг ачаал.
2. Хэвлэхийг хүссэн файлаа нээ.

Хэвлэх

3. Хэвлэх харилцах цонход хандахын тулд **Хэвлэх**-ийг **Файл** цэс буюу өөр бусад удирдлагаас сонго.

   Хэрэв шаардлагатай бол, **Дэлгэрэнгүйг Харуулах** эсвэл ▼-г дарж хэвлэх цонхыг томруулна.



4. Дараах тохиргоог хийнэ үү.
   - ❏ Принтер: Принтерээ сонгоно.
   - ❏ Урьдчилсан тохиргоо: Бүртгэлтэй тохиргоог ашиглахыг хүсэж байвал сонгоно.
   - ❏ Цаасны Хэмжээ: Принтерт ачаалсан цаасны хэмжээгээ сонгоно.

     Хүрээгүй хэвлэх үед, "хүрээгүй" цаасны хэмжээг сонгоно.
   - ❏ Чиглэл: Программ хангамжид тохируулсан чиглэлээ сонгоно уу.

Тэмдэглэл:
- ❏ *Хэрэв дээрх тохиргооны цэснүүд харагдахгүй байвал,* ***Цаасны Тохируулга****-г* ***Файл*** *файл цэснээс сонгож тохиргоог хийнэ.*
- ❏ *Захидал хэвлэх үед, хөндлөн чиглэлийг сонгоно.*

5. Дэлгэгддэг цэснээс **Хэвлэх Тохиргоо**-г сонгоно.



Тэмдэглэл:
OS X Mountain Lion болон дараагийн хувилбаруудад, ***Хэвлэх Тохиргоо*** *цэс гарч ирэхгүй бол, Epson принтерийн драйвер зөв суулгагдаагүй байна гэсэн үг.*

Системийн Тохируулгууд*-г цэс >* ***Принтер & Сканнер*** *(эсвэл* ***Хэвлэх & Сканнердах****,* ***Хэвлэх & Факсдах****)-аас сонгож, принтерийг устгаад дахин нэмнэ.Принтер нэмэх зааврыг дараахаас харна уу.*

http://epson.sn

6. Дараах тохиргоог хийнэ үү.
   - ❏ Media Type: Ачаалсан цаасны төрлөө сонгоно уу.
   - ❏ Print Quality: Принтерийн чанарыг сонгоно уу.

     Нарийн гэснийг сонгох нь илүү өндөр чанараар хэвлэх боловч, хэвлэх хурд удаан байж магадгүй.
   - ❏ Тэлэлт: Хүрээгүй цаасны хэмжээг сонгосон үед ашиглах боломжтой.

     Хүрээгүй хэвлэх үед хэвлэх өгөгдөл цаасны хэмжээнээс бага зэрэг томрох тул, цаасны ирмэг дагуу ямар ч хүрээ хэвлэгдэхгүй.Томсгох хэмжээг сонгоно.
   - ❏ Грейскейл: Хар эсвэл саарал сүүдэр дээр хэвлэх үед сонгоно.

7. **Хэвлэх** товчийг дар.

Холбогдох мэдээлэл

➡ 35 хуудас дээрх "Бэлэн байгаа цаас ба багтаамж"

➡ 37 хуудас дээрх "Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах"
➡ 102 хуудас дээрх "Mac OS принтерийн драйверын заавар"
➡ 36 хуудас дээрх "Цаасны төрлийн жагсаалт"

Хоёр тал дээр хэвлэх (Windows-т зөвхөн)

Принтерийн драйвер сондгой, тэгш тоотой хуудсыг автоматаар ялгаж хэвлэдэг. Принтер сондгой тоотой хуудсыг хэвлэж дууссаны дараа, тэгш тоотой хуудсыг хэвлэхийн тулд дараах байдлаар хуудсыг эргүүлнэ үү. Хэвлэмэл материалыг нугалж хийдэг товхимолыг та мөн хэвлэж болно.



Тэмдэглэл:

- ❏ *Хүрээгүй хэвлэх дээр энэхүү тохиргоог ашиглах боломжгүй.*
- ❏ *Хоёр талд нь хэвлэхэд тохиромжтой цаасыг ашиглаагүй бол, хэвлэлийн чанар муудаж, цаасны бөглөрөл үүсэх боломжтой.*
- ❏ *Цаас болон мэдээллээс шалтгаалж, цаасны нөгөө талд бэх нэвчих магадлалтай.*
- ❏ ***EPSON Status Monitor 3**-г идэвхгүйжүүлсэн бол, принтерийн драйверт нэвтэрч, **Өргөтгөсөн Тохиргоо**-г **Арчилгаа** таб дээрээс сонгоод дараа нь **EPSON Status Monitor 3-г идэвхжүүл**-г сонгоно.*
- ❏ *Принтерт сүлжээгээр дамжиж ханддаг болон принтерийг хуваан хэрэглэдэг бол 2 талд нь хэвлэх боломжгүй болно.*

1. Принтер дээр цаас ачаалах.
2. Хэвлэхийг хүсэж буй файлаа нээнэ.
3. Принтерийн драйверийн цонхонд хандана.
4. **Гар аргаар (Урт-ирмэгээр үдэх)**, эсвэл **Гар аргаар (Богино-ирмэгээр үдэх)**-г **2-талт Хэвлэлт**-с **Үндсэн** таб дээрээс сонгоно.
5. **Тохиргоо** дарж зохих тохиргоог хийж, дараа нь **OK**-г дарна.

   Тэмдэглэл:
   *Товхимол болгож хэвлэх бол **Товхимол**-г сонгоно.*
6. Шаардлагатай бол **Үндсэн** болон **Илүү Сонголтууд** таб дээр бусад зүйлсийг тохируулж, дараа нь **OK** товчийг товшино.

7. **Хэвлэх** товчийг товшино.

   Эхний талыг хэвлэж дууссаны дараа, компьютер дээр дэлгэгддэг цонх гарч ирнэ. Дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Холбогдох мэдээлэл

➡ 35 хуудас дээрх "Бэлэн байгаа цаас ба багтаамж"

➡ 37 хуудас дээрх "Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах"

➡ 42 хуудас дээрх "Принтерийн үндсэн мэдээлэл — Windows"

Нэг хуудсан дээр хэд хэдэн хуудсыг хэвлэх

Та нэг хуудсан дээр 2 эсвэл 4 хуудас мэдээллийг хэвлэх боломжтой.



Нэг хуудсан дээр олон хуудас хэвлэх — Windows

Тэмдэглэл:
Хүрээгүй хэвлэх дээр энэхүү тохиргоог ашиглах боломжгүй.

1. Принтер дээр цаас ачаалах.
2. Хэвлэхийг хүсэж буй файлаа нээнэ.
3. Принтерийн драйверийн цонхонд хандана.
4. **2-дээшээ** эсвэл **4-дээшээ**-г **Олон-Хуудаст** тохиргоо болгож **Үндсэн** таб дээр сонгоно.
5. **Хуудасны Дараалал** дарж зохих тохиргоог хийж, дараа нь **OK**-г дарж цонхыг хаана.
6. Шаардлагатай бол **Үндсэн** болон **Илүү Сонголтууд** таб дээр бусад зүйлсийг тохируулж, дараа нь **OK** товчийг товшино.
7. **Хэвлэх** товчийг товшино.

Холбогдох мэдээлэл

➡ 37 хуудас дээрх “Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах”
➡ 42 хуудас дээрх “Принтерийн үндсэн мэдээлэл — Windows”

Нэг хуудсан дээр олон хуудас хэвлэх — Mac OS

1. Принтерт цаасыг ачаал.
2. Хэвлэхийг хүссэн файлаа нээ.
3. Принтерийн харилцах цонхонд хандана.
4. Дэлгэгддэг цэснээс **Загвар**-г сонгоно.
5. **Нүүрэн дээрх хуудас**-ны тоо, **Загварын чиглэл** (хуудасны дараалал), **Хүрээ**-г тохируулна.
6. Шаардлагатай бусад тохиргоог бас хийнэ.
7. **Хэвлэх** товчийг дар.

Холбогдох мэдээлэл

➡ 37 хуудас дээрх “Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах”
➡ 43 хуудас дээрх “Хэвлэх үндсэн алхмууд Mac OS”

Цаасны хэмжээнд тааруулж хэвлэх

Принтерт ачаалсан цаасныхаа хэмжээтэй тохируулж хэвлэх боломжтой.



Цаасны хэмжээнд тохируулж хэвлэх — Windows

Тэмдэглэл:
Хүрээгүй хэвлэх дээр энэхүү тохиргоог ашиглах боломжгүй.

1. Принтер дээр цаас ачаалах.
2. Хэвлэхийг хүсэж буй файлаа нээнэ.

3. Принтерийн драйверийн цонхонд хандана.
4. **Илүү Сонголтууд** таб дээрх дараах тохиргоог хийнэ.
   - ❑ Баримтын Хэмжээ: Программ хангамжид тохируулсан цаасны хэмжээгээ сонгоно.
   - ❑ Гаралтын Цаас: Принтерт ачаалсан цаасны хэмжээгээ сонгоно.

     Хуудсанд Тааруулах автоматаар сонгогдоно.

   Тэмдэглэл:
   *Та цаасны голд багасгасан зураг хэвлэхийг хүсэж байгаа бол **Төв** тохиргоог сонгоно.*
5. Шаардлагатай бол **Үндсэн** болон **Илүү Сонголтууд** таб дээр бусад зүйлсийг тохируулж, дараа нь **OK** товчийг товшино.
6. **Хэвлэх** товчийг товшино.

Холбогдох мэдээлэл

➡ 37 хуудас дээрх "Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах"
➡ 42 хуудас дээрх "Принтерийн үндсэн мэдээлэл — Windows"

Цаасны хэмжээнд тохируулж хэвлэх — Mac OS

1. Принтерт цаасыг ачаал.
2. Хэвлэхийг хүссэн файлаа нээ.
3. Принтерийн харилцах цонхонд хандана.
4. Программ хангамж дотор **Цаасны Хэмжээ** тохиргоонд сонгосон цаасны хэмжээгээ тохируулна.
5. Дэлгэгддэг цэснээс **Цаас ашиглах** тохиргоог сонгоно.
6. **Цаасны хэмжээнд тохируулах хэмжээ** тохиргоог сонгоно.
7. **Сонгосон цаасны хэмжээ** тохиргоо болгож принтерт ачаалсан цаасны хэмжээгээ сонгоно.
8. Шаардлагатай бусад тохиргоог бас хийнэ.
9. **Хэвлэх** товчийг дар.

Холбогдох мэдээлэл

➡ 37 хуудас дээрх "Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах"
➡ 43 хуудас дээрх "Хэвлэх үндсэн алхмууд Mac OS"

Олон тооны файлыг хамт хэвлэх (Windows-т зөвхөн)

Ажил Эмхлэгч Лайт нь өөр өөр программ хангамжийн тусламжтай бүтээсэн хэд хэдэн файлыг нэгтгэж нэг хэвлэх ажил болгон хэвлэх боломжийг олгоно. Та нэгтгэсэн файлын хувьд хэвлэх тохиргоо буюу загвар, хэвлэх дараалал, чиглэл зэргийг тодорхойлж болно.



1. Принтерт цаасыг ачаал.
2. Хэвлэхийг хүссэн файлаа нээ.
3. Принтерийн драйверийн цонхонд хандана.
4. **Ажил Эмхлэгч Лайт**-г **Үндсэн** таб дээрээс сонгоно.
5. **OK** товчийг дарж принтерийн драйверын цонхыг хаана.
6. **Хэвлэх** товчийг дар.

   Ажил Эмхлэгч Лайтцонх гарч ирэн, хэвлэх ажил **Прожектыг Хэвлэх** дээр нэмэгдэнэ.
7. **Ажил Эмхлэгч Лайт** цонх нээлттэй байхад, одоо ажиллаж буй файлтайгаа нэгтгэхийг хүсэж буй файлаа нээн, дээрх 3-6 алхмыг давтан хийнэ.

   Тэмдэглэл:
   - ❑ ***Ажил Эмхлэгч Лайт*** *цонхыг та хаасан бол,хадгалагдаагүй* ***Прожектыг Хэвлэх*** *устгагдана. Дараа нь хэвлэхийн тулд* ***Хадгалах****-г* ***Файл*** *цэснээс дарна.*
   - ❑ ***Прожектыг Хэвлэх****-г* ***Ажил Эмхлэгч Лайт*** *дээр хадгалсан байршлаас нээхийн тулд* ***Ажил Эмхлэгч Лайт****-г принтерийн драйверийн* ***Арчилгаа*** *таб дээрээс дарна. Дараа нь,файлаа сонгохын тулд* ***Нээх****-г* ***Файл*** *цэснээс сонгоно. Хадгалсан файлын өргөтгөл нь "ecl" байна.*
8. **Бүдүүвч** болон **Засах** цэсийг **Ажил Эмхлэгч Лайт**-с сонгож **Прожектыг Хэвлэх**-г шаардлагатай бол засварлана. Дэлгэрэнгүйг Ажил Эмхлэгч Лайт-н тусламжаас лавлаарай.
9. **Хэвлэх**-г **Файл** цэснээс сонгоно.

Холбогдох мэдээлэл

➡ 37 хуудас дээрх “Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах”

➡ 42 хуудас дээрх “Принтерийн үндсэн мэдээлэл — Windows”

Нэг зургийг олон хуудсан дээр хэвлэж зурагт хуудас үүсгэх (зөвхөн Windows)

Энэ тохиргоо нь танд, нэг зургийг олон хуудас цаасан дээр хэвлэх боломжийг олгоно.Хэвлэсэн хэсгүүдээ нийлүүлэн нааж илүү том зурагт хуудас үүсгэх боломжтой.



Тэмдэглэл:
Хүрээгүй хэвлэх дээр энэхүү үзүүлэлтийг ашиглах боломжгүй.

1. Принтерт цаасыг ачаал.
2. Хэвлэхийг хүссэн файлаа нээ.
3. Принтерийн драйверын цонхонд хандана.
4. **2x1 Плакат**, **2x2 Плакат**, **3x3 Плакат**, **4x4 Плакат**-ийг **Үндсэн** таб дээрх **Олон-Хуудаст**-ээс сонгоно уу.
5. **Тохиргоо**-г дарж зохих тохиргоог хийгээд **OK**-г дарна.

   Тэмдэглэл:
   Таслах Зураас Хэвлэх *танд тайрах ирмэг хэвлэх чигийг харах боломж олгоно.*
6. Шаардлагатай бол **Үндсэн** болон **Илүү Сонголтууд** таб дээрх бусад зүйлсийг тохируулсны дараа **OK**-г дарна.
7. **Хэвлэх** товчийг дар.

Холбогдох мэдээлэл

➡ 37 хуудас дээрх “Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах”
➡ 42 хуудас дээрх “Принтерийн үндсэн мэдээлэл — Windows”

Давхардсан Зэрэгцүүлэлтын Тэмдэг ашиглан зурагт хуудас хийх

2x2 Плакат-г сонгосон үед, **Давхардсан Зэрэгцүүлэлтын Тэмдэг**-г **Таслах Зураас Хэвлэх** дээр сонгосон байхад зурагт хуудсыг хэрхэн хийх жишээг доор харуулав.



1. Sheet 1 ба Sheet 2-г бэлтгэнэ. Sheet 1-н хүрээг цэнхэр босоо шугамын дагуу хайчилж, дээд болон доод хөндлөн тэмдгийн голоор дайруулан зүснэ.



2. Sheet 1-н ирмэгийг Sheet 2-н дээд талд байрлуулж, хөндлөн тэмдгийг тааруулна. Дараа нь, хоёр хуудсыг ар талаар нь нийлүүлж түр наалтаар наана.



3. Тохируулсан тэмдэглэлийн дагуу татсан босоо улаан шугамаар наасан хуудсыг хуваана (энэ удаад хөндлөн тэмдэглэгээний зүүн талын шугам).



4. Хуудсуудыг ар талаар нь наана.



5. Sheet 3 болон Sheet 4-г наахад 1-4-р алхмыг давтана.

6. Зүүн болон баруун талын хөндлөн тэмдэглэгээний дундуур татсан хөндлөн хөх шугамаар Sheet 1 болон Sheet 2-н хүрээг тайрна.



Хэвлэх

7. Sheet 1 болон Sheet 2 ирмэгийг Sheet 3 болон Sheet 4-н орой дээр байрлуулж, хөндлөн тэмдгийг тааруулан, дараа нь тэдгээрийг ар талаар нь түр наана.



8. Тохируулсан тэмдэглэгээний дундуур татсан улаан шугамын дагуу наасан хуудсыг хоёр хуваана (энэ удаад хөндлөн тэмдэгийн дээрх шугамаар).



9. Хуудсуудыг ар талаар нь наана.



10. Гаднах тэмдгийн дагуу үлдсэн хүрээг тайрна.



Дээд зэргийн тохиргоог ашиглан хэвлэх

Энэхүү хэсэгт принтерийн драйверийн ашиглах боломжтой нэмэлт загвар, хэвлэлийн төрөл бүрийн тохиргоог танилцуулна.

Холбогдох мэдээлэл

➡ 98 хуудас дээрх “Windows принтерийн драйвер”

➡ 101 хуудас дээрх “Mac OS принтерийн драйвер”

Принтерийн урьдчилсан тохиргоог хялбар хэвлэх тохиргоон дээр нэмэх

Принтерийн драйвер дээр байнга ашигладаг хэвлэлийн тохиргооны урьдчилсан тавилыг үүсгэхийг хүсэж буй бол, та жагсаалтаас урьдчилсан тохиргоог сонгосноор хялбархан хэвлэх боломжтой болно.

Windows

Өөрийн урьдчилсан тохиргоог нэмэхийн тулд **Баримтын Хэмжээ** болон **Цаасны Төрөл**-г **Үндсэн** эсвэл **Илүү Сонголтууд** таб дээр тохируулаад, дараа нь **Урьдчилсан тохиргоог Нэмэх/Хасах**-г **Хэвлэлт Урьдчилж тохируул** дээрээс товшино.

Тэмдэглэл:
*Нэмсэн урьдчилсан тохиргоог устгахын тулд, **Урьдчилсан тохиргоог Нэмэх/Хасах** дээр дарж, жагсаалтаас хасахыг хүсэж буй урьдчилсан тохиргооны нэрийг сонгож, дараа нь үүнийг устгана.*

Mac OS

Принтерийн харилцах цонхонд хандана.Өөрийн урьдчилсан тохиргоог нэмэхийн тулд, **Цаасны Хэмжээ** болон **Media Type** зэрэг зүйлсийг тохируулж дараа нь **Урьдчилсан тохиргоо** дээр одоогийн тохиргоог хадгална.

Тэмдэглэл:
*Нэмсэн урьдчилсан тохиргоог устгахын тулд, **Урьдчилсан тохиргоо** > **Урьдчилсан тохиргоог харуулах** дээр дарж, жагсаалтаас хасахыг хүсэж буй урьдчилсан тохиргооны нэрийг сонгож, дараа нь үүнийг устгана.*

Жижигрүүлсэн эсвэл томруулсан баримт бичгийг хэвлэх

Та тодорхой хувиар баримт бичгийн хэмжээг жижигрүүлж, эсвэл томруулж болно.

Windows

Тэмдэглэл:
Хүрээгүй хэвлэх дээр энэхүү үзүүлэлтийг ашиглах боломжгүй.

Баримтын Хэмжээ-г **Илүү Сонголтууд** таб дээр тохируулна.**Баримтыг Багасгах/Томсгох**, **Хүртэл томсго**-г сонгож дараа нь дүрслэлийн хувиа оруулна.

Mac OS

Тэмдэглэл:
Програмаас шалтгаалж үйлдлүүд нь ялгаатай байна.Дэлгэрэнгүй мэдээллийг програмын тусламжаас үзнэ үү.

Цаасны Тохируулга (эсвэл **Хэвлэх**)-ийг **Файл** цэснээс сонго.**Зориулсан Формат** хэсэгт принтерийг сонгож, цаасны хэмжээ сонгоод, **Хуваарь** хэсэгт хувийг оруулна.Цонхыг хаагаад, хэвлэх үндсэн зааврын дагуу хэвлэнэ.

Принтерийн өнгийг тохируулах

Та хэвлэх ажилд хэрэглэж буй өнгийг тохируулах боломжтой.

Хэвлэх

ФотоСайжрилт нь үндсэн зургийн мэдээллийн тодрол, хурц, цайвар байдлыг автоматаар тохируулснаар тод зургийг хэвлэж, илүү тод өнгийг гаргадаг.

Тэмдэглэл:

- ❏ *Эдгээр тохируулгыг үндсэн мэдээлэл дээр хийдэггүй.*
- ❏ ***ФотоСайжрилт** нь дүрсний байрлалд шинжилгээ хийснээр өнгийг тохируулдаг.Тиймээс, та зургийг жижигрүүлж, томруулж, тайрч, эргүүлэн дүрсний байрлалыг өөрчилсөн бол, зурагны өнгө гэнэт өөрчлөгдөх магадлалтай.Хүрээгүй тохиргоо сонгох нь мөн дүрсний байрлалыг өөрчилж улмаар өнгийг өөрчилдөг.Хэрэв зураг фокусгүй болсон байвал, өнгө зохицол нь хэвийн бус болсон байх ёстой.Өнгө өөрчлөгдөж хэвийн бус болсон байвал **ФотоСайжрилт**-с өөр горимоор хэвлэнэ үү.*

Windows

Өнгө Засалт-с **Илүү Сонголтууд** табан дээрээс өнгө засах аргыг сонгоно уу.

Хэрэв та **Автомат**ыг сонговол, өнгө нь цаасны төрөл, хэвлэлийн чанарын тохиргоотой нийцэж автоматаар тохируулагдана.Хэрэв та **Өөрчлөх** цэсийг сонгож **Нэмэлт** хэсэг дээр дарвал, та өөрийн тохиргоогоо хийх боломжтой болно.

Mac OS

Принтерийн харилцах цонхонд хандана.Дэлгэгддэг цэснээс **Өнгө тааруулах**-г сонгож, дараа нь **EPSON Color Controls**-г сонгоно.Дэлгэгддэг цэснээс **Color Options**-г сонгож, дараа нь бэлэн байгаа сонголтуудын нэгийг сонгоно.**Мэргэшсэн Тохиргоо**-н хажууд байгаа сумыг дарж, зохих тохиргоог хийнэ.

Уотермарк хэвлэх (Windows-т зөвхөн)

Та хэвлэмэл материал дээрээ "Нууц" зэрэг уотермаркийг хэвлэх боломжтой.Түүнчлэн, та өөрийн уотермаркийг нэмэх боломжтой.



Тэмдэглэл:
Хүрээгүй хэвлэх үед энэхүү тохиргоог ашиглах боломжгүй.

Усан тэмдгийн Үзүүлэлтүүд-г **Илүү Сонголтууд** таб дээрээс дарж, уотермаркийг сонгоно.Уотермаркийн нягтшил, байрлал зэрэг дэлгэрэнгүй тохиргоог өөрчлөхийн тулд **Тохиргоо**-г дарна.

Хуудасны толгой, доод хэсгийг хэвлэх (Windows-т зөвхөн)

Та хэрэглэгчийн нэр, хэвлэсэн огноо зэрэг мэдээллийг толгой, доод хэсэгт хэвлэж болно.

Усан тэмдгийн Үзүүлэлтүүд-г **Илүү Сонголтууд** таб дээрээс дарж, дараа нь **Дээд хэсэг/ Доод хэсэг**-г сонгоно. **Тохиргоо** дээр дарж, дэлгэгддэг жагсаалтаас шаардлагатай зүйлсийг сонгоно.

Epson Easy Photo Print ашиглаж фото зураг хэвлэх

Epson Easy Photo Print нь төрөл бүрийн цаасан дээр фото зургийг хялбархан бүдүүвчилж хэвлэх боломжтой. Дэлгэрэнгүй мэдээллийг програмын тусламжаас үзнэ үү.

Тэмдэглэл:

❏ *Epson-н жинхэнэ фото цаасан дээр хэвлэснээр бэхний чанар дээд зэргээр гарч, хэвлэмэл материал тод, гоё өнгөтэй байна.*

❏ *Худалдаанд бэлэн байгаа программ хангамж ашиглан хүрээгүй хэвлэхийг ашиглахын тулд дараах тохиргоог хийнэ үү.*

- ❏ Цаасны хэмжээтэй бүрэн таарсан зургийн мэдээллийг үүсгэж, таны ашиглаж буй программ хангамж дээр хүрээний тохиргоог хийх боломжтой бол, хүрээг 0 мм болгоно.
- ❏ Принтерийн драйвер дээр хүрээгүй хэвлэх тохиргоог идэвхжүүлнэ.

Холбогдох мэдээлэл

➡ 105 хуудас дээрх "Epson Easy Photo Print"

➡ 109 хуудас дээрх "Программ хангамжийг устгах"

Ухаалаг төхөөрөмжөөс хэвлэх

Epson iPrint ашиглах

Epson iPrint нь ухаалаг утас эсвэл таблет зэрэг ухаалаг төхөөрөмжөөс фото зураг, баримт, вэб хуудсыг хэвлэх боломжтой програм юм. Принтертэй ижил утасгүй сүлжээнд холбогдсон ухаалаг төхөөрөмжөөс хэвлэх дотоод хэвлэлт, эсвэл, интернэтээр дамжуулан алсын байрлалаас хэвлэх алсын хэвлэлтийн аль нэгийг сонгох боломжтой. Алсын хэвлэлтийг ашиглахын тулд принтерээ Epson Connect үйлчилгээнд бүртгүүлнэ.

Холбогдох мэдээлэл

➡ 96 хуудас дээрх "Epson Connect үйлчилгээ"

Epson iPrint Суулгах

Та дараах URL эсвэл QR кодоос ухаалаг төхөөрөмж дээрээ Epson iPrint суулгаж болно.

http://ipr.to/a

Epson iPrint ашиглан хэвлэх

Ухаалаг төхөөрөмжөөсөө Epson iPrint-г эхлүүлж, нүүр дэлгэцээс ашиглахыг хүссэн зүйлээ сонгоно.

Дараах дэлгэцний байдал нь урьдчилж мэдэгдэлгүйгээр өөрчлөгдөх боломжтой.Агуулга бүтээгдэхүүнээс хамаарч өөр өөр байж болно.



❶	Аппликейшн эхлэхэд нүүр дэлгэц нь гарч ирнэ.
❷	Принтерийг хэрхэн тохируулах болон Түгээмэл Асуулт Хариултуудыг харуулна.
❸	Принтерийг сонгож, принтерийн тохиргоог хийх дэлгэцийг харуулна.Принтерийг нэг сонгосон бол дараагийн удаа дахин сонгох шаардлагагүй болно.
❹	Зураг, бичиг баримт зэрэг хэвлэхийг хүссэн зүйлээ сонгоно.
❺	Цаасны хэмжээ, цаасны төрөл зэрэг хэвлэх тохиргоог хийх дэлгэцийг харуулна.
❻	Таны сонгосон фото зураг, баримт бичгийг харуулна.
❼	Хэвлэж эхэлнэ.

Тэмдэглэл:
iPhone, iPad, iPod touch зэрэг iOS дээр ажилладаг төхөөрөмжөөс хэвлэхийн тулд Epson iPrint-г iTunes дээрх файл хуваалцах функцыг ашиглан хэвлэхийг хүссэн баримтаа шилжүүлсний дараа ажиллуулна.

Хэвлэхийг цуцлах

Тэмдэглэл:

- *Windows дээр хэвлэх ажил принтер рүү бүрэн илгээгдсэний дараа компьютероос хэвлэх ажлыг цуцлах боломжгүй.Энэхүү тохиолдолд, принтерийн хяналтын самбарыг ашиглан хэвлэх ажлыг цуцална.*
- *Mac OS-с хэд хэдэн хуудсыг хэвлэх үед, та хяналтын самбарыг ашиглан бүх ажлыг цуцлах боломжгүй.Энэ тохиолдолд, компьютероос хэвлэх ажлыг цуцална.*
- *Та хэвлэх ажлыг Mac OS X v10.6.8-с сүлжээгээр дамжуулж илгээсэн бол та компьютероос хэвлэх ажлыг цуцлах боломжгүй болох юм.Энэхүү тохиолдолд, принтерийн хяналтын самбарыг ашиглан хэвлэх ажлыг цуцална.*

Хэвлэхийг цуцлах — Принтерийн товч

Явагдаж буй хэвлэх ажлыг цуцлахын тулд ⊽ дээр дарна.

Хэвлэхийг цуцлах — Windows

1. Принтерийн драйверийн цонхонд хандана.
2. **Арчилгаа** табыг сонгоно.
3. **Хэвлэх Дараалал** дээр дарна.
4. Цуцлахыг хүсэж буй ажил дээр хулганы баруун товчийг дарж дараа нь **Цуцлах**-г сонгоно.

Холбогдох мэдээлэл

➡ 98 хуудас дээрх “Windows принтерийн драйвер”

Хэвлэхийг цуцлах — Mac OS

1. **Тавцан** дээрх принтерийн тэмдэг дээр дарна.
2. Цуцлахыг хүсэж буй ажлаа сонгоно.
3. Ажлыг цуцална.
   - ❏ OS X Mountain Lion буюу түүнээс хойших

     Үйл явц хэмжигчийн хажуугийн ⊗ дээр дарна.
   - ❏ Mac OS X v10.6.8-с v10.7.x

     Устгах дээр дарна.

Хуулбарлах

Хуулбарлах үндсэн мэдээлэл

Та ижил хэмжээтэйгээр A4 хэмжээтэй цаасан дээр хуулбарлаж болно. Эх хувь нь цаасны өнцгийн эргэн тойрондоо хүрээтэй эсэхээс үл хамааран 3 мм-н өргөнтэй хүрээ цаасны өнцгийн эргэн тойрон харагдана. A4-өөс бага хэмжээтэй эх хувийг хуулбарлах үед, эх хувийг хаана байрлуулснаас хамааран 3 мм-ээс илүү өргөнтэй хүрээтэй байна.

1. A4 хэмжээтэй цаасыг принтер дээр ачаална.
2. Эхийг байрлуул.
3. эсвэл товчийг дарна.

   Тэмдэглэл:
   Хуулсан зургийн өнгө, хэмжээ, хүрээ нь эх зургаас бага зэрэг өөр байна.

Холбогдох мэдээлэл

➡ 37 хуудас дээрх “Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах”

➡ 40 хуудас дээрх “Сканнерын Шил дээр эх хувийг байрлуулах”

Олон тооны хуулбар хийх

Та нэг удаад олон тооны хуулбар хийж болно. Та 20 хүртэлх хуулбар хийхээр зааж болно. 3 мм-н өргөнтэй хүрээ нь цаасны эргэн тойронд харагдана.

1. Хуулбарлахыг хүсэж буй хувийн тоотой ижил тооны A4 хэмжээтэй цаасыг ачаална.
2. Эх хувийг байрлуулна.
3. Хуулбарлахыг хүсэж буй тоотой адил хэмжээгээр эсвэл товчийг дарна. Жишээлбэл, та өнгөтөөр 10 хувийг хуулбарлахыг хүсэж байвал товчийг 10 удаа дарна.

   Тэмдэглэл:
   Хувийн тоог өөрчлөхийн тулд уг товчийг нэг секунд дарна. Нэг секунд уг товчийг дарсны дараа дахин дарвал, хуулбарын тоог тогтоож, хуулбарлах ажиллагаа эхэлнэ.

Холбогдох мэдээлэл

➡ 37 хуудас дээрх “Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах”

➡ 40 хуудас дээрх “Сканнерын Шил дээр эх хувийг байрлуулах”

Скандах

Хяналтын самбараас скандах

Принтертэй USB кабель утсаар холбогдсон компьютер руу та скандсан зургийг PDF форматаар хадгалах боломжтой.

> ***Чухал:***
> *Та энэхүү тохиргоог ашиглахын тулд компьютер дээрээ Epson Scan 2 ба Epson Event Manager суулгасан байх ёстой.*

1. Эхийг байрлуул.
2. товч болон товчийг зэрэг дарна.

Тэмдэглэл:

- ❏ *Сканнердах хэмжээ, хадгалах хавтас, хадгалах формат зэрэг сканнерийн тохиргоог Epson Event Manager ашиглан өөрчлөх боломжтой.*
- ❏ *Сканнердсан зургийн өнгө, хэмжээ, хүрээ эхтэй яг адил биш байж болно.*

Холбогдох мэдээлэл

➡ 40 хуудас дээрх “Сканнерын Шил дээр эх хувийг байрлуулах”

➡ 105 хуудас дээрх “Epson Event Manager”

Компьютероос скандах

Epson Scan 2 ашиглан сканнердах

Та "Epson Scan 2"-н сканнерийн драйверийг ашиглан сканнердах боломжтой. Тохиргоо бүрийн тайлбарыг Epson Scan 2-н тусламж хэсгээс үз.

Холбогдох мэдээлэл

➡ 104 хуудас дээрх “Epson Scan 2 (Сканнерийн драйвер)”

Бичиг баримтыг сканнердах (Баримтын Горим)

Epson Scan 2 дээр **Баримтын Горим** ашиглан та бичвэр бичиг баримтанд тохиромжтой нарийн тохиргоог ашиглан эхүүдийг сканнердах боломжтой.

1. Эхийг байрлуул.
2. Epson Scan 2-г эхлүүлнэ.

Скандах

3. **Баримтын Горим**-г **Горим** жагсаалтаас сонгоно.

4. **Үндсэн тохиргоо** таб дээрх дараах тохиргоог хийнэ.



❏ Баримтын Хэмжээ: Байрлуулсан эхийнхээ хэмжээг сонго.

❏ / (Эх чиглэл) товчнууд: Эхийг байрлуулсан тохируулгын чиглэлийг сонго. Эхийн хэмжээнээс шалтгаалан энэ зүйл нь автоматаар тохируулагдан, өөрчлөгдөх боломжгүй байж болно.

❏ Зургийн төрөл: Сканнердсан зургийг хадгалах өнгийг сонго.

❏ Нягтрал: Нягтарлыг сонго.

Тэмдэглэл:

❏ ***Баримтын эх*** *тохиргоо нь* ***Сканерийн шил****-н нэгэн адил тогтмол байна. Та энэ тохиргоог өөрчлөх боломжгүй.*

❏ *Та сканнердсаны дараа* ***Сканердаад хуудас нэм, засах*** *тохиргоо хийвэл, та эх хувийг сканнердсаны дараа нэмэлт эх хувийг сканнердах боломжтой болно. Улмаар,* ***Зургийн формат****-г PDF эсвэл Multi-TIFF гэж тохируулсан бол, та сканнердсан зургаа нэг файл болгож хадгалж чадна.*

5. Хэрэв шаардлагатай бол бусад сканнерийн тохиргоог хий.

❏ Та **Урьдчилж харах** товчийг товшин сканнердсан зургийг урьдчилан харах боломжтой. Урьдчилан харах цонх нээгдэж, урьдчилан харсан зургууд харагдана.

Скандах

- **Мэргэжлийн Тохиргоо** таб дээр та бичвэр бичиг баримтанд тохиромжтой нарийн зураг тохируулах тохиргоог хийх боломжтой.
  - Ар фоныг арилгах: Эх хувийн дэвсгэр зургийг арилга.
  - Текстийг сайжруулах: Та бүдгэрсэн үсгүүдийг хурц тод өнгөтэй болгох боломжтой.
  - Авто сегментчлэл: Та зураг агуулсан бичиг баримтыг хар цагаанаар сканнердах үед үсгийг тодруулж зургийг гөлгөр болгох боломжтой.
  - Өнгөний сайжруулалт: Та сканнердсан зургийнхаа тодорхой өнгийг сайжруулан сүүдэртэй эсвэл хар цагаан болгож болно.
  - Гэрэлтэлт: Та сканнердсан зургийн гэрэлтүүлгийг тохируулах боломжтой.
  - Ялгарал: Та сканнердсан зургийн тодролтыг тохируулах боломжтой.
  - Гамма: Та сканнердсан зургийн гамма (дунд хэсгийн гэрэлтүүлэг)-г тохируулах боломжтой.
  - Босго: Та хүрээг нэг өнгөөр (хар цагаан) хослуулан тохируулах боломжтой.
  - Хурцлах маск: Та зургийн гадны талын зураасыг сайжруулж тодруулах боломжтой.
  - Муар эффект арилгах: Та сэтгүүл гэх мэт хэвлэмэл эхийг сканнердах үед харагддаг муар хээ угалз (вэб маягийн дүрс)-ыг арилгах боломжтой.
  - Ирмэгийг Дүүргэх: Та сканнердсан зургийг тойрсон сүүдрийг арилгах боломжтой.
  - Хос зургийн гаралт (Зөвхөн Windows-д): Та нэг удаа сканнердаад 2 зургийг өөр өөр гаралтын тохиргоотойгоор хадгалах боломжтой.

Тэмдэглэл:
Таны хийсэн тохиргооны улмаас зүйлс байхгүй байж болзошгүй.

6. Файл хадгалах тохиргоог тохируул.



❏ Зургийн формат: Жагсаалтаас хадгалах форматыг сонго.

Та BITMAP ба PNG-с бусад бүх хадгалах форматаар нарийн тохируулах боломжтой. Хадгалах форматыг сонгосны дараа жагсаалтаас **Сонголтууд**-г сонго.

❏ Файлын Нэр: Харуулсан хадгалах файлын нэрийг баталгаажуул.

Та жагсаалтаас **Тохиргоо** гэснийг сонгож файлын нэрийн тохиргоог өөрчлөх боломжтой.

❏ Хавтас: Жагсаалтаас сканнердсан зургийн хадгалах хавтсыг сонго.

Та жагсаалтаас **Сонгох** сонгож шинэ хавтас үүсгэх эсвэл өөр хавтас сонгох боломжтой.

7. **Сканердах** дээр дарна.

Холбогдох мэдээлэл

➡ 40 хуудас дээрх “Сканнерын Шил дээр эх хувийг байрлуулах”

Фото эсвэл зургийг сканнердах (Фото Горим)

Фото Горим-г Epson Scan 2 дээрээс ашиглан та фото эсвэл зурагт тохиромжтой олон төрлийн зургийн тохиргооны онцлог ашиглан эхүүдийг сканнердах боломжтой.

1. Эхийг байрлуул.

Сканнерийн шилэн дээр олон эхүүдийг байршуулснаар та бүгдийг нь нэгэн зэрэг сканнердах боломжтой.Эхүүдийн хооронд дор хаяж 20 мм-ийн зай байгаа эсэхийг баталгаажуул.

Скандах

2. Epson Scan 2-г эхлүүлнэ.
3. **Фото Горим**-г **Горим** жагсаалтаас сонгоно.
4. **Үндсэн тохиргоо** таб дээрх дараах тохиргоог хийнэ.



❏ Зургийн төрөл: Сканнердсан зургийг хадгалах өнгийг сонго.

❏ Нягтрал: Нягтарлыг сонго.

Тэмдэглэл:
Баримтын эх *тохиргоог* ***Сканерийн шил*** *болгож зассан ба* ***Баримтын төрөл*** *тохиргоог* ***Гялгар*** *болгож зассан.(****Гялгар*** *гэдэг нь гэрэлтдэггүй эхүүд жишээ нь энгийн цаас ба фотонууд гэсэн үг.)Та эдгээр тохиргоог өөрчлөх боломжгүй.*

5. **Урьдчилж харах** дээр дарна.

   Урьдчилан харах цонх нээгдэж, урьдчилан харсан зургууд жижиг дүрс хэлбэрээр харагдана.



Тэмдэглэл:
*Сканнердсан хэсгийг бүхэлд нь урьдчилан харах бол урьдчилан харах цонхны дээд талд байгаа жагсаалтаас **Жижиг зураг**-г арилга.*

6. Урьдчилсан хувилбарыг баталгаажуулж, шаардлагатай бол **Мэргэжлийн Тохиргоо** таб дээрээс зургийн тохиргоог хий.



Скандах

Та фото болон зурагт тохиромжтой дэлгэрэнгүй тохиргоог ашиглан сканнердсан зургийг янзлах боломжтой, тухайлбал.

- ❏ Гэрэлтэлт: Та сканнердсан зургийн гэрэлтүүлгийг тохируулах боломжтой.
- ❏ Ялгарал: Та сканнердсан зургийн тодролтыг тохируулах боломжтой.
- ❏ Нэвчилт: Та сканнердсан зургийн дүүргэлтийг (өнгөний тодрол) тохируулах боломжтой.
- ❏ Хурцлах маск: Та сканнердсан зургийн гадны талын зураасыг сайжруулж тодруулах боломжтой.
- ❏ Өнгө сэргээлт: Та өнгөө алдсан зургийг сэргээн засах боломжтой.
- ❏ Арын фоныг засварлах: Та арын гэрэлний нөлөөгөөр бараан болсон сканнердсан зургийг цайруулах боломжтой.
- ❏ Муар эффект арилгах: Та сэтгүүл гэх мэт хэвлэмэл эхийг сканнердах үед харагддаг муар хээ угалз (вэб маягийн дүрс)-ыг арилгах боломжтой.
- ❏ Тоосыг арилгах: Та сканнердсан зургийнхаа тоосыг арилгах боломжтой.

Тэмдэглэл:

- ❏ *Таны хийсэн тохиргооны улмаас зүйлс байхгүй байж болзошгүй.*
- ❏ *Эх хувиас шалтгаалан сканнердсан зургийг зөв тохируулаагүй байж болзошгүй.*
- ❏ *Олон жижиг зураг үүссэн бол жижиг зураг тус бүрийн зургийн чанарыг тохируулах боломжтой.Тохиргооны зүйлсээс хамаарч олон жижиг зургийг сонгож сканнердсан зургуудын чанарыг нийтэд нь тохируулах боломжтой.*

7. Файл хадгалах тохиргоог тохируул.



- ❏ Зургийн формат: Жагсаалтаас хадгалах форматыг сонго.

  Та BITMAP ба PNG-с бусад бүх хадгалах форматаар нарийн тохируулах боломжтой.Хадгалах форматыг сонгосны дараа жагсаалтаас **Сонголтууд**-г сонго.

❏ Файлын Нэр: Харуулсан хадгалах файлын нэрийг баталгаажуул.
Та жагсаалтаас **Тохиргоо** гэснийг сонгож файлын нэрийн тохиргоог өөрчлөх боломжтой.

❏ Хавтас: Жагсаалтаас сканнердсан зургийн хадгалах хавтсыг сонго.
Та жагсаалтаас **Сонгох** сонгож шинэ хавтас үүсгэх эсвэл өөр хавтас сонгох боломжтой.

8. **Сканердах** дээр дарна.

Холбогдох мэдээлэл

➡ 40 хуудас дээрх “Сканнерын Шил дээр эх хувийг байрлуулах”

➡ 41 хуудас дээрх “Нэгэн зэрэг олон зургийг сканнердахаар тавих”

Ухаалаг төхөөрөмжөөс сканнердах

Epson iPrint нь таны принтертэй адил утасгүй сүлжээнд холбогдсон ухаалаг утас эсвэл таблет зэрэг ухаалаг төхөөрөмжөөс зураг, баримтыг сканнердах боломжтой програм юм. Сканнерддсан өгөгдлөө ухаалаг төхөөрөмж, эсвэл Үүлэн үйлчилгээнд хадгалж, и-мэйлээр илгээж, эсвэл хэвлэх боломжтой.

Epson iPrint Суулгах

Та дараах URL эсвэл QR кодоос ухаалаг төхөөрөмж дээрээ Epson iPrint суулгаж болно.

http://ipr.to/a

Epson iPrint ашиглан сканнердах

Ухаалаг төхөөрөмжөөсөө Epson iPrint-г эхлүүлж, нүүр дэлгэцээс ашиглахыг хүссэн зүйлээ сонгоно.

Скандах

Дараах дэлгэцний байдал нь урьдчилж мэдэгдэлгүйгээр өөрчлөгдөх боломжтой.



❶	Аппликейшн эхлэхэд нүүр дэлгэц нь гарч ирнэ.
❷	Принтерийг хэрхэн тохируулах болон Түгээмэл Асуулт Хариултуудыг харуулна.
❸	Принтерийг сонгож, принтерийн тохиргоог хийх дэлгэцийг харуулна. Принтерийг нэг сонгосон бол дараагийн удаа дахин сонгох шаардлагагүй болно.
❹	Сканнердах дэлгэцийг харуулна.
❺	Нарийвчлал зэрэг сканнердах тохиргоог хийж боломжтой дэлгэцийг харуулна.
❻	Сканнердсан зургийг харуулна.
❼	Сканнердаж эхэлнэ.
❽	Сканнердсан өгөгдлийг ухаалаг төхөөрөмж эсвэл Үүлэн үйлчилгээнд хадгалж болох дэлгэцийг харуулна.
❾	Сканнердсан өгөгдлийг и-мэйлээр илгээж болох дэлгэцийг харуулна.
❿	Сканнердсан өгөгдлийг хэвлэж болох дэлгэцийг харуулна.

Хорны картриджийг солих

Бэхний Түвшинг Шалгах

Та бэхний ойролцоолсон түвшинг компьютероосоо шалгаж болно.

Бэхний түвшинг шалгах - Windows

1. Принтерийн драйверийн цонхонд хандана.
2. **Бэхний Түвшин**-г **Үндсэн** таб дээрээс дарна.

   Тэмдэглэл:
   *Хэрэв **EPSON Status Monitor 3** цуцлагдсан бол, бэхний түвшин харагдахгүй. **Өргөтгөсөн Тохиргоо**-г **Арчилгаа** таб дээрээс дараад, **EPSON Status Monitor 3-г идэвхжүүл**-г сонгоно.*

Холбогдох мэдээлэл

➡ 98 хуудас дээрх “Windows принтерийн драйвер”

Бэхний Түвшинг Шалгах — Mac OS

1. **Системийн тохируулгууд**-ыг цэс > **Принтер & Сканнер** (эсвэл **Хэвлэх & Сканнердах**, **Хэвлэх & Факсдах**)-аас сонгоод дараа нь принтерээ сонго.
2. **Сонголт ба Хангамж** > **Хэрэгсэл** > **Принтерийн хэрэгслийг нээх** дээр дарна.
3. **EPSON Status Monitor** дээр дарна.

Хорны картриджийн код

Epson нь Epson-н жинхэнэ бэхний картриджийг ашиглахыг санал болгож байна. Epson нь жинхэнэ бус бэхний чанар, найдвартай байдалд баталгаа гаргахгүй. Жинхэнэ бус бэхийг хэрэглэснээс үүдэж хохирол гарах бөгөөд түүнийг Epson-н баталгаагаар нөхөн төлөхгүй. Зарим тохиолдолд, принтерийн ажиллагаанд хэвийн бус байдал бий болно. Жинхэнэ бус бэхний түвшингийн тухай мэдээллийг зөв харуулахгүй байж болно.

Дараах нь Epson-ы хорны картриджийн код болно.

Хорны картриджийг солих

Тэмдэг	BK: Black (Хар)	C: Cyan (Хөх)	M: Magenta (Ягаан)	Y: Yellow (Шар)
Strawberry	29 29XL*	29 29XL*	29 29XL*	29 29XL*

* "XL" том картриджийг илтгэнэ.

Тэмдэглэл:

❏ *Бүх картриджийг бүх бүс нутагт худалдан авах боломжгүй.*

❏ *Хорны картриджийн код байрлалаас хамаарч ялгаатай байна. Өөрийн бүсийн зөв кодын мэдээллийг авахын тулд Epson-ы тусламж үйлчилгээнд хандана уу.*

❏ *Европын хэрэглэгчид Epson-н хорны картриджийн гарцын талаарх мэдээллийг авахын тулд дараах вэбсайтад зочлоорой.*

http://www.epson.eu/pageyield

Холбогдох мэдээлэл

➡ 149 хуудас дээрх "Техник туслалцааны вэбсайт"

Хорны картриджтай харьцах урьдчилсан санамж

Хорны картриджийг солихын өмнө дараах зааврыг уншина уу.

Ашиглалтын урьдчилсан санамж

❏ Бэхийн картриджийг өрөөний ердийн температурт хадгалж, нарны шууд тусгалаас хол байлгана.

❏ Сав баглаанд дээр заасан огнооноос өмнө бэхний картриджийг ашиглахыг Epson санал болгож байна.

❏ Сайн үр дүн хүрэхийн тулд, баглааг задалснаас зургаан сарын дотор бэхний картриджийг ашиглаж дуусгана.

❏ Сайн үр дүнд хүрэхийн тулд, бэхний картриджийн иж бүрдлийн ёроолыг доош нь харуулж хадгална.

❏ Бэхний картриджийг хүйтэн агуулахын талбайгаас өрөөн дотор оруулсны дараа, түүнийг ашиглахаас өмнө гурваас доошгүй цаг өрөөний температурт бүлээцүүлнэ.

❏ Үүнийг принтерт суулгахад бэлэн болтлоо бэхний картриджийн сав баглаа боодлыг онгойлгохгүй байна. Найдвартай байдлыг хадгалахын тулд бэхний картриджийг вакумжуулж савласан байдаг. Хэрэв картриджийг ашиглахаас өмнө удаан хугацаагаар онгорхой байлгавал, ердийн байдлаар хэвлэх боломжгүй болох аюултай.

❏ Та бэхний картриджийн хажуу талын дэгээг салгах үедээ түүнийг эвдэхгүй байхад анхаарал хандуулна.

Хорны картриджийг солих

❏ Та картриджийг суулгахаас өмнө шар хуулгыг нь салгах ёстой; эс тэгвээс хэвлэлийн чанар муудах эсвэл та хэвлэх боломжгүй болж магадгүй. Картриджийн шошгыг салгах эсвэл урж болохгүй; энэ нь бэх асгарахад хүргэнэ.

❏ Картриджийн ёроолоос тунгалаг лацыг салгаж болохгүй; эс тэгвээс, картриджийг ашиглах боломжгүй болж магадгүй.



❏ Зурагт үзүүлсэн хэсгүүдэд бүү хүр. Тэгвэл, хэвийн ажиллагаа хэвлэх ажиллагаанд саад учруулах аюултай.

❏ Бүх бэхний картриджаа суурилуулна; эс тэгвээс та хэвлэх боломжгүй.

❏ Тэжээл салсан үед бэхний картриджийг сольж болохгүй. Принтерийн толгойг гараар хөдөлгөхгүй байх; эс тэгвээс, та принтерт эвдрэл гэмтэл учруулж болно.

Хорны картриджийг солих

- ❏ Бэхний картриджийг салгасны дараа, принтер бэхийг цэнэглэж байх хооронд тэжээлийн гэрэл үргэлжлүүлэн анивчина. Бэх цэнэглэх зуур принтерийг бүү унтраа. Бэх цэнэглэж дуусаагүй бол, та хэвлэх боломжгүй хэвээр байна.
- ❏ Хонгиог салгасан үед принтерийг эзэнгүй орхиж болохгүй, мөн хонгиог сольж байхдаа принтерийг унтрааж болохгүй. Эс тэгвээс, принтерийн толгойн цоргонд үлдсэн бэх хатаж, та хэвлэх боломжгүй болж болно.
- ❏ Та түр хугацаагаар бэхний картриджийг салгах хэрэгтэй бол, та бэх хангах талбайг тоос шорооноос хамгаална уу. Бэхний картриджийг принтерийнхтэй ижил орчинд хадгалах ба бэх нийлүүлэх портыг доош, эсвэл хажуу тийш нь харуулна. Бэх нийлүүлэх портыг дээш нь харуулж бэхний картриджийг бүү хадгал. Бэх нийлүүлэх порт нь илүүдэл бэхний гаралтыг тогтоох хавхлагаар тоноглосон учраас, өөрийн таг, эсвэл залгуурыг ашиглах шаардлага байхгүй.
- ❏ Салгасан бэхний картриджийн бэх нийлүүлэх портын эргэн тойрон бэх байж болох бөгөөд картриджийг салгахдаа түүний эргэн тойронд бэх болгохгүй байхад анхаарна.
- ❏ Энэ принтер нь картридж бүрийн үлдэж буй бэх зэрэг мэдээллийг хянадаг ногоон чипээр тоноглогдсон бэхний картриджийг ашигладаг. Картриджийг ашиглахаас өмнө принтерээс салгасан ч гэсэн, та тус картриджийг дараа нь принтерт буцаан хийж ашиглаж болно гэсэн үг юм. Гэсэн хэдий ч, картриджийг дахин хийх үед, принтерийн ажиллагааг баталгаажуулахын тулд тодорхой хэмжээний бэхийг хэрэглэх боломжтой.
- ❏ Бэхийг хамгийн үр ашигтай ашиглахыг тулд, та солиход бэлэн болсон үедээ л бэхний картриджийг салгаж байна уу. Бага бэхний түвшинтэй бэхний картриджийг дахин хийсэн үед ашиглаж болохгүй.
- ❏ Та дээд зэргийн хэвлэлийн чанараар хэвлэж, өөрийн принтерийн толгойг хамгаалж байхын тулд, таны принтерийн картриджийг солих дохио өгөх үед картриджад бэхний аюулгүй ажиллагааны янз бүрийн нөөцийг үлдээнэ. Танд харуулах гарцын хэмжээнд энэхүү нөөц орж тооцогдохүй болно.
- ❏ Бэхний картридж дотор дахин боловсруулсан материал ашиглаж болдог боловч, энэ нь принтерийн үйл ажиллагаа, гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй.
- ❏ Сайжруулсан талаар урьдчилсан мэдэгдэл өгөхгүйгээр бэхний картриджийн үзүүлэлт, гаднах байдлыг өөрчилж болно.
- ❏ Бэхний картриджийг задалж, өөрчилж болохгүй. Эс тэгвээс, та хэвийн хэвлэх боломжгүй болж болно.
- ❏ Солиулахаар принтертэй цуг ирсэн картриджийг та ашиглаж болохгүй.
- ❏ Хэвлэж буй зураг, ашиглаж буй цаасны төрөл, хэвлэх давтамж, температур зэрэг орчны нөхцөл байдлаас шалтгаалан дурдсан гарц өөрчлөгдөж болно.

Бэх зарцуулалт

- ❏ Принтерийн толгойн оновчтой хэрэглээг хадгалахын тулд принтерийн толгойг цэвэрлэх зэрэг засвар үйлчилгээний үед бүх бэхний савнаас тодорхой хэмжээний бэхийг хэрэглэж болно. Мөн принтерийг асаахад бэх хэрэглэгдэж болно.
- ❏ Монохром болон саарал дэвсгэрээр хэвлэх үед, цаасны төрөл, эсвэл хэвлэлийн чанарын тохиргооноос шалтгаалж хар бэхний оронд өнгөт бэхийг хэрэглэж болно. Энэ нь хар өнгийг бүрдүүлэхийн тулд өнгөт бэхний холимог хэрэглэгддэгтэй холбоотой.
- ❏ Принтертэй хамт ирсэн бэхний картридж дотор бэх нь анхан шатны тохиргооны үед баг зэрэг хэрэглэгддэг. Дээд зэргийн чанараар хэвлэхийн тулд принтерийн хэвлэх толгой нь бэхээр бүрэн дүүртлээ цэнэглэгдэнэ. Энэхүү нэг удаагийн үйл явцад тодорхой хэмжээний бэх хэрэглэгддэг тул дараагийн удаад дүүргэх бэхний картриджтай харьцуулахад цөөн тооны цаас хэвлэж болно.

Хорны картриджийг солих (Гэрэл асаалттай эсвэл анивчиж байгаа үед)

> ⚠ ***Болгоомжтой:***
>
> *Сканнерын нэгцийг нээж хаах үедээ гар, хуруугаа хавчуулахаас болгоомжлоорой. Эс бөгөөс гэмтэх аюултай.*

Тэмдэглэл:

- *Та ♦ (хор) гэрэл анивчиж байгаа үед үргэлжлүүлэн хэвлэх боломжтой. Гэхдээ шинэ хорны картриджийг нэн даруй бэлд.*
- *Хэрэв та хуулах үеэр хорны картриджийг сольвол эхүүд гарч болзошгүй. ▽ товчийг товшиж эхүүдийг соль.*

1. Баримтын тагийг хаалттай хэвээр сканнерийн нэгжийг нээнэ.



2. Хорны картриджийн суурийг зөөхийн тулд принтерйн товчуудыг дар.

   Тэмдэглэл:
   Картриджийг ♦ тэмдэг дээр зогсонгуут соль. Хэрэв нэлээн дуусаж байгаа хор бол картридж ♦ тэмдэг рүү таныг ▽ товчийг дарах бүрт очно.



- Хэрэв ♦ гэрэл асаалттай бол (нэг буюу түүнээс дээш хорны картридж дууссан үед)

  ▽ товчийг дарна. Хорны картриджийн суурь ♦ тэмдэг рүү хөдөлнө. Та энэ байрлалаас картриджийг солих боломжгүй. Дараагийн алхам руу шилж.

Хорны картриджийг солих

❏ Хэрэв ♦ гэрэл анивчиж байгаа бол (нэг буюу түүнээс дээш хорны картридж дуусаж байгаа үед)

⍜ товчийг хорны картридж ⍀ тэмдэг рүү хөдлөх хүртэл удаан дар. Та энэ байрлалаас картриджийг солих боломжгүй. Дараагийн алхам руу шилж.

Тэмдэглэл:
Хорны картриджийг солихоо болих бол хорны картриджийг авалгүй принтерийг унтраа.

3. ⍜ товчийг дахин дар.

   Хорны картриджийн суурь солих байрлал руу хөдөлнө.



4. Хар хорны картриджийг солих бол шинэ хар хорны картриджийг дөрвөөс таван удаа зөөлөн сэгсэрч, савнаас гарга. Бусад өнгөний картриджийг солих бол шинэ өнгөт картриджийг сэгсрэхгүйгээр савнаас нь гарга.



Чухал:
Боодлыг нь нээсний дараа картриджийг сэгсэрч болохгүй, учир нь асгарах аюултай.

Хорны картриджийг солих

5. Зөвхөн шар туузыг хуул.



Чухал:

Зурагт үзүүлсэн хэсгүүдэд бүү хүр. Тэгвэл, хэвийн ажиллагаа хэвлэх ажиллагаанд саад учруулах аюултай.

6. Хорны картридж дээрх цоргыг шахаж дээшээ тат. Хэрэв та хорны картриджийг гаргаж чадахгүй бол хүчдээ дээш нь тат.



Хорны картриджийг солих

7. Шинэ хорны картриджийг оруулаад доош нь чанга дарж өг.



8. Сканнерийн нэгжийг хаана.



9. ⓥ товчийг дарна.

Хорыг цэнэглэж эхэлнэ.

> ***Чухал:***
>
> *Бэхний картриджийг салгасны дараа, принтер бэхийг цэнэглэж байх хооронд тэжээлийн гэрэл үргэлжлүүлэн анивчина. Бэх цэнэглэх зуур принтерийг бүү унтраа. Цэнэглэх ойролцоогоор хоёр минут болно. Бэх цэнэглэж дуусаагүй бол, та хэвлэх боломжгүй хэвээр байна.*

Тэмдэглэл:

Хэрэв ♦ гэрэл унтрахгүй бол хорны картриджийг аваад дахин оруулаад үз.

Холбогдох мэдээлэл

➡ 73 хуудас дээрх “Хорны картриджийн код”

➡ 74 хуудас дээрх “Хорны картриджтай харьцах урьдчилсан санамж”

Хорны картриджийг солих (Гэрэл унтраалттай байгаа үед)

Та картриджинд хор байсан ч гэсэн картриджийг солих боломжтой.

> ⚠ ***Болгоомжтой:***
> *Сканнерын нэгцийг нээж хаах үедээ гар, хуруугаа хавчуулахаас болгоомжлоорой. Эс бөгөөс гэмтэх аюултай.*

1. Баримтын тагийг хаалттай хэвээр сканнерийн нэгжийг нээнэ.



2. ▽ товчийг хорны картриджийн суурь хөдөлж эхэлтэл удаан дар.



Хорны картриджийн суурь солих байрлал руу хөдөлнө.

Тэмдэглэл:
Хорны картриджийг солихоо болих бол хорны картриджийг авалгүй принтерийг унтраа.

Хорны картриджийг солих

3. Хар хорны картриджийг солих бол шинэ хар хорны картриджийг дөрвөөс таван удаа зөөлөн сэгсэрч, савнаас гарга. Бусад өнгөний картриджийг солих бол шинэ өнгөт картриджийг сэгсрэхгүйгээр савнаас нь гарга.



> ***Чухал:***
> *Боодлыг нь нээсний дараа картриджийг сэгсэрч болохгүй, учир нь асгарах аюултай.*

4. Зөвхөн шар туузыг хуул.



Хорны картриджийг солих

Чухал:

Зурагт үзүүлсэн хэсгүүдэд бүү хүр. Тэгвэл, хэвийн ажиллагаа хэвлэх ажиллагаанд саад учруулах аюултай.



5. Хорны картридж дээрх цоргыг шахаж дээшээ тат. Хэрэв та хорны картриджийг гаргаж чадахгүй бол хүчтэй дээш нь тат



6. Шинэ хорны картриджийг оруулаад доош нь чанга дарж өг.



7. Сканнерийн нэгжийг хаана.



8. ⓥ товчийг дарна.

Хорыг цэнэглэж эхэлнэ.

> ***Чухал:***
>
> *Бэхний картриджийг салгасны дараа, принтер бэхийг цэнэглэж байх хооронд тэжээлийн гэрэл үргэлжлүүлэн анивчина. Бэх цэнэглэх зуур принтерийг бүү унтраа. Цэнэглэх ойролцоогоор хоёр минут болно. Бэх цэнэглэж дуусаагүй бол, та хэвлэх боломжгүй хэвээр байна.*

Тэмдэглэл:

Хэрэв ♦ гэрэл унтрахгүй бол хорны картриджийг аваад дахин оруулаад үз.

Холбогдох мэдээлэл

➡ 73 хуудас дээрх “Хорны картриджийн код”

➡ 74 хуудас дээрх “Хорны картриджтай харьцах урьдчилсан санамж”

Түр зуур хар хороор хэвлэх

Компьютероос хэвлэх үед өнгөт хор дуусаж, хар хор үлдсэн үед та дараах тохиргоог ашиглаж, богино хугацаанд зөвхөн хар хорыг ашиглан хэвлэх боломжтой.

❏ Цаасны төрөл: Цулгуй цаас, Дугтуй

❏ Өнгө: **Грейскейл**

❏ Хүрээгүй: Сонгоогүй

❏ EPSON Status Monitor 3: Идэвхжүүллээ (Зөвхөн Windows-д зориулсан)

Энэ үйлчилгээг ойролцоогоор ердөө таван өдөр ашиглах боломжтой учраас дууссан хорны картриджийг нэн даруй солиорой.

Хорны картриджийг солих

Тэмдэглэл:

- ❏ *Хэрэв **EPSON Status Monitor 3** идэвхижээгүй бол, принтерийн драйверт нэвтэрч, **Өргөтгөсөн Тохиргоо**-г **Арчилгаа** таб дээрээс сонгоод, **EPSON Status Monitor 3-г идэвхжүүл**-г сонгоно.*
- ❏ *Өгөгдсөн хугацаа хэрэглээний нөхцөлөөс хамаарч ялгаатай байна.*

Түр зуур хар хороор хэвлэх — Windows

1. Дараах цонх гарч ирвэл хэвлэлтийг цуцална уу.





Хорны картриджийг солих

Тэмдэглэл:
Хэрэв та компьютероосоо хэвлэлтийг цуцлах боломжгүй бол хэвлэгчийн хянах самбарыг ашиглан цуцална уу.

2. Принтерийн драйверийн цонхонд хандана.
3. **Хүрээгүй** гэснийг **Үндсэн** таб дээрээс арилга.
4. **Цулгуй цаас** эсвэл **Дугтуй**-г **Цаасны Төрөл** тохиргоо болгож **Үндсэн** таб дээр сонгоно.
5. **Грейскейл**-ийг сонго.
6. Шаардлагатай бол **Үндсэн** болон **Илүү Сонголтууд** таб дээрх бусад зүйлсийг тохируулсны дараа **OK**-г дарна.
7. **Хэвлэх** товчийг дар.
8. Гарч ирсэн цонхон дээрээс **Хараар Хэвлэх** гэснийг товш.

Холбогдох мэдээлэл

➡ 37 хуудас дээрх "Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах"
➡ 42 хуудас дээрх "Принтерийн үндсэн мэдээлэл — Windows"

Түр зуур хар хороор хэвлэх — Mac OS

Тэмдэглэл:
*Энэ үйлчилгээг сүлжээнд ашиглах бол **Bonjour**-тай холбогд.*

1. **Тавцан** дээрх принтерийн тэмдэг дээр дарна.
2. Ажлыг цуцална.

   Тэмдэглэл:
   Хэрэв та компьютероосоо хэвлэлтийг цуцлах боломжгүй бол хэвлэгчийн хянах самбарыг ашиглан цуцална уу.

3. **Системийн Тохируулгууд**-ыг цэс > **Принтер, Сканнер** (эсвэл **Хэвлэх, Сканнердах**, **Хэвлэх, Факсдах**)-аас сонгоод, дараа нь принтерийг сонго.**Сонголт & Хангамж** > **Сонголт** (эсвэл **Драйвер**) дээр дар.
4. **On**-ыг **Permit temporary black printing** тохиргоогоор сонго.
5. Принтерийн харилцах цонхонд хандана.
6. Дэлгэгддэг цэснээс **Хэвлэх Тохиргоо**-г сонгоно.
7. Хүрээгүй хэмжээнээс бусад бүх цаасны хэмжээг **Цаасны Хэмжээ** тохиргоогоор сонго.
8. **Цулгуй цаас** эсвэл **Дугтуй**-г **Media Type** тохиргоогоор сонго.
9. **Грейскейл**-ийг сонго.
10. Шаардлагатай бусад тохиргоог бас хийнэ.

11. **Хэвлэх** товчийг дар.

Холбогдох мэдээлэл

➡ 62 хуудас дээрх “Хэвлэхийг цуцлах”

➡ 37 хуудас дээрх “Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах”

➡ 43 хуудас дээрх “Хэвлэх үндсэн алхмууд Mac OS”

Хар хор дуусаж эхлэнгүүт хэмнэх (Зөвхөн Windows)

Хар хор дуусаж эхлэхэд хангалттай өнгөт хор байгаа үед та хар өнгө үүсгэх өнгөний нийлэмжийг ашиглах боломжтой. Та хар хорны картриджийг солихоор бэлдэх зуур үргэлжлүүлэн хэвлэх боломжтой.

Энэхүү үйлчилгээг зөвхөн дараах тохиргоог принтерийн драйв дээрээс сонгосон үед л ашиглах боломжтой.

❏ Цаасны Төрөл: **Цулгуй цаас**

❏ Чанар: **Стандарт**

❏ EPSON Status Monitor 3: Идэвхжүүлсэн

Тэмдэглэл:

❏ *Хэрэв **EPSON Status Monitor 3** идэвхижээгүй бол, принтерийн драйверт нэвтэрч, **Өргөтгөсөн Тохиргоо**-г **Арчилгаа** таб дээрээс сонгоод, **EPSON Status Monitor 3-г идэвхжүүл**-г сонгоно.*

❏ *Өнгө хольж гаргасан хар нь цэвэр хар өнгөнөөс бага зэрэг өөр харагддаг. Дээр нь принтерийн хурд удааширна.*

❏ *Принтерийн толгойны чанарыг хадгалахын тулд хор хорыг мөн зарцуулна.*



Сонголтууд	Тодорхойлолт
Тийм	Өнгө холихыг сонгож хар өнгө гаргаж ав. Таныг дараагийн удаа ямар нэг төстэй ажил хэвлэх үед энэ цонх харагдана.
Үгүй	Үргэлжлүүлэх сонгож үлдсэн хар хорыг ашигла. Таныг дараагийн удаа ямар нэг төстэй ажил хэвлэх үед энэ цонх харагдана.
Энэ үзүүлэлтийн хаа	Үргэлжлүүлэх сонгож үлдсэн хар хорыг ашигла. Хар хор дуусаж дахин сольтол энэ цонх харагдахгүй.

Принтерийг хадгалах

Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх

Цорго бөглөрсөн бол, хэвлэмэл материал бүдэг болж, зураас харагдаж, санаандгүй өнгөнүүд гарч ирнэ. Хэвлэлийн чанар муудсан бол, цорго шалгах тохиргоог ашиглаж, цорго бөглөрсөн эсэхийг шалгана. Цорго бөглөрсөн бол, принтерийн толгойг цэвэрлэнэ.

Чухал:

- ❏ *Толгойг цэвэрлэж байхад сканнерийн хэсгийг онгойлгож, принтерийн унтрааж болохгүй. Толгой цэвэрлэж дуусаагүй бол, та хэвлэх боломжгүй хэвээр байна.*
- ❏ *Принтерийн толгой цэвэрлэхэд тодорхой хэмжээгээр бэх хэрэглэдэг тул, чанар муудсан үед л принтерийн толгойг цэвэрлэнэ.*
- ❏ *Бэх бага болсон үед, хэвлэх толгойг цэвэрлэх боломжгүй байж магадгүй. Эхлээд бэхний гэрийг солино.*
- ❏ *Цорго шалгах, толгой цэвэрлэхээ бараг дөрвөн удаа давтсаны дараа ч хэвлэлийн чанар сайжрахгүй бол, хэвлэхгүйгээр зургаан цагаас доошгүй хүлээж, дараа нь цорго шалгахаа давтаж, шаардлагатай толгойг давтан цэвэрлэнэ. Бид принтерээ унтраахыг зөвлөж байна. Хэвлэлийн чанар сайжрахгүй хэвээр байвал, Epson тусламж үйлчилгээний албатай холбоо барина уу.*
- ❏ *Принтерийн толгойг хатахаас сэргийлэхийн тулд, тэжээл залгаатай байхад принтерийг тогноос салгаж болохгүй.*

Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх — Принтерийн товчлуур

1. A4 хэмжээтэй цулгуй цаасыг принтерт ачаална.
2. Принтерийг унтраахын тулд ⏻ товчийг дарна.
3. ⓥ товчийг дарж байх зуураа, принтерийг асаан, тэжээлийн гэрэл анивчиж эхлэнгүүт товчноос гараа авна.

   Цорго шалгах дүрсийг хэвлэнэ.

   Тэмдэглэл:
   Хошууг шалгах цаасыг хэвлэхэд хэсэг хугацаа шаардагдаж болно.

4. Хэвлэгдсэн дүрсийг шалга.Хэрэв "NG" дүрсэн дээр хугарсан шугам, хоосон хэсэг харагдаж байвал, принтерийн толгойн цорго бөглөрсөн байж болно.Дараагийн алхам руу шилж.Хэрэв "OK" дүрсэн дээр хугарсан шугам, хоосон хэсэг харагдахгүй байвал, принтерийн толгойн цорго бөглөрөөгүй байна.Принтерийн толгойг цэвэрлэх шаардлагагүй.



5. ⓥ товчийг 3 секундын турш дарангаа тэжээлийн гэрэл анивчих хүртэл үргэлжлүүлэн дарна.

   Принтерийн толгойн цэвэрлэгээ эхэлнэ.

   Тэмдэглэл:
   Толгой цэвэрлэх хэвлэж эхлэхэд хэсэг хугацаа шаардагдаж болно.

6. Тэжээлийн гэрэл анивчихаа болих үед, цорго шалгах дүрсийг дахин хэвлэнэ.Бүх шугам бүрэн хэвлэгдэх хүртэл цэвэрлэгээг давтаж, дүрс хэвлэхээ үргэлжлүүлнэ.

Холбогдох мэдээлэл

➡ 37 хуудас дээрх “Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах”

Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх — Windows

1. A4 хэмжээтэй ердийн цаасыг принтер дээр ачаална.
2. Принтерийн драйверийн цонхонд хандана.
3. **Хошуу Шалгах**-г **Арчилгаа** таб дээрээс дарна.
4. Дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Холбогдох мэдээлэл

➡ 37 хуудас дээрх “Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах”
➡ 98 хуудас дээрх “Windows принтерийн драйвер”

Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх — Mac OS

1. A4 хэмжээтэй цулгуй цаасыг принтерт ачаална.

2. **Системийн тохируулгууд**-ыг цэс > **Принтер & Сканнер** (эсвэл **Хэвлэх & Сканнердах**, **Хэвлэх & Факсдах**)-аас сонгоод дараа нь принтерээ сонго.
3. **Сонголт ба Хангамж** > **Хэрэгсэл** > **Принтерийн хэрэгслийг нээх** дээр дарна.
4. **Хошуу Шалгах** дээр дарна.
5. Дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Холбогдох мэдээлэл

➡ 37 хуудас дээрх "Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах"

Принтерийн толгойг тохируулна

Та босоо шугамын үл тохирол, эсвэл бүдэг зургийг ажиглавал, принтерийн толгойг тохируулна.

Принтерийн толгойг тохируулах — Windows

1. A4 хэмжээтэй цулгуй цаасыг принтерт ачаална.
2. Принтерийн драйверийн цонхонд хандана.
3. **Хэвлэх Толгой Зэрэгцүүлэлт**-г **Арчилгаа** таб дээрээс дарна.
4. Дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Холбогдох мэдээлэл

➡ 37 хуудас дээрх "Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах"
➡ 98 хуудас дээрх "Windows принтерийн драйвер"

Принтерийн толгойг тохируулна — Mac OS

1. A4 хэмжээтэй цулгуй цаасыг принтерт ачаална.
2. **Системийн тохируулгууд**-ыг цэс > **Принтер & Сканнер** (эсвэл **Хэвлэх & Сканнердах**, **Хэвлэх & Факсдах**)-аас сонгоод дараа нь принтерээ сонго.
3. **Сонголт ба Хангамж** > **Хэрэгсэл** > **Принтерийн хэрэгслийг нээх** дээр дарна.
4. **Print Head Alignment** дээр дарна.
5. Дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Холбогдох мэдээлэл

➡ 37 хуудас дээрх "Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах"

Цаас дамжих замыг цэвэрлэх

Хэвлэмэл материал бохирдож цоорсон байвал, доторх бортогыг цэвэрлэнэ.

> ***Чухал:***
> *Принтерийн доторхыг цэвэрлэхдээ ариун цэврийн цаас ашиглаж болохгүй. Принтерийн толгойн цорго ленттэйгээ бөглөрсөн байж болно.*

1. сканнерын шил болон баримтын таг дээр ямар ч тоос, толбо байлгаж болохгүй.
2. A4 хэмжээтэй цулгуй цаасыг принтерт ачаална.
3. Эх хувийг сканнерын шил дээр тавилгүйгээр хуулбарлаж эхэлнэ.
   Цаасыг принтерээс гаргалаа.
4. Цаас бэхээр бохирдохгүй болох хүртэл энэхүү үйл явцыг давтан явуулна.

Холбогдох мэдээлэл

➡ 63 хуудас дээрх “Хуулбарлах үндсэн мэдээлэл”

Сканнерын Шил-г цэвэрлэх

Хуулбарласан зүйл, эсвэл сканнердсан зургууд бохирдсон байвал, сканнерын шил-г цэвэрлэнэ үү.

> ***Чухал:***
> *Принтерийг цэвэрлэхдээ алкоголь болон шингэрүүлэгчийг хэзээ ч ашиглаж болохгүй. Эдгээр химийн бодис нь принтерт эвдрэл гэмтэл учруулж болно.*

1. Баримтын тагийг нээнэ.



2. сканнерын шил-н гадаргууг цэвэрлэхдээ хөнгөн, хуурай, цэвэр даавууг ашиглана.

> ***Чухал:***
>
> ❏ *Хэрэв шилний гадаргуун дээр өөх тос, эсвэл арилгахад хэцүү бусад материалын толбо суусан байвал, бага хэмжээний шил арчигчийг ашиглаж, зөөлөн даавуугаар арилгана. Үлдсэн бүх шингэнийг арчиж хатаана.*
>
> ❏ *Шилний гадаргуу дээр хэт чанга дарж болохгүй.*
>
> ❏ *Шилний гадаргууг зурах, эвдэлж гэмтээхгүйн тулд болгоомжтой арчина. Эвдэрч гэмтсэн шилэн гадаргуу сканы чанарыг бууруулах магадлалтай.*

Тунгалаг хальсийг цэвэрлэх

Принтерийн толгойг тэгшлэх эсвэл цаасны замыг цэвэрлэсний дараа хэвлэлт сайжрахгүй бол принтерийн доторх тунгалаг хальс бохирдсон байж болно.

Хэрэгтэй зүйлс:

❏ Хөвөн багс (хэд хэдэн)

❏ Хэдэн дусал угаалагын бодистой ус (аяганы 1/4 усанд 2 – 3 дусал угаалгын бодис)

❏ Бохирдлыг шалгах гэрэл

> ***Чухал:***
>
> *Угаалгын бодистой уснаас өөр цэвэрлэгээний бодис хэрэглэх шаардлагагүй.*

1. ⏻ товч дээр дарж принтерийг унтраана.

2. Сканнерийн нэгжийг нээнэ.



Принтерийг хадгалах

3. Тунгалаг хальс бохирдсон эсэхийг шалгана.Гэрэл ашиглавал бохирдлыг харахад дөхөм байна.

   Тунгалаг хальсанд (A) бохирдол (хурууны хээ эсвэл тос) үүссэн байвал дараагийн алхамруу шилжэнэ.



A: Тунгалаг хальс

B: Зам

> ***Чухал:***
>
> *Замд (B) хүрэхээс болгоомжил.Эс тэгвэл хэвлэх боломжгүй болж мэднэ.Зам дээрх тос нь үйл ажиллагаанд хэрэгцээтэй байдаг учир үүнийг арчиж болохгүй.*

4. Хөвөн багсыг угаалгын нунтагтай усаараа чийглээд ус дусахааргүй болгоод бохирдсон хэсгийг арчина.



> ***Чухал:***
> *Бохирдлыг зөөлөн арчина.Хэрвээ хальсыг хөвөнгөөр хэт хүчтэй дарвал пүрш нь байрлалаа алдаж принтер гэмтэх магадлалтай.*

5. Хальсыг арчихын тулд шинэ хуурай хөвөн багс ашиглаарай.

> ***Чухал:***
> *Хальсан дээр ямар ч сэмэрдэс үлдээж болохгүй.*

Тэмдэглэл:
Бохирдлыг тараахгүй байх үүднээс хөвөн багсаа байн байн шинээр солих хэрэгтэй.

6. Хальсны бохирдол байхгүй болтол үйлдлээ 4 – 5 удаа давтана.

7. Хальс бохирдолгүй болсон эсэхийг харж шалгана.

Эрчим хүч хэмнэх

Хэсэг хугацааны турш ямарваа ажиллагаа явагдаагүй бол принтер унтах горимд орж автоматаар унтарна. Эрчим хүчний удирдлага хэрэгжих хүртэлх хугацааг тохируулах боломжтой. Энэ хугацааг ямарваа нэг хэмжээгээр ихэсгэх нь принтерийн эрчим хүчний хэмнэлтэд нөлөөлнө. Тиймээс ямар нэг өөрчлөлт хийхээс өмнө байгаль орчинд үзүүлэх нөлөөг нь тунгаан бодоорой.

Эрчим хүч хэмнэх — Windows

1. Принтерийн драйверийн цонхонд хандана.

2. **Принтер болон Сонголтын Мэдээлэл**-г **Арчилгаа** таб дээрээс дарна.

3. **Унтах Цаг тоологч** -н тохиргоо болгож принтер унтах горимд орохоос өмнө цаг хугацаагаа сонгох ба улмаар **Илгээх** товчийг дарна. Принтерийг автоматаар унтраахын тулд, **Унтраах Цаг Тоологч** тохиргооноос цаг хугацааг сонгож **Илгээх** товч дээр дарна.

4. **OK** дээр дарна.

Холбогдох мэдээлэл

➡ 98 хуудас дээрх “Windows принтерийн драйвер”

Цахилгаан хэмнэх — Mac OS

1. **Системийн тохируулгууд**-ыг цэс > **Принтер & Сканнер** (эсвэл **Хэвлэх & Сканнердах**, **Хэвлэх & Факсдах**)-аас сонгоод дараа нь принтерээ сонго.

2. **Сонголт ба Хангамж** > **Хэрэгсэл** > **Принтерийн хэрэгслийг нээх** дээр дарна.

3. **Принтерийн Тохиргоо** дээр дарна.

Принтерийг хадгалах

4. **Унтах Цаг тоологч**-н тохиргоо болгож принтер унтах горимд орохоос өмнө цаг хугацаагаа сонгох ба улмаар **Хэрэглэх** товчийг дарна.Принтерийг автоматаар унтраахын тулд, **Унтраах Цаг Тоологч** тохиргооноос цаг хугацааг сонгож **Хэрэглэх** товч дээр дарна.

Сүлжээний үйлчилгээ болон программын мэдээлэл

Энэ хэсэгт Epson вэбсайт эсвэл дагалдах программ хангамжийн диск дээрх, таны принтерт зориулсан сүлжээний үйлчилгээ болон программ хангамжийн бүтээгдэхүүнийг танилцуулах болно.

Epson Connect үйлчилгээ

Интернэт дээр бэлэн байгаа Epson Connect үйлчилгээг ашигласнаар, та ухаалаг утас, таблет компьютер, эсвэл нөтбүүкээсээ хэзээд ч хаанаас ч хэвлэх боломжтой.

Интернэт дээр бэлэн байгаа үйлчилгээний шинж чанарыг доор харуулав.

Email Print	Epson iPrint алсын принтер	Scan to Cloud	Remote Print Driver
✓	✓	–	✓

Дэлгэрэнгүй мэдээллийг Epson Connect портал вэбсайтаас үз.

https://www.epsonconnect.com/

http://www.epsonconnect.eu (Зөвхөн Европод)

Web Config

Web Config нь Internet Explorer, Safari зэрэг вэб хөтчөөр дамжуулж компьютер, эсвэл ухаалаг төхөөрөмж дээр ажилладаг программ хангамж юм. Та принтерийн төлөвийг баталгаажуулж, сүлжээний үйлчилгээ болон принтерийн тохиргоог өөрчилж болно. Web Config-г ашиглахын тулд, принтер, компьютер, эсвэл төхөөрөмжөө нэг сүлжээнд холбох хэрэгтэй.

Тэмдэглэл:
Дараах хөтчийг дэмжиж ажилладаг.

Үйлдлийн систем	Хөтөч
Windows XP буюу түүнээс хойших	Internet Explorer 8 эсвэл түүнээс хойших, Firefox*, Chrome*
Mac OS X v10.6.8 буюу түүнээс хойших	Safari*, Firefox*, Chrome*
iOS*	Safari*
Android 2.3 буюу түүнээс хойших	Өгөгдмөл хөтөч
Chrome OS*	Өгөгдмөл хөтөч

* Хамгийн сүүлийн хувилбарыг хэрэглэх.

Web Config-г вэб хөтөч дээр ажиллуулах

1. Принтерийн IP хаягаа шалгах.

   Сүлжээний төлөвийн мэдээллээ хэвлэхийн тулд товчийг дор хаяж 10 секунд дарж, дараа нь принтерийн IP хаягийг шалгана уу.

2. Вэб хөтчийг компьютер, эсвэл ухаалаг төхөөрөмжөөсөө ажиллуулж, дараа нь принтерийн IP хаягийг оруулна.

   Формат:

   IPv4: http://принтерийн IP хаяг/

   IPv6: http://[принтерийн IP хаяг]/

   Жишээ:

   IPv4: http://192.168.100.201/

   IPv6: http://[2001:db8::1000:1]/

   Тэмдэглэл:
   Ухаалаг төхөөрөмж ашигласнаар та Web Config-г Epson iPrint-н засвар үйлчилгээний дэлгэцнээс ажиллуулж болно.

Холбогдох мэдээлэл

➡ 61 хуудас дээрх "Epson iPrint ашиглан хэвлэх"

Web Config-г Windows дээр ажиллуулах

WSD ашиглан принтерт компьютерийг холбоход Web Config-г ажиллуулахын тулд доорх алхмуудыг дагана уу.

1. Windows дээрх төхөөрөмж, принтерийн дэлгэц рүү хандана.
   - ❏ Windows 10

     Эхлэл товч дээр баруун товшиж, дараа нь **Хяналтын самбар** > **Техник хангамж ба принтерийг харах** гэснийг **Техник хангамж ба дуу** дээрээс сонго.
   - ❏ Windows 8.1/Windows 8

     Десктоп > **Тохиргоо** > **Хяналтын самбар** > **Техник хангамж, принтерийг харах**-г **Техник хангамж ба дуу** (эсвэл **Техник хангамж**) дээрээс сонгоно.
   - ❏ Windows 7

     Старт товч дээр дарж, **Хяналтын самбар** > **Техник хангамж, принтерийг харах**-г **Техник хангамж ба дуу** дээрээс сонгоно.
   - ❏ Windows Vista

     Старт товч дээр дарж, **Хяналтын самбар** > **Принтер**-г **Техник хангамж ба дуу** дээрээс сонгоно.

2. Принтер дээрээ хулганы баруун товчийг дарж, **Үзүүлэлт**-г сонгоно.

3. **Вэбийн үйлчилгээ** табыг сонгож, URL дээр дарна.

Web Config-г Mac OS дээр ажиллуулах

1. **Системийн Тохируулгууд**-ыг цэс > **Принтер & Сканнер** (эсвэл **Хэвлэх & Сканнердах**, **Хэвлэх & Факсдах**)-аас сонгоод, дараа нь принтерийг сонго.

2. **Сонголт ба хангамж** > **Принтерийн вэб хуудсыг харуулах** дээр дарна.

Windows принтерийн драйвер

Принтерийн драйвер нь бусад програмаас авсан хэвлэх командын дагуу принтерийг удирддаг. Принтерийн драйвер дээр тохиргоог хийх нь хамгийн сайн хэвлэлтийн үр дүнд хүргэнэ. Мөн принтерийн драйверийн хэрэглүүрийг ашиглан принтерийн төлвийг шалган, үйл ажиллагаа явуулах хамгийн сайн нөхцлийг хангах боломжтой.

Тэмдэглэл:
*Та принтерийн драйверийн хэлийг өөрчилж болно. **Хэл** тохиргооноос **Арчилгаа** таб дээрээс та хэрэглэхийг хүсэж буй хэлээ сонгоно.*

Программ хангамжаас принтерийн драйверт хандах

Таны ашиглаж буй программ хангамжид зориулсан тохиргоог хийхийн тулд, тус программ хангамжаас драйверт хандана.

Хэвлэх эсвэл **Хэвлэх Тохируулга**-г **Файл** цэснээс сонгоно. Принтерээ сонгож, дараа нь **Тохиргоо** эсвэл **Үзүүлэлт** дээр дарна.

Тэмдэглэл:
Програмаас шалтгаалж үйлдлүүд нь ялгаатай байна. Дэлгэрэнгүй мэдээллийг програмын тусламжаас үзнэ үү.

Хяналтын самбараас принтерийн драйверт хандах

Бүх программ хангамжид ашиглаж болох тохиргоог хийхийн тулд хяналтын самбараас драйверт хандана.

❏ Windows 10

Эхлэл товч дээр баруун товшиж, дараа нь **Хяналтын самбар** > **Техник хангамж ба принтерийг харах** гэснийг **Техник хангамж ба дуу** дээрээс сонго. Принтер дээрээ хулганы баруун товчийг дарах эсвэл түүн дээр дарж байгаад **Хэвлэх тохиргоо**-г сонгоно.

❏ Windows 8.1/Windows 8

Десктоп > **Тохиргоо** > **Хяналтын самбар** > **Төхөөрөмж, принтер харах**-г **Техник хангамж ба дуу** дээрээс сонгоно. Принтер дээрээ хулганы баруун товчийг дарах эсвэл түүн дээр дарж байгаад **Хэвлэх тохиргоо**-г сонгоно.

❏ Windows 7

Старт товч дээр дарж, **Хяналтын самбар** > **Техник хангамж, принтерийг харах**-г **Техник хангамж ба дуу** дээрээс сонгоно. Принтер дээрээ хулганы баруун товчийг дарж **Хэвлэх тохиргоо**-г сонгоно.

❏ Windows Vista

Старт товч дээр дарж, **Хяналтын самбар** > **Принтер**-г **Техник хангамж ба дуу** дээрээс сонгоно. Принтер дээрээ хулганы баруун товчийг дарж **Хэвлэх тохиргоог сонгох**-г сонгоно.

❑ Windows XP

Старт товч дээр дарж, **Хяналтын самбар** > **Принтер ба бусад Техник хангамж** > **Принтер ба Факс**-г сонгоно. Принтер дээрээ хулганы баруун товчийг дарж **Хэвлэх тохиргоо**-г сонгоно.

Ажлын мөрөн дээрх принтерийн тэмдгээс принтерийн драйверт хандах

Десктопын ажлын мөрөн дээрх принтерийн тэмдэг нь принтерийн драйверт хурдан хандах боломж олгох товчилбор тэмдэг юм.

Та принтерийн тэмдэг дээр дарж **Принтерийн Тохиргоо**-г сонговол, хяналтын самбараас дамжиж ордог принтерийн тохиргооны цонхтой ижил цонх руу хандах боломжтой. Хэрэв та энэхүү тэмдэг дээр хулганаа хоёр товшвол, та принтерийн төлөвийг шалгах боломжтой.

Тэмдэглэл:
Принтерийн тэмдэг ажлын мөр дээр харагдахгүй байвал, принтерийн драйверийн цонх руу орж ***Ажиглалтын Тохируулгууд****-г* ***Арчилгаа*** *таб дээрээс дараад* ***Товчилбор тэмдэгийг таскбарт бүртгүүл****-г сонгоно.*

Хэрэгслийг эхлүүлэх

Принтерийн драйверийн цонхонд хандана. **Арчилгаа** табыг товшино.

Windows принтерийн драйверын заавар

Windows-н принтерийн драйверийн тусламж үйлчилгээг авах боломжтой. Зүйлсийг тохируулах талаарх тайлбарыг харахын тулд, зүйлс бүр дээр хулганы баруун товчийг дарж, дараа нь **Тусламж** дээр дарна уу.

Үндсэн таб

Та цаасны төрөл, цаасны хэмжээ зэрэг принтерийн үндсэн тохиргоог хийж болно.

Сүлжээний үйлчилгээ болон программын мэдээлэл

Түүнчлэн, та цаасны хоёр талд хэвэл, эсвэл нэг хуудсан дээр олон хуудсыг хэвлэх тохиргоог хийж болно.



Илүү Сонголтууд таб

Хэвлэмэл материалын хэмжээг өөрчлөх, өнгөний засвар хийх зэрэг загвар, хэвлэлийн нэмэлт сонголтыг хийж болно.



Арчилгаа таб

Та цорго шалгах, принтерийн толгой цэвэрлэх зэрэг засвар үйлчилгээний тохиргоог ажиллуулж болно. Түүнчлэн, та **EPSON Status Monitor 3**-г ажиллуулснаар принтерийн төлөв, алдааны мэдээллийг шалгах боломжтой.



Windows принтерийн драйверт ашиглалтын тохиргоог хийх

EPSON Status Monitor 3-г идэвхжүүлэх зэрэг тохиргоог хийж болно.

1. Принтерийн драйверийн цонхонд хандана.
2. **Өргөтгөсөн Тохиргоо**-г **Арчилгаа** таб дээрээс дарна.
3. Зохих тохиргоог хийж, дараа нь **OK**-г дарна.

   Зүйлсийг тохируулах тайлбарыг онлайн тусламжаас харна уу.

Холбогдох мэдээлэл

➡ 98 хуудас дээрх “Windows принтерийн драйвер”

Mac OS принтерийн драйвер

Принтерийн драйвер нь бусад програмаас авсан хэвлэх командын дагуу принтерийг удирддаг.Принтерийн драйвер дээр тохиргоог хийх нь хамгийн сайн хэвлэлтийн үр дүнд

хүргэнэ.Мөн принтерийн драйверийн хэрэглүүрийг ашиглан принтерийн төлвийг шалган, үйл ажиллагаа явуулах хамгийн сайн нөхцлийг хангах боломжтой.

Программ хангамжаас принтерийн драйверт хандах

Цаасны Тохируулга буюу **Хэвлэх**-ийг програмынхаа **Файл** цэснээс дар.Хэрэв шаардлагатай бол, **Дэлгэрэнгүйг Харуулах** (эсвэл ▼)-г дарж хэвлэх цонхыг томруулж болно.

Тэмдэглэл:
*Хэрэглэж байгаа програмаас шалтгаалж, **Цаасны Тохируулга** нь **Файл** цэсэд байхгүй байж магадгүй ба хэвлэх цонхыг харуулах үйлдлүүд өөр байж бас магадгүй.Дэлгэрэнгүй мэдээллийг програмын тусламжаас үзнэ үү.*

Хэрэгслийг эхлүүлэх

Системийн Тохируулгууд-ыг цэс > **Принтер, Сканнер** (эсвэл **Хэвлэх, Сканнердах**, **Хэвлэх, Факсдах**)-аас сонгоод, дараа нь принтерийг сонго.**Сонголт ба Хангамж** > **Хэрэгсэл** > **Принтерийн хэрэгслийг нээх** дээр дарна.

Mac OS принтерийн драйверын заавар

Принтерийн харилцах цонх

Илүү олон зүйлсийг харуулахын тулд дэлгэцийн төвд буй дэлгэгддэг цэс рүү шилжинэ.



Ил харагдах цэс	Тодорхойлолт
Бүдүүвч	Нэг хуудсан дээр олон хуудас хэвлэх загварыг сонгож болох ба хүрээг хэвлэх сонголт хийж болно.
Өнгө тохируулах	Та өнгөө тохируулж болно.

Сүлжээний үйлчилгээ болон программын мэдээлэл

Ил харагдах цэс	Тодорхойлолт
Цаас ашиглах	Таны ачаалсан цаасны хэмжээтэй автоматаар тохируулахаар хэвлэлийн ажлын хэмжээгээ бууруулж эсвэл нэмэгдүүлж болно.
Нүүр хуудас	Та өөрийн баримтад нүүр сонгох боломжтой.Нүүрэн дээр хэвлэгдэх агуулгын тавихын тулд **Нүүрэн хуудасны төрөл**-г сонго.
Хэвлэх Тохиргоо	Цаасны төрөл, хэвлэх чанар зэрэг хэвлэх үндсэн тохиргоог хийж болно.
Color Options	**EPSON Color Controls**-ийг **Өнгө Тааруулах** цэснээс сонгох үед, өнгө засалтын аргыг сонгох боломжтой.

Тэмдэглэл:
*OS X Mountain Lion болон дараагийн хувилбаруудад **Хэвлэх Тохиргоо** цэс гарч ирэхгүй бол, Epson-н принтерийн драйверыг зөв суулгаагүй байна гэсэн үг.*

***Системийн тохируулгууд**-г цэс > **Принтер & Сканнер** (эсвэл **Хэвлэх & Сканнердах**, **Хэвлэх & Факсдах**)-аас сонгож, принтерийг устгаад дахин нэмнэ.Дараах вэбсайтаас нэвтэрч бүтээгдэхүүний нэрээ оруулна уу.Дэмжлэг үүсгэх очоод санууулгыг хараарай.*

http://epson.sn

Epson Printer Utility

Та цорго шалгах, принтерийн толгой цэвэрлэх зэрэг засвар үйлчилгээний тохиргоог ажиллуулж болно. Түүнчлэн, та **EPSON Status Monitor**-г ажиллуулснаар принтерийн төлөв, алдааны мэдээллийг шалгах боломжтой.



Mac OS принтерийн драйверт ашиглалтын тохиргоог хийх

Mac OS принтерийн драйверын үйлдлийн тохиргооны цонхонд нэвтрэх

Системийн Тохируулгууд-ыг цэс > **Принтер & Сканнер** (эсвэл **Хэвлэх & Сканнердах**, **Хэвлэх & Факсдах**)-аас сонгоод, дараа нь принтерийг сонго. **Сонголт & Хангамж** > **Сонголт** (эсвэл **Драйвер**) дээр дар.

Mac OS принтерийн драйверын үйлдлийн тохиргоонууд

- ❏ Хоосон Хуудсыг Алгас: Хоосон хуудсыг хэвлэхээс сэргийлнэ.
- ❏ Чимээгүй Горим: Хэвлэгчийн чимээг бууруулах ч хэвлэлтийн хурдыг удаашруулж болзошгүй. Таны сонгосон цаасны төрөл ба хэвлэлтийн чанарын тохиргооноос хамаарч, хэвлэгчийн оновчлолын түвшинд ялгаа гарахгүй байж болзошгүй.
- ❏ Permit temporary black printing: Түр хугацаагаар зөвхөн хар хороор хэвлэнэ.
- ❏ High Speed Printing: Принтерийн толгой хоёр чиглэлд хөдлөх үед хэвлэнэ. Хэвлэх хурд илүү хурдан боловч, хэвлэлтийн чанар муудаж магадгүй.
- ❏ Warning Notifications: Анхааруулгын мэдэгдлийг харуулах боломжоор принтерийн драйверийг хангана.
- ❏ Establish bidirectional communication: Ихэнх тохиолдолд үүнийг **On** байлгах шаардлагатай. **Off**-г, принтерийг сүлжээн дээр Windows компьютерүүдтэй хуваалцан хэрэглэж байгаа буюу бусад ямарваа шалтгааны улмаас принтерийн мэдээллийг авах боломжгүй үед хэрэглэнэ.

Холбогдох мэдээлэл

➡ 84 хуудас дээрх “Түр зуур хар хороор хэвлэх”

Epson Scan 2 (Сканнерийн драйвер)

Epson Scan 2 нь скандах үйл ажиллагааг хянадаг программ хангамж юм.Та скандах зурагны хэмжээ, нягтрал, цайвар, өнгө ялгарал, чанарыг тохируулж болно.

Тэмдэглэл:
Түүнчлэн, та TWAIN тохируулгатай сканы программ хангамжаас Epson Scan 2-г ажиллуулж болно.

Windows дээр асаах

- ❏ Windows 10

  Эхлэл товч дээр товшиж, дараа нь **EPSON** > **Epson Scan 2** сонго.

- ❏ Windows 8.1/Windows 8

  Хайлтын талбар дээр программ хангамжийн нэрийг оруулж, дараа нь гарч ирсэн тэмдгийг сонгоно.

❏ Windows 7/Windows Vista/Windows XP

Эхлэх товч дээр дарж, дараа нь **Бүх программ** эсвэл **Программууд** > **EPSON** > **Epson Scan 2**> **Epson Scan 2** гэснийг сонго.

Mac OS дээр асаах

Тэмдэглэл:
Epson Scan 2 нь Mac OS-н хэрэглэгчийг хурдан солих тохиргоог дэмждэггүй.Хэрэглэгчийг хурдан солих тохиргоог унтраана.

Очих > **Программууд** > **Epson Software** > **Epson Scan 2**-г сонго.

Холбогдох мэдээлэл

➡ 109 хуудас дээрх "Программ хангамжийг устгах"

Epson Event Manager

Epson Event Manager нь үйл ажиллагааны менежер нь хяналтын самбараас скандах ажиллагааг удирдах, компьютерт зураг хадгалах боломж олгодог программ хангамж юм.Та баримт бичгийн төрөл, хадгалах хавтасны байрлал, зургийн формат зэрэг өөрийн тохиргоогоо урьдчилсан тохиргоо байдлаар нэмж болно.Дэлгэрэнгүй мэдээллийг програмын тусламжаас үзнэ үү.

Windows дээр асаах

❏ Windows 10

Эхлэх товч дээр дарж, дараа нь **Epson Software** > **Event Manager** сонгоно уу.

❏ Windows 8.1/Windows 8

Хайлтын талбар дээр программ хангамжийн нэрийг оруулж, дараа нь гарч ирсэн тэмдгийг сонгоно.

❏ Windows 7/Windows Vista/Windows XP

Старт товч дээр дарж **Бүх программ** эсвэл **Программууд** > **Epson Software** > **Event Manager**-г сонгоно.

Mac OS дээр асаах

Шилжих > **Программ хангамж** > **Epson Software** > **Event Manager**-г сонгоно.

Холбогдох мэдээлэл

➡ 64 хуудас дээрх "Хяналтын самбараас скандах"

➡ 109 хуудас дээрх "Программ хангамжийг устгах"

Epson Easy Photo Print

Epson Easy Photo Print нь төрөл бүрийн загвартайгаар фото зураг хялбараар хэвлэх боломж олгодог программ хангамж юм.Та фото зургийг урьдчилан харж, зураг эсвэл байрлалыг нь тохируулах боломжтой.Түүнчлэн, та фото зургаа хүрээтэйгээр хэвлэж болно.Дэлгэрэнгүй мэдээллийг програмын тусламжаас үзнэ үү.

Тэмдэглэл:
Энэхүү программ хангамжийг ашиглахын тулд принтерийн драйверийг суулгах шаардлагатай.

Windows дээр асаах

❏ Windows 10

Эхлэх товч дээр дарж, дараа нь **Epson Software** > **Epson Easy Photo Print**-г сонгоно.

❏ Windows 8.1/Windows 8

Хайлтын талбар дээр программ хангамжийн нэрийг оруулж, дараа нь гарч ирсэн тэмдгийг сонгоно.

❏ Windows 7/Windows Vista/Windows XP

Эхлэх товч дээр дарж **Бүх программ** эсвэл **Программууд** > **Epson Software** > **Epson Easy Photo Print**-г сонгоно.

Mac OS дээр асаах

Очих > **Программууд** > **Epson Software** > **Epson Easy Photo Print**-г сонго.

Холбогдох мэдээлэл

➡ 109 хуудас дээрх "Программ хангамжийг устгах"

E-Web Print (зөвхөн Windows-д зориулсан)

E-Web Print нь төрөл бүрийн загвартайгаар вэб хуудас хялбараар хэвлэх боломж олгодог программ хангамж юм. Дэлгэрэнгүй мэдээллийг програмын тусламжаас үзнэ үү. Та тусламж руу **E-Web Print** цэснээс **E-Web Print** багажийн мөр дээрээс орж болно.

Тэмдэглэл:
Дэмждэг вэб хөтөч болон татах сайтаас хамгийн сүүлийн үеийн хувилбарыг шалгана уу.

Асаах

E-Web Print-г суулгах үед, энэ нь таны вэб хөтөч дээр харагдана. **Print** эсвэл **Clip** дар.

Холбогдох мэдээлэл

➡ 109 хуудас дээрх "Программ хангамжийг устгах"

Easy Photo Scan

Easy Photo Scan нь танд фото сканнердах, сканнердсан зургаа компьютер эсвэл үүлэн үйлчилгээнд хялбархан илгээх боломж олгох программ юм. Та мөн сканнердсан зургаа хялбархан тохируулах боломжтой. Дэлгэрэнгүй мэдээллийг програмын тусламжаас үзнэ үү.

Тэмдэглэл:
Энэхүү программ хангамжийг ашиглахын тулд сканнерийн драйвер Epson Scan 2-ийг суулгах шаардлагатай.

Windows дээр асаах

❏ Windows 10

Эхлэх товчийг товшиж, дараа нь **Бүх программ** > **Epson-ы программ хангамж** > **Хялбар Фото Скан** гэснийг сонго.

❏ Windows 8.1/Windows 8

Хайлтын талбар дээр программ хангамжийн нэрийг оруулж, дараа нь гарч ирсэн тэмдгийг сонгоно.

❏ Windows 7/Windows Vista/Windows XP

Старт товч дээр дарж **Бүх программ** эсвэл **Программууд** > **Epson Software** > **Easy Photo Scan**-г сонгоно.

Mac OS дээр асаах

Шилжих > **Программ хангамж** > **Epson Software** > **Easy Photo Scan**-г сонгоно.

Холбогдох мэдээлэл

➡ 109 хуудас дээрх "Программ хангамжийг устгах"

EPSON Software Updater

EPSON Software Updater нь интернэт дээр шинэ эсвэл шинэчилсэн программ хангамж байгаа эсэхийг шалгаж түүнийг суулгадаг программ хангамж юм.Түүнчлэн, та принтерийн компаниас гаргасан программ хангамж, гарын авлагыг шинэчилж болно.

Windows дээр асаах

❏ Windows 10

Эхлэл товч дээр товшиж, дараа нь **Epson Software** > **EPSON Software Updater** сонго.

❏ Windows 8.1/Windows 8

Хайлтын талбар дээр программ хангамжийн нэрийг оруулж, дараа нь гарч ирсэн тэмдгийг сонгоно.

❏ Windows 7/Windows Vista/Windows XP

Эхлэх товч дээр дарж, дараа нь **Бүх программ** (эсвэл **Программууд**) > **Epson Software** > **EPSON Software Updater** гэснийг сонго.

Тэмдэглэл:
*Түүнчлэн, та десктопын ажлын мөр дээрх принтерийн тэмдэг дээр дарж, дараа нь EPSON Software Updater-г сонгосноор **Програмын Шинэчлэл**-г эхлүүлж болно.*

Mac OS дээр асаах

Очих > **Программууд** > **Epson Software** > **EPSON Software Updater**-г сонго.

Холбогдох мэдээлэл

➡ 109 хуудас дээрх "Программ хангамжийг устгах"

Программ хангамжийг суулгах

Тэмдэглэл:
Компьютер руу админы эрхээр нэвтэрнэ. Компьютер танаас шаардвал админы нууц үгийг оруулна.

Программ хангамжийг устгах — Windows

1. Принтерийг унтраахын тулд ⏻ товчийг дарна.
2. Ажиллаж буй бүх программ хангамжаас гарч хаана.
3. **Хяналтын самбар**-г нээнэ:
   - ❏ Windows 10
     Эхлэх товчийг баруун товш эсвэл удаан дараад **Хянах самбар** гэснийг сонго.
   - ❏ Windows 8.1/Windows 8
     Десктоп > **Тохиргоо** > **Хяналтын самбар**-г сонгоно.
   - ❏ Windows 7/Windows Vista/Windows XP
     Старт товч дээр дарж **Хяналтын самбар**-г сонгоно.
4. **Программ хангамжийг устгах**-г нээнэ (эсвэл **Программ хангамжийг нэмэх эсвэл устгах**):
   - ❏ Windows 10/Windows 8.1/Windows 8/Windows 7/Windows Vista
     Программыг устгах-г **Программууд** дээрээс сонгоно.
   - ❏ Windows XP
     Программ хангамжийг нэмэх эсвэл устгах дээр дарна.
5. Устгахыг хүсэж буй программ хангамжаа сонгоно.
6. Программ хангамжийг устгах:
   - ❏ Windows 10/Windows 8.1/Windows 8/Windows 7/Windows Vista
     Устгах/Өөрчлөх эсвэл **Устгах** дээр дарна.
   - ❏ Windows XP
     Өөрчлөх/Устгах эсвэл **Устгах** дээр дарна.

   Тэмдэглэл:
   Хэрэглэгчийн дансны хяналт*-н цонх гарч ирвэл,* ***Үргэлжлүүлэх*** *дээр дарна.*
7. Дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Програм суулгах- Mac OS

1. Uninstaller-г EPSON Software Updater ашиглаж татаж авна.

   Uninstaller-г татаж авсны дараа, та тус программ хангамжийг устгах бүртээ үүнийг дахин татаж авах шаардлагагүй болно.

2. Принтерийг унтраахын тулд ⏻ товчийг дарна.

3. Принтерийн драйверийг устгахдаа **Системийн тохиргоо**-г цэсээс > **Принтер & Сканнер** сонгоод (эсвэл **Хэвлэх & Скандах**, **Хэвлэх & Факсдах**) идэвхжүүлсэн принтерийн жагсаалтаас принтерийн устгана.

4. Ажиллаж буй бүх программ хангамжаас гарч хаана.

5. **Очих** > **Программууд** > **Epson Software** > **Uninstaller**-г сонго.

6. Устгахыг хүсэж буй программ хангамжаа сонгож, дараа нь **Uninstall** дээр дарна.

> ***Чухал:***
> *Uninstaller нь компьютер дээрх Epson бэхээр ажилладаг принтерийн бүх драйверийг устгана.Та Epson бэхээр ажилладаг олон тооны принтер ашиглаж бөгөөд та тэдгээрийн заримыг устгахыг хүсэж байгаа бол,эхлээд тэдгээрийг бүгдийг устгаад дараа нь шаардлагатай принтерийн драйверийг дахин суулгана.*

Тэмдэглэл:
*Та программ хангамжийн жагсаалт дээр устгахыг хүсэж буй программ хангамжаа олж чадахгүй байвал, Uninstaller устгагчийг ашиглаж устгаж чадахгүй.Энэ тохиолдолд, **Шилжих** > **Програмууд** > **Epson Software** руу орж, устгахыг хүсэж буй программ хангамжаа сонгож дараа нь түүнийг хогийн савын тэмдэг рүү зөөнө.*

Холбогдох мэдээлэл

➡ 109 хуудас дээрх "Программ хангамжийг устгах"

Программ хангамжийг устгах

Компьютероо сүлжээнд холбож вэбсайтаас програмын хамгийн сүүлийн хувилбарыг татаарай.

Тэмдэглэл:
❏ *Компьютер руу админы эрхээр нэвтэрнэ. Компьютер танаас шаардвал админы нууц үгийг оруулна.*

❏ *Программ хангамжийг дахин суулгах үед, та үүнийг эхлээд устгах шаардлагатай.*

1. Ажиллаж буй бүх программ хангамжаас гарч хаана.

2. Принтерийн драйвер эсвэл Epson Scan 2 суулгах үед, принтер, компьютер хоёрыг түр хугацаагаар салгана.

   Тэмдэглэл:
   Таныг холбо гэж заавар өгөх хүртэл принтер, компьютер хоёрыг холбож болохгүй.

3. Доорх вэбсайт дээрх зааврыг дагаж программ хангамжийг суулгана.

   http://epson.sn

   Тэмдэглэл:
   Хэрэв та Windows хэрэглэж байгаа ба вэбсайтаас програмыг татаж авч чадахгүй байвал, принтертэй хамт ирсэн програм хангамжийн дискнээс суулгаж болно.

Холбогдох мэдээлэл

➡ 108 хуудас дээрх "Программ хангамжийг суулгах"

Программ хангамж, компанийн программыг шинэчлэх

Та программ хангамж, компанийн программыг шинэчилснээр тодорхой асуудлыг шийдэж, үүрэг ажиллагааг сайжруулан мөн нэмэх боломжтой. Та программ хангамж, компанийн программын хамгийн сүүлийн үеийн хувилбарыг ашиглаж байгаагаа баталгаажуулна уу.

1. Принтер, компьютер хоёр холбогдсон бөгөөд компьютер интернэтэд холбогдсон эсэхийг шалгана уу.

2. EPSON Software Updater-г асааж, программ хангамж болон компанийн программ хангамжийг шинэчилнэ.

> ***Чухал:***
> *Шинэчилж байхдаа компьютер, принтерээ унтрааж болохгүй.*

Тэмдэглэл:
Та жагсаалт дээр шинэчлэхийг хүсэж буй программ хангамжаа олж чадахгүй байвал, EPSON Software Updater-г ашиглаж шинэчилж чадахгүй. Программ хангамжийн хамгийн сүүлийн хувилбарыг Epson-н вэбсайтаас шалгана.

http://www.epson.com

Холбогдох мэдээлэл

➡ 107 хуудас дээрх "EPSON Software Updater"

Асуудлыг шийдэх

Принтерийн төлөвийг шалгах

Принтер дээрх алдаа заагчийг шалгах

Алдаа гарсан үед гэрэл асаж анивчих болно. Алдааны дэлгэрэнгүй мэдээлэл компьютерын дэлгэц дээр гарах болно.

■: Асаалттай

: Удаан анивчина

: Хурдан анивчина

Гэрэл	Нөхцөл байдал	Шийдлүүд
	Ямар ч цаас ачаалаагүй байна, эсвэл нэг удаад нэгээс олон цаасыг тэжээл дээр тавьж байна.	Цаасыг ачаалж эсвэл товчийг дарна.
	Цаас бөглөрсөн байна.	Цаасыг салгаж эсвэл товчийг дарна.
	Картриджийн хор дууссан эсвэл цэнэглэх хангалтай хор картриджанд алга.	Та дээд зэргийн хэвлэлийн чанараар хэвлэж, өөрийн принтерийн толгойг хамгаалж байхын тулд, таны принтерийн картриджийг солих цаг болсныг илтгэх үед картриджанд бэхний аюулгүй ажиллагааны тодорхой хэмжээний нөөц үлдэнэ. Шинэ хорны хайрцгаар соль.
	Картриджийг суурьлуулаагүй байна.	Картриджийг суурьлуул.
	Картриджийг танихгүй байна.	Хорны хайрцгийг чангаар доош дар.
	Дэмждэггүй хорны хайрцгийг суурьлуулсан байна.	Энэ хэвлэгчийг дэмджэг хорны хайрцгийг суурьлуул. Солиулахаар принтертэй цуг ирсэн картриджийг та ашиглах боломжгүй.
	Картридж бараг дуусаж байна. Та ● гэрлийг астал хэвлэх боломжтой.	Шинэ картриджийг бэлдэнэ үү. Та хорны түвшинг компьютероосоо шалгах боломжтой.

Асуудлыг шийдэх

Гэрэл	Нөхцөл байдал	Шийдлүүд
	гэрэл ба гэрэл хоёр ээлжлэн анивчиж байна. Бэхний тавцан ажиллагааны хугацааны төгсгөл рүүгээ ойртож байна эсвэл дууссан байна.	Хорны дэвсгэрийг* солих шаардлагатай. Epson болон Epson-н эрх бүхий үйлчилгээ үзүүлэгчтэй холбоо барьж бэхний тавцангаа солиулна уу*. Үүнд хэрэглэгчийн засаж болох сэлбэг хэрэгсэл орохгүй. Та хэвлүүлэхээс үргэлжлүүлж болно гэсэн мэдээлэл компьютер дээр гарвал, хэвлэхээ үргэлжлүүлэхийн тулд эсвэл товч дээр дарна уу. Тухайн цаг мөчид гэрэл анивчихаа болих боловч бэхний тавцанг солих хүртэл тэдгээр нь үргэлжлүүлэн анивчина.
	Принтерийн алдаа үүслээ.	Сканнерын хэсгийг нээж, принтер доторх аливаа цаас эсвэл хамгаалалтын материалыг салгана. Тэжээлийг унтрааж, дахин асаана. Хэрэв тэжээлийг унтрааж дахин асаасны дараа алдаа гарсан хэвээр байвал, Epson дэмжлэг үйлчилгээтэй холбоо барина уу.
	Wi-Fi холболтын алдаа үүслээ.	Алдааг арилгахын тулд Wi-Fi товчлуурыг дарж дахин оролдоно.
	Фирмварийн шинэчлэл амжилтгүй болсон тул принтер сэргээх горимд эхэллээ.	Доорх алхмыг дагаж фирмварийг дахин шинэчлэнэ үү. 1. Компьютер болон принтерийг USB кабелаар холбо. (Сэргээх горимын үед, фирмварийг сүлжээний холболтоор дамжуулж шинэчлэх боломжгүй.) 2. Дотоодынхоо Epson вэбсайт руу зочилж дэлгэрэнгүй зааврыг аваарай. Принтер программын шинэчлэлийн төлөвийг танд доорх байдлаар мэдэгдэнэ. Бэлтгэж байна: Сүлжээний төлөвийн гэрэл анивчина. Шинэчилж байна: Тэжээлийн гэрэл анивчина. Дууслаа: Тэжээлийн гэрэл асаалттай хэвээр байна.

* Зарим хэвлэх үйл явцад бэхний тавцан дээр маш бага хэмжээний илүүдэл бэх цуглардаг. Тавцангаас бэх асгарахаас сэргийлэхийн тулд, тавцан хязгаартаа хүрсэн үед принтерийг хэвлүүлэхийг зогсоохоор загварчилсан байдаг. Энэ үйл явц шаардагдах эсэх, хэр их шаардагдах эсэх нь таны хэвлэх хуудасны тоо, таны хэвлэж буй баримт бичгийн төрөл, принтерийн гүйцэтгэж буй цэвэрлэх үе шатны тооноос хамааран өөр өөр байна. Тавцанг солих шаардлагатай болох нь принтер техникийн зааварчилгааныхаа дагуу үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон гэсэн үг биш юм. Тавцанг хэзээ солих шаардлагатай болохыг принтер танд мэдэгдэх бөгөөд солихдоо Epson-н үйлчилгээ үзүүлэгчээр зөвхөн солиулах хэрэгтэй. Epson-н баталгаанд энэхүү солих зардлыг оруулдаггүй болно.

Холбогдох мэдээлэл

➡ 113 хуудас дээрх "Бөглөрсөн цаасыг салгах"

➡ 149 хуудас дээрх "Epson-н тусламжтай холбогдох"

➡ 109 хуудас дээрх "Программ хангамжийг устгах"

➡ 110 хуудас дээрх "Программ хангамж, компанийн программыг шинэчлэх"

Принтерийн төлөвийг шалгах — Windows

1. Принтерийн драйверийн цонхонд хандана.
2. **EPSON Status Monitor 3**-г **Арчилгаа** таб дээрээс дарна.

   Тэмдэглэл:

   ❑ *Түүнчлэн, ажлын мөр дээрх принтерийн тэмдэг дээр хулганаар хоёр товшиж принтерийн төлөвийг шалгаж болно. Принтерийн тэмдэг ажлын мөр дээр нэмэгдээгүй бол **Ажиглалтын Тохируулгууд**-г **Арчилгаа** таб дээрээс сонгоод дараа нь **Товчилбор тэмдэгийг таскбарт бүртгүүл**-г сонгоно.*

   ❑ ***EPSON Status Monitor 3**-г идэвхгүйжүүлсэн бол **Өргөтгөсөн Тохиргоо**-г **Арчилгаа** таб дээрээс сонгоод дараа нь **EPSON Status Monitor 3-г идэвхжүүл**-г сонгоно.*

Холбогдох мэдээлэл

➡ 98 хуудас дээрх "Windows принтерийн драйвер"

Принтерийн төлөвийг шалгах — Mac OS

1. **Системийн Тохируулгууд**-ыг цэс > **Принтер, Сканнер** (эсвэл **Хэвлэх, Сканнердах**, **Хэвлэх, Факсдах**)-аас сонгоод, дараа нь принтерийг сонго.
2. **Сонголт ба Хангамж** > **Хэрэгсэл** > **Принтерийн хэрэгслийг нээх** дээр дарна.
3. **EPSON Status Monitor** дээр дарна.

   Та принтерийн төлөв, хорны түвшин, алдааны статусыг шалгах боломжтой.

Бөглөрсөн цаасыг салгах

Аливаа урагдсан хэсгээс бүрдэх бөглөрсөн цаасыг салгахын тулд хяналтын самбар дээр гарсан алдааг шалгаж, зааврыг дагана уу. Дараа нь алдааг арилгана.

> ***Чухал:***
>
> *Бөглөрсөн цаасыг болгоомжтой салгана. Цаасыг хүчтэй салгавал принтерт эвдрэл гэмтэл учруулж болно.*

Холбогдох мэдээлэл

➡ 111 хуудас дээрх "Принтер дээрх алдаа заагчийг шалгах"

Арын Цаасны Дайз дотроос бөглөрсөн цаасыг салгах

Бөглөрсөн цаасыг салгана.



Гаргах тавиураас бөглөрсөн цаасыг салгах

Гацсан цаасыг авна.



Принтер дотроос бөглөрсөн цаасыг салгах

⚠ ***Болгоомжтой:***

- ❏ *Сканнерыг нээж хаах үедээ гар, хуруугаа хавчуулахаас болгоомжлоорой.Эс бөгөөс гэмтэх аюултай.*
- ❏ *Таны гар принтер дотор байх үед хяналтын самбар дээрх товчнуудад хүрч болохгүй.Принтер ажиллаж эхэлсэн бол, энэ нь биед гэмтэл учруулах боломжтой.Гэмтлээс сэргийлэхийн тулд цухуйсан хэсгүүдэд хүрэхгүй байхад анхаарах хэрэгтэй.*

Асуудлыг шийдэх

1. Баримтын тагийг хаалттай хэвээр сканнер төхөөрөмжийг нээнэ.



2. Гацсан цаасыг авна.



Чухал:

Принтерийн дотор талын гэрэлтсэн хальс эсвэл цагаан хавтгай кабель утсанд гараа хүргэхгүй байх.Ингэвэл, принтерийн ажиллагааг доголдуулахад хүргэж болно.



3. Сканнер төхөөрөмжийг хаана.



Цаас зөв татагдахгүй байвал

Асуудлыг шийдэхийн тулд, дараах зүйлсийг шалгаад, зохих арга хэмжээг авна уу.

- ❏ Принтерийг тэгш гадаргуу дээр тавьж, зөвлөмж болгосон орчны нөхцөлд ажиллуул.
- ❏ Энэхүү принтерийн дэмждэг цаасыг ашигла.
- ❏ Цаастай харьцах санамжийг дага.
- ❏ Тухайн цаасанд заасан хуудасны дээд тооноос илүү ихийг бүү ачаалаарай. Цулгүй цаасны хувьд, ирмэг заагч дээрх гурвалжин тэмдгийн заасан шугамаас дээш гаргаж ачаалахгүй байх хэрэгтэй.

Холбогдох мэдээлэл

➡ 145 хуудас дээрх “Орчны үзүүлэлт”
➡ 34 хуудас дээрх “Цаас ашиглахтай холбоотой анхааруулга”
➡ 35 хуудас дээрх “Бэлэн байгаа цаас ба багтаамж”

Цаас гацалт

- ❏ Цаасыг зөв чиглэлд ачаалж, ирмэг заагчийг цаасны ирмэгт тулгаж гулгуулна.
- ❏ Олон тооны цаасыг ачаалах үед нэг удаад нэг хуудас цаасыг ачаална.

Холбогдох мэдээлэл

➡ 113 хуудас дээрх “Бөглөрсөн цаасыг салгах”
➡ 37 хуудас дээрх “Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах”

Цаас хазайж татагдаж байвал

Цаасыг зөв чиглэлд ачаалж, ирмэг заагчийг цаасны ирмэгт тулгаж гулгуулна.

Холбогдох мэдээлэл

➡ 37 хуудас дээрх “Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах”

Нэг дор хэд хэдэн хуудас татагдвал

❏ Цаасыг нэг нэгээр нь ачаал.

❏ Гар аргаар 2-талт хэвлэлтийг гүйцэтгэх үед хэд хэдэн хуудас нэг зэрэг татагдаж байгаа бол, цаасыг дахин ачаалахын өмнө принтерт ачаалагдсан бүх цаасыг гарга.

Тэжээл ба хяналтын самбарын асуудал

Тэжээл асахгүй байна

❏ Тэжээлийн цахилгаан утсыг залгасан эсэхийг шалгана.

❏ ⏻ товчийг бага зэрэг удаан дарна.

Тэжээл унтрахгүй байна

⏻ товчийг бага зэрэг удаан дарна. Та принтерийг унтрааж чадахгүй хэвээр байвал, тэжээлийн цахилгаан утсыг салгана. Принтерийн толгойг хатахаас сэргийлэхийн тулд, принтерийг буцаан асааж ⏻ товчийг дарж унтраана.

Компьютероос хэвлэх боломжгүй

Холболт шалгах (USB)

❏ USB кабелийг принтер болон компьютертой сайтар холбо.

❏ Хэрэв USB ашиглаж байгаа бол, принтерийг компьютертой шууд холбоод үз.

❏ USB кабелийг танихгүй байвал, портыг өөрчилж, USB кабелийг солино.

❏ Принтер нь USB холболт ашиглан хэвлэж чадахгүй байвал, дараахыг хийж үзнэ үү.

USB кабелийг компьютероос салга.Компьютер дээр харуулсан принтер тэмдэг дээр баруун товшиж **Төхөөрөмжийг арилгах** товш.Дараа нь, USB кабелийг компьютертой холбож сорилт хийн хэвлээд үз.

Энэхүү гарын авлага доторх алхмуудыг даган компьютерт холбох аргыг өөрчлөх замаар USB холболтыг дахин тохируул.Холбогдох мэдээллийг доорх холбоосоос дэлгэрэнгүй үзнэ үү.



Холбогдох мэдээлэл

➡ 32 хуудас дээрх “Компьютерт холбох аргыг өөрчлөх”

Холболт шалгах (Сүлжээ)

❏ Хэрэв та нэвтрэх цэг эсвэл үйлчилгээ үзүүлэгчийг өөрчилсөн бол принтерийн сүлжээний тохиргоог дахин өөрчлөөд үз.Принтертэй ижил SSID-д ухаалаг төхөөрөмж болон компьютерийг холбо.

❏ Сүлжээнд холбохыг хүссэн төхөөрөмжүүдээ унтраа.10 секунд орчим хүлээгээд дараах дарааллаар төхөөрөмжүүдийг асаа: нэвтрэх цэг, компьютер эсвэл ухаалаг төхөөрөмж, тэгээд дараа нь принтер.Принтер, компьютер эсвэл ухаалаг төхөөрөмжийг радио долгионы харилцаа үүсгэхийг дэмжих үүднээс нэвтрэх цэгт ойр байрлуулж сүлжээний тохиргоог дахин тохируулаад үз.

❏ Сүлжээний холболтын тайланг хэвлэ.Дэлгэрэнгүй мэдээлэл авах бол доорх холбогдох мэдээллийн холбоосыг харна уу.Хэрэв тайлан сүлжээний холболтыг амжилтгүй болсон гэж харуулж байвал сүлжээний холболтын тайланг шалгаад хэвлэсэн шийдлийг дагана уу.

❏ Хэрвээ принтерт холбогдсон IP хаяг нь 169.254.XXX.XXX болон дэд баг нь 255.255.0.0 бол IP хаяг зөв холбогдоогүй гэсэн үг.Нэвтрэх цэгийг дахин эхлүүлэх эсвэл принтерийн сүлжээний тохиргоог шинэчлэнэ үү.Хэрвээ асуудал шийдэгдэхгүй бол нэвтрэх цэгийн баримтжуулалтыг харна уу.

❏ Таны компьютерийн сүлжээний тохиргоо зөв эсэхийг баталгаажуулан компьютероосоо вэб сайтанд хандаад үз.Ямар нэг вэбсайтанд хандах боломжгүй бол таны компьютерт асуудал байна гэсэн үг.Компьютерын сүлжээний холболтын тайланг шалга.

Холбогдох мэдээлэл

➡ 20 хуудас дээрх “Компьютертай холбогдох”

➡ 25 хуудас дээрх “Сүлжээний холболтын тайланг хэвлэх”

Программ хангамж ба өгөгдлийг шалгах

❏ Жинхэнэ Epson принтерийн драйверыг суулгасан эсэхээ шалгана уу.Жинхэнэ Epson принтерийн драйвер суулгаагүй бол, боломжит функцууд нь хязгаарлагдмал байна.Жинхэнэ Epson принтерийн драйверыг ашиглахыг бид зөвлөж байна.Холбогдох мэдээллийг доорх холбоосоос дэлгэрэнгүй үзнэ үү.

❏ Та том хэмжээний мэдээлэл бүхий зураг хэвлэж байгаа бол, компьютерын санах ой хүрэхгүй байж болно.Зургийг бага нарийвчлал эсвэл бага хэмжээтэйгээр хэвлэнэ үү.

Холбогдох мэдээлэл

➡ 119 хуудас дээрх "Epson принтерийн жинхэнэ драйверийг шалга"

➡ 109 хуудас дээрх "Программ хангамжийг устгах"

Epson принтерийн жинхэнэ драйверийг шалга

Epson принтерийн жинхэнэ драйверийг компьютер дээрээ суулгасан эсэхийг дараах аргуудын аль нэгээр шалгаж болно.

Windows

Хянах самбар > **Төхөөрөмж ба принтер харах** (**Принтер**, **Принтер ба Факс**), дараа нь принтерийн серверийн үзүүлэлтийн цонхыг нээхийн тулд дараахыг хийнэ.

❏ Windows 10/Windows 8.1/Windows 8/Windows 7

Принтерийн тэмдэг дээр товшиж, дараа нь цонхны дээд хэсэг дээрх **Принтерийн серверийн үзүүлэлт**-ийг товш.

❏ Windows Vista

Принтер-ийн хавтсан дээр хулганы баруун товчийг дарж, **Администратор хэлбэрээр ажиллуулах** > **Серверийн үзүүлэлт**-г дарна.

❏ Windows XP

Файл цэснээс, **Серверийн үзүүлэлт**-ийг сонгоно.

Асуудлыг шийдэх

Драйвер табыг товшино.Жагсаалт дотор таны принтерийн нэр байвал, жинхэнэ Epson принтерийн драйвер таны компьютер суулгагдсан болно.



Mac OS

Системийн тохируулгууд-ыг цэс > **Принтер & Сканнер** (эсвэл **Хэвлэх & Сканнердах**, **Хэвлэх & Факсдах**)-аас сонгоод дараа нь принтерээ сонго.**Сонголт ба Хангамж** дээр дарж, **Сонголтын** тав болон **Хэрэгслийн** таб цонхон дээр гарах үед, жинхэнэ Epson принтерийн драйвер таны компьютер дээр суулгагдсан байна.

Холбогдох мэдээлэл

➡ 109 хуудас дээрх “Программ хангамжийг устгах”

Компьютероос принтерийн төлөвийг шалгах (Windows)

Хэвлэх Дараалал-г принтерийн драйверийн **Арчилгаа** таб дээрээс товшиж, дараа нь доорхыг шалгана уу.



❏ Түр зогсоосон ямарваа хэвлэх ажил байгаа эсэхийг шалгах.

Хэрвээ хэрэгцээгүй өгөгдөл үлдвэл **Принтер** цэсний **Бүх бичиг баримтыг болих**-г сонгоно.

❏ Принтер оффлайн биш эсэх, эсвэл түр зогссон эсэхийг шалгах.

Хэрэв принтер оффлайн эсвэл түр зогссон бол **Принтер** цэснээс оффлайн эсвэл түр зогссон тохиргоог арилгах.



❏ **Принтер** цэснээс принтерийг өгөгдмөл принтер гэж сонгосон эсэхийг шалгах (цэсний зүйлс дээр зөвлөх тэмдэг байх ёстой).

Хэрэв принтерийг өгөгдмөл принтер гэж сонгоогүй бол, түүнийг өгөгдмөл принтер гэж сонгох.Хэрвээ **Хянах самбар** > **Төхөөрөмж болон принтерийг харах** (**Принтерүүд**, **Принтер болон Факсууд**-д) олон сонголт байвал тэмдэгтийг сонгохын тулд дараахыг харна уу.

Жишээлбэл

USB холболт: EPSON XXXX Сери

Сүлжээний холболт: EPSON XXXX Сери (сүлжээ)

Хэрвээ принтерийн драйверийг хэд хэдэн удаа суулгавал принтерийн драйверийн хуулбарууд үүсч болно.Хэрэв "EPSON XXXX Сери (хуулбар 1)" гэх мэтээр үүсвэл, хуулбарлагдсан драйверийн тэмдэгтийн байруун товчыг дараад **Төхөөрөмжийг арилгах**-г дарна.

❏ Принтерийн портыг **Үзүүлэлт** > **Порт** гэж **Принтер** цэснээс дараах байдлаар зөв сонгосон эсэхийг шалга.

USB холболт хийхийн тулд "**USBXXX**", эсвэл сүлжээний холболт хийхийн тулд "**EpsonNet Print Port**" гэснийг сонго.

Компьютероос принтерийн төлөвийг шалгах (Mac OS)

Принтерийн төлөв **Түр зогсоосон** болоогүй эсэхийг баталгаажуул.

Системийн тохиргоо-г цэс > **Принтер ба Сканнер** (эсвэл **Хэвлэх ба Скандах**, **Хэвлэх ба Факсдах**)-г сонгоод, дараа нь принтерийг хоёр товшино.Принтерийг түр зогсоосон бол, **Буцаан асаах** (эсвэл **Принтерийг буцаан асаах**) дээр дарна.

Сүлжээний тохиргоо хийж чадахгүй бол

❏ Сүлжээнд холбохыг хүссэн төхөөрөмжүүдээ унтраа.10 секунд орчим хүлээгээд дараах дарааллаар төхөөрөмжүүдийг асаа: нэвтрэх цэг, компьютер эсвэл ухаалаг төхөөрөмж, тэгээд дараа нь принтер.Принтер, компьютер эсвэл ухаалаг төхөөрөмжийг радио долгионы харилцаа үүсгэхийг дэмжих үүднээс нэвтрэх цэгт ойр байрлуулж сүлжээний тохиргоог дахин тохируулаад үз.

❏ Сүлжээний холболтын тайланг хэвлэх бол товчийг дар.Үүнийг шалгаад хэвлэсэн шийдлийг дагана уу.

Холбогдох мэдээлэл

➡ 122 хуудас дээрх “Хэдийгээр сүлжээний тохиргоонд асуудал гараагүй ч төхөөрөмжөөс холбогдох боломжгүй байх”

➡ 25 хуудас дээрх “Сүлжээний холболтын тайланг хэвлэх”

Хэдийгээр сүлжээний тохиргоонд асуудал гараагүй ч төхөөрөмжөөс холбогдох боломжгүй байх

Хэдийгээр сүлжээний холболтын тайлан ямарч асуудлыг үзүүлэхгүй байгаа ч ухаалаг төхөөрөмж болон компьютероос принтерт та холбогдох боломжгүй байгаа бол дараахийг шалгана уу.

❏ Та нэгэн зэрэг олон хандалт хийх үед таны хандалт хийж байгаа газруудын тохиргооноос хамаарааД ухаалаг төхөөрөмж болон компьютероосоо сканнерийг ашиглах боломжгүй.Принтертэй ижил хандалтын цэгт ухаалаг төхөөрөмж болон компьютерийг холбо.

Хэрэв энэ нь идэвхжсэн бол ухаалаг төхөөрөмж дээрх уяаны функцийг идэвхгүй болго.



Асуудлыг шийдэх

❏ Хандалтын цэг олон SSIDs-тэй байгаа үед хандалтын цэгүүдэд холбогдох боломжгүй ба төхөөрөмжүүд нь ижилхэн хандалтын цэгтт өөр өөр SSIDs-д холбогдсон байдаг.Принтертэй ижил SSID-д ухаалаг төхөөрөмж болон компьютерийг холбо.



❏ Хандалтын цэг нь IEEE802.11a болон IEEE802.11g-тэй аль алинтай нь нийцсэн байх ч 2.4 GHz, 5 GHz-н SSID-тэй байна.Хэрэв та компьютер болон ухаалаг төхөөрөмжөө 5 GHz SSID-д холбовол та принтерээ холбож чадахгүй. Учир нь принтер зөвхөн 2.4 GHz-тэй холболтыг дэмждэг.Принтертэй ижил SSID-д ухаалаг төхөөрөмж болон компьютерийг холбо.



❏ Ихэнх нэвтрэх цэгүүд нь нууцлалын тусгаарлагч онцлогтой байдаг ч холбоотой төхөөрөмжөөс холбогдвол цоожлогдоно.Хэрэв та принтер, компьютер, ухаалаг төхөөрөмж хооронд холбоо тогтоох боломжгүй бол ижил сүлжээнд холбогдсон байсан ч нэвтрэх цэг дээрх нууцлалын тусгаарлагчийг салгана уу.Хандалтын цэгийн талаарх дэлгэрэнгүйг гарын авлагаас харна уу.



Холбогдох мэдээлэл

➡ 125 хуудас дээрх “Принтертэй холбоотой SSID-г шалгах”

➡ 126 хуудас дээрх “Компьютерын SSID-г шалгах”

Утасгүй интернэтийн (Энгийн AP) шууд холболтыг ашиглан холбогдохгүй байгаа бол

Хэрвээ дөрвөн төхөөрөмж аль хэдийн холбогдсон ч илүү төхөөрөмж холбож болохгүй байгаа бол.Дараахыг хараад дахин холбож үзнэ үү.

Хэдэн төхөөрөмж холбогдсоныг шалга

Принтерт хэдэн төхөөрөмж холбогдсоныг шалга.Хэрвээ холбогдсон төхөөрөмжний тоо дээд хэмжээндээ хүрээгүй бол холболтын алдаа гарч болно.Принтер, компьютер эсвэл ухаалаг төхөөрөмжийг радио долгионы харилцаа үүсгэхийг дэмжих үүднээс нэвтрэх цэгт ойр байрлуулж SSID болон нууц үгээ зөв эсэхийг шалгаад сүлжээний тохиргоог дахин тохируулаад үз.

❏ Сүлжээний төлөвийн хуудас



❏ Web Config-д бүтээгдэхүүний төлөвийн дэлгэц

Web Config-г нээхийн тулд холбогдсон төхөөрөмжөөс веб хөтчийг ажиллуулаад утасгүй интернэтийн (Энгийн AP) IP хаягийг оруулна.**Product Status** > **Wi-Fi Direct**-г дараад Wi-Fi Direct н төлөвийг шалга.

Хэрэгцээгүй төхөөрөмжүүдийг салгах

Хэрвээ принтерт аль хэдийн дөрвөн төхөөрөмж холбогдсон бол хэрэгцээгүй төхөөрөмжүүдийг салгаад шинэ төхөөрөмж холбоод үз.

Принтертэй холбох шаардлагагүй төхөөрөмжинд утасгүй интернэтийн дэлгэц дэх шууд утасгүй интернэтийн SSID-г устгана.

Принтертэй холбоотой SSID-г шалгах

Та SSID-г сүлжээний холболтын тайлан, сүлжээний статусын хуудас хэвлэн, эсвэл Web Config дээр шалгах боломжтой.

Компьютерын SSID-г шалгах

Windows

Компьютерын даалгаврын тавиур дээр байгаа дээр товш.Харуулсан жагсаалтаас холбосон SSID-ийн нэрийг шалга.

Mac OS

Компьютерын дэлгэцийн дээр байгаа Wi-Fi тэмдгийг товш.SSID-н жагсаалтыг харуулах ба холбогдсон SSID нь чагт тэмдэгтэй байна.

Хэвлэмэл материалын асуудал

Хэвлэгдсэн зүйл зурагдсан эсвэл өнгөгүй байх

Хэрэв та принтерээ удаан хугацааны турш хэрэглээгүй бол, хэвлэх толгойн хошуу бөглөрч, бэх гарч ирэхгүй болсон байж магадгүй. Хошуу шалгалтыг гүйцэтгэж, хэвлэх толгойн аль нэг хошуу бөглөрсөн байвал хэвлэх толгойг цэвэрлэ.

Холбогдох мэдээлэл

➡ 88 хуудас дээрх “Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх”

Судал эсвэл санаандгүй өнгүүд харагдана



Принтерийн толгойн цорго бөглөрсөн байж болно. Хэвлэх толгойн хошуу бөглөрсөн эсэхийг шалгаж хошууны шалгалтыг явуул. Хэвлэх толгойн аль нэг хошуу бөглөрсөн байвал хэвлэх толгойг цэвэрлэ.

Холбогдох мэдээлэл

➡ 88 хуудас дээрх “Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх”

Ойролцоогоор 2.5 см-ийн зайтай өнгөт судлууд гарч ирнэ



❏ Принтерт ачаалсан цаасны төрөлд таарсан цаасны зөв төрлийн тохиргоог сонго.

❏ Хэвлэх толгойг тэгшитгэ.

❏ Ердийн цаасан дээр хэвлэх үед өндөр чанарын тохиргоог ашиглан хэвлэ.

Холбогдох мэдээлэл

➡ 36 хуудас дээрх "Цаасны төрлийн жагсаалт"

➡ 90 хуудас дээрх "Принтерийн толгойг тохируулна"

Бүдэг хэвлэлт, Босоо судал, Далий

Хэвлэх толгойг тэгшитгэ.

Холбогдох мэдээлэл

➡ 90 хуудас дээрх "Принтерийн толгойг тохируулна"

Хэвлэх толгойг тэгшитгэсний дараа ч хэвлэлтийн чанар сайжрахгүй байвал

Хоёр чиглэлт (эсвэл өндөр хурдны) хэвлэлтийн үед, хэвлэх толгой хоёр тийш хөдөлж хэвлэдэг учраас босоо шугамууд тэгш бус болж магадгүй байдаг.Хэрэв хэвлэлтийн чанар сайжрахгүй бол, хоёр чиглэлт (эсвэл өндөр хурдны) тохиргоог цуцла.Энэ тохиргоог цуцлах нь хэвлэх хурдыг удаашруулж болзошгүй.

❏ Windows

Өндөр Хурд-г принтерийн драйверын **Илүү Сонголтууд** таб дээрээс арилга.

❏ Mac OS

Системийн тохируулгууд-ыг цэс > **Принтер & Сканнер** (эсвэл **Хэвлэх & Сканнердах**, **Хэвлэх & Факсдах**)-аас сонгоод дараа нь принтерээ сонго.**Сонголт & Хангамж** > **Сонголт** (эсвэл **Драйвер**) дээр дар.**Off**-ыг **High Speed Printing** тохиргоогоор сонго.

Хэвлэлтийн чанар муу байвал

Бүдэг хэвлэгдэх, судалтах, өнгө дутуу гарах, өнгө гандах, тэгш бус шугам хэвлэлтэнд гарах зэргээс болж хэвлэлтийн чанар муу бол дараахыг шалгана уу.

Принтерийг шалгах

❏ Хошуу шалгалтыг гүйцэтгэж, хэвлэх толгойн аль нэг хошуу бөглөрсөн байвал хэвлэх толгойг цэвэрлэ.

❏ Хэвлэх толгойг тэгшитгэ.

Цаас шалгах

❏ Энэхүү принтерийн дэмждэг цаасыг ашигла.

❏ Нойтон, урагдсан, эсвэл хэт хуучин цаасан дээр хэвлэхгүй байх.

❏ Цаас мушгирсан эсвэл дугтуй овоорсон байвал тэдгээрийг тэнийлгэнэ.

❏ Хэвлэсний дараа цааснуудыг шууд давхарлаж болохгүй.

❏ Хэвлэсэн материалыг хавтаслах, үзүүлэнд тавихаас өмнө бүрэн хатаагаарай. Хэвлэсэн материалыг хатаахдаа, нарны шууд тусгалаас хол байлгаж, хатаагч ашиглахгүй, цаасны хэвлэсэн хэсэгт хүрэхгүй байх хэрэгтэй.

❏ Зураг буюу фото зураг хэвлэхдээ, ердийн цулгуй цааснаас илүү жинхэнэ Epson цаасыг ашиглахыг Epson зөвлөж байна. Жинхэнэ Epson цаасны хэвлэж болох тал дээр хэвлэнэ.

Принтерийн тохиргоог шалгах

❏ Принтерт ачаалсан цаасны төрөлд таарсан цаасны зөв төрлийн тохиргоог сонго.

❏ Илүү өндөр чанарын тохиргоогоор хэвлэ.

Хорны картриджийг шалгах

❏ Сав баглаанд дээр заасан огнооноос өмнө бэхний картриджийг ашиглахыг Epson санал болгож байна.

❏ Сайн үр дүн хүрэхийн тулд, баглааг задалснаас зургаан сарын дотор бэхний картриджийг ашиглаж дуусгана.

❏ Epson-н жинхэнэ бэхний картриджийг ашиглахыг хичээнэ үү. Энэхүү бүтээгдэхүүн нь Epson-н жинхэнэ бэхний картриджийг ашиглах дээр суурилж өнгийг тохируулахаар бүтээгдсэн байдаг. Жинхэнэ бус бэхний картриджийг ашиглавал хэвлэлийн чанар муудаж болно.

Холбогдох мэдээлэл

➡ 35 хуудас дээрх “Бэлэн байгаа цаас ба багтаамж”

➡ 36 хуудас дээрх “Цаасны төрлийн жагсаалт”

➡ 34 хуудас дээрх “Цаас ашиглахтай холбоотой анхааруулга”

➡ 88 хуудас дээрх “Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх”

➡ 90 хуудас дээрх “Принтерийн толгойг тохируулна”

Цаас балархайтах буюу үнгэгдсэн байвал

❏ Хөндлөн судал гарч ирэх эсвэл цаасны дээд, доод үзүүр бохирдоход, цаасыг зөв чиглэлд ачаалж, ирмэгийн чиглүүлэгчийг цаасны ирмэг рүү гулгуул.



❏ Босоо судал гарч ирэх эсвэл цаас бохирдоход, цаасны замыг цэвэрлэ.



❏ Цаас нугаларсан эсэхийг шалгаж хавтгай гадаргуу дээр түүнийг байрлуул. Нугаларсан бол тэгшил.

❏ Гар аргаар 2-талт хэвлэлтийг гүйцэтгэх үед, цаасыг дахин ачаалахын өмнө бэх бүрэн хатсан эсэхийг шалгана.

Холбогдох мэдээлэл

➡ 37 хуудас дээрх “Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах”

➡ 91 хуудас дээрх “Цаас дамжих замыг цэвэрлэх”

Хэвлэсэн фото зураг наалдамхай байвал

Та фото цаасны буруу талд хэвлэж байж болно. Та хэвлэх тал дээр хэвлэж байгаа эсэхээ шалгаарай.

Фото цаасны буруу тал дээр хэвлэвэл та цаасны замг цэвэрлэх хэрэгтэй.

Холбогдох мэдээлэл

➡ 91 хуудас дээрх “Цаас дамжих замыг цэвэрлэх”

Зураг юмуу фото зураг хэвийн бус өнгөөр хэвлэгдэж байвал

Windows-н принтерийн драйвераас хэвлэж байгаа үед Epson-ы автомтаар фотог тохируулах тохиргоо цаасны төрөлөөс хамаарч өгөгдмөлөөр хийгдэнэ. Тохиргоог өөрчлөөд үз.

Илүү Сонголтууд таб дээрээс **Өөрчлөх** гэснийг **Өнгө Засалт** дээр сонгож, дараа нь **Нэмэлт** товш. **Зураг Засвар** тохиргоог **Автомат Засагч**-с бусад сонголт руу өөрчил. Тохиргоог өөрчилсөн ч болохгүй бол **Өнгөний Менежмент**-н **ФотоСайжрилт**-с өөр өнгө өөрчлөх аргыг ашигла.

Холбогдох мэдээлэл

➡ 58 хуудас дээрх “Принтерийн өнгийг тохируулах”

Өнгөнүүд дэлгэц дээр харагддагаасаа өөр байдаг

- ❏ Дэлгэцийн төхөөрөмж буюу компьютерийн дэлгэц нь өөрийн гэсэн дэлгэцийн шинж чанартай байдаг. Хэрэв дэлгэц нь тогтворгүй байвал дүрслэлийн зохих гэрэлтүүлэг болон өнгөнүүд нь харагдахгүй. Төхөөрөмжийн үзүүлэлтийг тохируул.
- ❏ Дэлгэцэн дээр гэрэл тусах үед дэлгэцэн дээрх дүрслэл хэрхэн харагдахад нөлөөлдөг. Шууд нарны гэрлээс зайлсхийж, зохих гэрэлтүүлэг байгаа эсэхийг баталгаажуул.
- ❏ Өндөр нягтралтай дэлгэц бүхий ухаалаг төхөөрөмж буюу таблет, ухаалаг утас дээр өнгө өөр харагдаж болно.
- ❏ Дэлгэцэн дээрх өнгөнүүд нь цаасан дээрх өнгөнүүдтэй тийм ч адил биш. Учир нь дэлгэцний төхөөрөмж болон принтер нь өнгө ялгах өөр процесстой байдаг.

Эргэн тойрон хүрээгүй хэвлэх боломжгүй

Хэвлэх тохиргоон дээр хүрээгүй хэвлэх тохиргоог хийнэ. Хэрэв хүрээгүй хэвлэх үйлдлийг дэмждэггүй төрлийн цаас сонгосон бол, та **Хүрээгүй**-г сонгож болохгүй. Хүрээгүй хэвлэх үйлдлийг дэмждэг төрлийн цаас сонго.

Холбогдох мэдээлэл

➡ 42 хуудас дээрх "Принтерийн үндсэн мэдээлэл — Windows"

➡ 43 хуудас дээрх "Хэвлэх үндсэн алхмууд Mac OS"

Хүрээгүй хэвлэх явцад зургийн ирмэгийг тайрсан

Хүрээгүй хэвлэх үед, зураг бага зэрэг томорч цухуйсан хэсэг нь багасаж болно.Арай багаар томруулах тохиргоог сонго.

- ❏ Windows

  Тохиргоо-г **Хүрээгүй** гэсэн сонгох хайрцгын хажуугаас принтерийн драйверын **Үндсэн** таб дээрээс товш.

- ❏ Mac OS

  Тэлэлт тохиргоог принтерийн харилцах цонхны **Хэвлэх Тохиргоо** цэснээс өөрчилнө.

Хэвлэмэл материалын байрлал, хэмжээ, хүрээ буруу байх

- ❏ Цаасыг зөв чиглэлд ачаалж, ирмэг заагчийг цаасны ирмэгт тулгаж гулгуулна.
- ❏ Эх хувийг сканнерын шил дээр байрлуулах үед эх хувийн буланг scanner glass-н хүрээний тэмдгээр харуулсан булантай тааруулна. Хуулбарын өнцөг зүсэгдсэн байвал, эх хувийг булангаас бага зэрэг холдуулж гулгуулна.
- ❏ Эх хувийг сканнерын шил дээр байрлуулах үед, сканнерын шил болон баримт бичгийн тагийг цэвэрлэнэ. Шилэн дээр тоос, эсвэл толбо байвал, хуулбарлах талбай нь уг тоос, толбыг багтаахаар томорч болох ба үр дүнд нь хуулалтын буруу байрлал, жижиг зургийг бий болгоно.
- ❏ Цаасны зохих хэмжээний тохиргоог сонго.

❏ Хүрээний тохиргоог программ хангамж дээр тохируулж, ингэснээр энэ нь хэвлэх талбай дотор багтах болно.

Холбогдох мэдээлэл

➡ 37 хуудас дээрх "Арын Цаасны Дайз дээр цаас ачаалах"

➡ 40 хуудас дээрх "Сканнерын Шил дээр эх хувийг байрлуулах"

➡ 91 хуудас дээрх "Сканнерын Шил-г цэвэрлэх"

➡ 141 хуудас дээрх "Хэвлэх талбай"

Хэвлэсэн тэмдэгт буруу, ташаа байх

❏ USB кабелийг принтер болон компьютерт сайтар холбо.

❏ Түр зогсоосон бүх хэвлэх ажлыг цуцлах.

❏ Хэвлэж байхад компьютерийг **Ичих** эсвэл **Унтах** горимд гар аргаар оруулахгүй байх. Ташаа хэвлэсэн текст бүхий хуудсыг дараагийн удаа компьютероо асаахдаа хэвлэж болно.

Холбогдох мэдээлэл

➡ 62 хуудас дээрх "Хэвлэхийг цуцлах"

Хэвлэсэн зураг буруу харах

Принтерийн драйвер эсвэл программ хангамж доторх бүх зургийн толин тохируулгыг арилгах.

❏ Windows

Толин Тусгал-г принтерийн драйверийн **Илүү Сонголтууд** таб дээрээс арилгана.

❏ Mac OS

Mirror Image-г хэвлэх харилцах цонхны **Хэвлэх Тохиргоо** цэснээс арилгана.

Хэвлэлтийн Мозайк маягийн хээ угалз

Зураг буюу фото зураг хэвлэхдээ, өндөр нарийвчлалтай өгөгдөл ашиглан хэвлээрэй. Вэбсайт дээрх зургууд ихэвчлэн нарийвчлал багатай байдаг ба хэдий дэлгэц дээр гоё харагдах ч хэвлэхэд чанар муутай харагдана.

Ижил бус өнгө, бохирдол, цэг, эсвэл шулуун шугамууд хуулбарласан зураг дээр гарч ирэх

❏ Цаасны замыг цэвэрлэ.

❏ сканнерын шил-ийг цэвэрлэ.

❏ Эхийг сканнерын шил дээр байрлуулах үедээ, эх буюу баримтын таг дээр хэт хүчтэй дарж болохгүй.

Холбогдох мэдээлэл

➡ 91 хуудас дээрх “Цаас дамжих замыг цэвэрлэх”

➡ 91 хуудас дээрх “Сканнерын Шил-г цэвэрлэх”

Хуулбарласан зураг дээр муар (хөндлөн зураас)-н дүрс харагдах

Эх хувийг бага зэрэг өөр өнцгөөр тавина.

Эх хувийн эсрэг талын зураг хуулбарласан зураг дээр гарах

Нимгэн эх хувийн хувьд эх хувийг сканнерын шил дээр тавьж дараа нь түүний дээгүүр хар цаас тавина.

Хэвлэмэл материалын асуудал шийдэгдэхгүй байх

Та бүх шийдлийг оролдож үзээд асуудлыг шийдэж чадахгүй байвал, принтерийн драйверийг устгаж дараа нь дахин суулгана уу.

Холбогдох мэдээлэл

➡ 108 хуудас дээрх “Программ хангамжийг суулгах”

➡ 109 хуудас дээрх “Программ хангамжийг устгах”

Хэвлэх бусад асуудал

Хэт удаан хэвлэх

❏ Аливаа шаардлагагүй программ хангамжийг хаах.

❏ Чанарын тохиргоог багасга.Дээд зэргийн чанартай хэвлэх нь хэвлэх хурдыг удаашруулдаг.

❏ Хоёр чиглэлт (эсвэл өндөр хурдны) тохиргоог идэвхжүүлэх.Энэхүү тохиргоог идэвхжүүлсэн үед, принтерийн толгой нь хоёр чиглэлд хөдлөнгөө хэвлэдэг бөгөөд хэвлэх хурд нэмэгддэг.

  ❏ Windows

  Өндөр Хурд-г принтерийн драйверийн **Илүү Сонголтууд** таб дээрээс сонгоно.

  ❏ Mac OS

  Системийн тохируулгууд-ыг цэс > **Принтер & Сканнер** (эсвэл **Хэвлэх & Сканнердах**, **Хэвлэх & Факсдах**)-аас сонгоод дараа нь принтерээ сонго.**Сонголт & Хангамж** > **Сонголт** (эсвэл **Драйвер**) дээр дар.**On**-ыг **High Speed Printing** тохиргоогоор сонго.

❏ **Чимээгүй Горим**-ыг идэвхгүй болго.

❏ Windows

Чимээгүй Горим-г принтерийн драйверийн **Үндсэн** таб дээрээс идэвхгүйжүүлнэ.

❏ Mac OS

Системийн тохируулгууд-ыг цэс > **Принтер & Сканнер** (эсвэл **Хэвлэх & Сканнердах**, **Хэвлэх & Факсдах**)-аас сонгоод дараа нь принтерээ сонго.**Сонголт & Хангамж** > **Сонголт** (эсвэл **Драйвер**) дээр дар.**Off**-ыг **Чимээгүй Горим** тохиргоогоор сонго.

Үргэлжилсэн Хэвлэлтийн Үед Хэвлэлт Удаашрах

Принтерийн механизмийг хэт халах, эвдэрч гэмтэхээс сэргийлж хэвлэлт удааширдаг. Гэвч та үргэлжлүүлэн хэвлэх боломжтой. Эргэж хэвийн хурд руу буцаахын тулд принтерийг дор хаяж 30 минут сул зогсоо. Хэрэв тэжээл унтраалттай бол хэвлэх хурд хэвийн хэмжээндээ буцаж орохгүй.

Сканыг эхлүүлж чадахгүй байна

❏ USB кабелийг принтер болон компьютертой сайтар холбо.Хэрэв USB ашиглаж байгаа бол, принтерийг компьютертой шууд холбоод үз.

❏ Хэрэв сүлжээгээр дамжуулан өндөр нарийвчлалтай сканнердвал, холбооны алдаа гарч болзошгүй.Нарийвчлалыг бууруул.

❏ Зөв принтер (сканнер) Epson Scan 2 дээр сонгогдсон эсэхийг шалгана уу.

Windows-г ашиглах үед принтерийг таних эсэхийг шалгана

Windows дээр, **Сканнер ба Зургийн аппарат** хэсэгт принтер (сканнер) харагдаж байгаа эсэхийг магадла.Принтер (сканнер) нь "EPSON XXXXX (принтерийн нэр)" гэж харагдах ёстой.Хэрэв принтер (сканнер) харагдахгүй байвал, Epson Scan 2-г устгаад дахин суулга.**Сканнер ба Зургийн аппарат**-д хандахын тулд дараахыг лавлана уу.

❏ Windows 10

Эхлэл товчин дээр хулганы баруун товчийг удаан дарж, **Хяналтын самбар**-ыг сонгон, хайлтын талбарт "Сканнер ба Камер" гэж оруулна. Дараа нь **Сканнер, камерийг харах** дээр дарж, улмаар принтер харагдаж байгаа эсэхийг шалгана.

❏ Windows 8.1/Windows 8

Десктоп > **Тохиргоо** > **Хяналтын самбар**-ыг сонгож, хайлтын талбарт "Сканнер ба Камер" гэж оруулан, **Сканнер ба Камерийг харуулах** дээр дарах ба дараа нь принтер харагдаж байгаа эсэхийг шалгана.

❏ Windows 7

Старт товчийг дарж, **Хяналтын самбар**-ыг сонгон, хайлтын талбарт "Сканнер ба Камер" гэж оруулна. Дараа нь **Сканнер, камерийг харах** дээр дарж, улмаар принтер харагдаж байгаа эсэхийг шалгана.

❏ Windows Vista

Старт товч дээр дарж, **Хяналтын самбар** > **Техник хангамж ба Дуу** > **Сканнер ба Камер**-г сонгож дараа нь принтер харагдаж байгаа эсэхийг шалгана.

❑ Windows XP

Старт товч дээр дарж, **Хяналтын самбар** > **Принтер ба Бусад техник хангамж** > **Сканнер ба Камер**-г сонгож дараа нь принтер харагдаж байгаа эсэхийг шалгана.

Холбогдох мэдээлэл

➡ 108 хуудас дээрх "Программ хангамжийг суулгах"

➡ 109 хуудас дээрх "Программ хангамжийг устгах"

Хяналтын самбар ашиглаж байхад сканыг асааж чадахгүй байна

❑ Epson Scan 2 ба Epson Event Manager-г зөв суулгасан эсэхийг шалгана.

❑ Epson Event Manager дээр хийсэн скандах тохиргоог шалгана.

Холбогдох мэдээлэл

➡ 104 хуудас дээрх "Epson Scan 2 (Сканнерийн драйвер)"

➡ 105 хуудас дээрх "Epson Event Manager"

Скандсан зурагны асуудал

Сканерын шил дээрээс сканердахад жигд бус өнгө, тоос шороо, толбо зэрэг гарч ирвэл

❑ Сканерын шилийг цэвэрлэ.

❑ Эхэд наалдсан бүх хог шороо, буртагийг цэвэрлэ.

❑ Эх болон баримтын таг дээр хэтэрхий их хүчээр дарахаас болгоомжил. Хэрэв хэтэрхий хүчтэй дарвал, бүрсийх, балархайтах, толботох зэрэг асуудал үүсэж болзошгүй.

Холбогдох мэдээлэл

➡ 91 хуудас дээрх "Сканнерын Шил-г цэвэрлэх"

Зургийн чанар муу

❑ **Горим**-г Epson Scan 2 дээрээс сканнердахыг хүссэн эхийнхээ дагуу тохируул. **Баримтын Горим** дээр бичиг баримтын тохиргоог, **Фото Горим** дээр фотоны тохиргоог ашиглан сканнерд.

❑ Epson Scan 2 дээр **Мэргэжлийн Тохиргоо** таб дээр байгаа зүйлсийг ашиглан зургийг тохируулж сканнерд.

❑ Хэрэв нягтрал нь доогуур бол нягтралыг өсгөөд сканнердаад үз.

Холбогдох мэдээлэл

➡ 64 хуудас дээрх "Epson Scan 2 ашиглан сканнердах"

Оффсет зургийн ар талд харагдана

Эхийн ар талд байгаа зургууд сканнердсан зургууд дээр харагдаж болзошгүй.

❏ Epson Scan 2 дээрээс **Мэргэжлийн Тохиргоо** таб, дараа нь **Гэрэлтэлт**-г тохируул.

Энэ үйлчилгээ **Үндсэн тохиргоо** таб дээрх тохиргоо > **Зургийн төрөл** эсвэл **Мэргэжлийн Тохиргоо** таб дээрх бусад тохиргооны улмаас байхгүй байж болзошгүй.

❏ Epson Scan 2-н **Баримтын Горим** дээрээс **Мэргэжлийн Тохиргоо** таб, дараа нь **Зургийн сонголт** > **Текстийг сайжруулах** гэснийг сонго.

❏ Сканнерын шилэн дээрээс сканнердаж байгаа үед эхийн дээр хар цаас эсвэл дэвсгэр байрлуулах нь зүйтэй.

Холбогдох мэдээлэл

➡ 40 хуудас дээрх "Сканнерын Шил дээр эх хувийг байрлуулах"

➡ 64 хуудас дээрх "Epson Scan 2 ашиглан сканнердах"

Бичвэр бүдгэрэх

❏ Epson Scan 2-н **Баримтын Горим** дээрээс **Мэргэжлийн Тохиргоо** таб, дараа нь **Зургийн сонголт** > **Текстийг сайжруулах** гэснийг сонго.

❏ **Баримтын Горим**-г Epson Scan 2-н **Горим**-р сонго. **Баримтын Горим** дээрх бичиг баримтын тохиргоог ашиглан сканнерд.

❏ Epson Scan 2-н **Баримтын Горим**-р **Зургийн төрөл**-г **Үндсэн тохиргоо** таб дээр **Хар цагаан**-р тохируулсан бол, **Босго**-г **Мэргэжлийн Тохиргоо** таб дээрээс тохируул. Та **Босго**-г өсгөвөл, хар өнгөний хэсэг илүү том болно.

❏ Хэрэв нягтрал нь доогуур бол нягтралыг өсгөөд сканнердаад үз.

Холбогдох мэдээлэл

➡ 64 хуудас дээрх "Бичиг баримтыг сканнердах (Баримтын Горим)"

Муар хээ (аалзны тор шиг сүүдэртсэн хээ) гарч ирвэл

Хэрэв эх нь хэвлэмэл баримт бол, сканердсан зураг дээр муар хээ (аалзны тор шиг сүүдэртсэн хээ) гарч ирж болзошгүй байдаг.

❏ Epson Scan 2 дахь **Мэргэжлийн Тохиргоо** таб дээр **Муар эффект арилгах**-г сонгоорой.

❏ Нарийвчлалыг өөрчлөөд, дахин сканердаарай.

Холбогдох мэдээлэл

➡ 64 хуудас дээрх "Epson Scan 2 ашиглан сканнердах"

Сканнерийн шилэн дээрх зөв бүсийг сканнердаж болохгүй

❏ Эхийг шугамын дагуу зөв байрлуулсан эсэхийг шалгаарай.

❏ Хэрэв сканнердсан зургийн ирмэг байхгүй байвал эхийг сканнерийн шилийн ирмэгээс бага зэрэг хөндийрүүлээрэй.

❏ Сканнерийн шилэн дээрх олон эхүүдийг байрлуулах үед эхүүдийн хоорондох зай хамгийн багадаа 20 мм (дотроосоо 0.79 инч.) байгаа эсэхийг нягтлаарай.

Холбогдох мэдээлэл

➡ 40 хуудас дээрх "Сканнерын Шил дээр эх хувийг байрлуулах"

Жижиг зураг-д урьдчилан харах боломжгүй

❏ Сканнерийн шилэн дээрх олон эхүүдийг байрлуулах үед эхүүдийн хоорондох зай хамгийн багадаа 20 мм (дотроосоо 0.79 инч.) байгаа эсэхийг нягтлаарай.

❏ Эхийг шулуун байрлуулсан эсэхийг шалга.

❏ Эхээс хамаарч **Жижиг зураг**-г урьдчилан харах боломжгүй байж болно. Энэ тохиолдолд, сканнердсан бүх хэсгийг урьдчилан харахын тулд урьдчилан харах өнчин мөрний дээд хэсэгт байх **Жижиг зураг** чагтлах хэсгийг устгаад гүйдэг бичвэрийг өөрөө үүсгэнэ үү.

Холбогдох мэдээлэл

➡ 67 хуудас дээрх "Фото эсвэл зургийг сканнердах (Фото Горим)"

Бичвэр нь Хайлт хийж болох PDF хэлбэрээр хадгалах үед зөв танигдаагүй

❏ Epson Scan 2-н **Зургийн Форматын Сонголт** цонхон дээрээс **Текстийн хэл**-г **Текст** таб дээр зөв тохируулсан эсэхийг шалга.

❏ Эхийг шулуун байрлуулсан эсэхийг шалга.

❏ Бичвэр нь тодорхой эхийг ашигла. Дараах төрлийн эхүүдэд бичвэр танигч муу ажиллаж болзошгүй.

- ❏ Олон удаа хуулбарлагдсан эхүүд
- ❏ Факсаар ирсэн эхүүд (бага нягтралтай)
- ❏ Үсэг ба мөр хоорондын зай хэт жижиг эхүүд
- ❏ Бичвэрийн доогуур зурсан эсвэл шугамтай эхүүд
- ❏ Гараар бичсэн бичвэр эхүүд
- ❏ Нугаларч үрчийсэн эхүүд

❏ Epson Scan 2-н **Баримтын Горим**-р **Зургийн төрөл**-г **Үндсэн тохиргоо** таб дээр **Хар цагаан**-р тохируулсан бол, **Босго**-г **Мэргэжлийн Тохиргоо** таб дээрээс тохируул. Таныг **Босго**-г өсгөх үед хар илүү тод болно.

❏ Epson Scan 2-н **Баримтын Горим** дээрээс **Мэргэжлийн Тохиргоо** таб, дараа нь **Зургийн сонголт** > **Текстийг сайжруулах** гэснийг сонго.

Холбогдох мэдээлэл

➡ 64 хуудас дээрх “Бичиг баримтыг сканнердах (Баримтын Горим)”

Сканнердсан зургийн асуудлуудыг шийдвэрлэж чадахгүй байх

Та бүх шийдлийг оролдож үзээд асуудлыг шийдэж чадахгүй байвал Epson Scan 2 тохиргоог Epson Scan 2 Utility-г ашиглан эхлүүл.

Тэмдэглэл:
Epson Scan 2 Utility нь Epson Scan 2-г дагалдан ирдэг программ юм.

1. Epson Scan 2 Utility-г эхлүүлнэ.
   - ❏ Windows 10

     Эхлэх товч дээр дарж, дараа нь **EPSON** > **Epson Scan 2 Utility** сонгоно уу.
   - ❏ Windows 8.1/Windows 8

     Хайлтын талбар дээр программ хангамжийн нэрийг оруулж, дараа нь гарч ирсэн тэмдгийг сонгоно.
   - ❏ Windows 7/Windows Vista/Windows XP

     Эхлэх товчийг товшиж, дараа нь **Бүх программ** эсвэл **Программууд** > **EPSON** > **Epson Scan 2** > **Epson Scan 2 Utility** гэснийг сонго.
   - ❏ Mac OS

     Шилжих > **Программ хангамж** > **Epson Software** > **Epson Scan 2 Utility**-г сонгоно.
2. **Бусад** табыг сонгоно.
3. **Ресет хийх** дээр дарна.

   Тэмдэглэл:
   Хэрэв дахин эхлүүлсэнээр асуудлыг шийдэгдэхгүй хэвээр бол, Epson Scan 2-г устгаад дахин суулга.

Холбогдох мэдээлэл

➡ 108 хуудас дээрх “Программ хангамжийг суулгах”

➡ 109 хуудас дээрх “Программ хангамжийг устгах”

Скандах бусад асуудал

Хэт удаан скандаж байна

Нягтралыг бууруулна.

Холбогдох мэдээлэл

➡ 64 хуудас дээрх “Epson Scan 2 ашиглан сканнердах”

PDF/Multi-TIFF руу скандах үед скандах ажиллагаа зогсоод байна

❏ Epson Scan 2-г ашиглаж сканнердах үед, та PDF форматаар 999 хуудас, Multi-TIFF форматаар 200 хүртэл хуудсыг тасралтгүй сканнердах боломжтой.

❏ Том хэмжээний мэдээлэл скандах үед, саарал дүрсээр скандахыг бид санал болгож байна.

❏ Компьютерийн хатуу дискэн дээрх сул зайг нэмэгдүүлнэ. Хангалттай сул зай байхгүй бол скандах ажиллагаа зогсож болно.

❏ Бага нягтралтайгаар скандах гэж оролдоно уу. Нийт мэдээллийн хэмжээ хязгаартаа хүрсэн бол скандах ажиллагаа зогсоно.

Холбогдох мэдээлэл

➡ 64 хуудас дээрх “Epson Scan 2 ашиглан сканнердах”

Бусад асуудал

Принтерт хүрэхэд бага зэргийн тог цохиж байна

Компьютерт олон тооны дагалдах хэрэгсэл холбосон үед, принтерт хүрэх үед та бага зэргийн тог цохилт мэдэрч болно. Принтерт холбогдсон компьютерт газардуулагч утас суулгана уу.

Ажиллагаа чанга дуутай байвал

Хэрэв ажиллагааны дуу хэт чанга байвал, **Чимээгүй Горим**-ыг идэвхижүүл. Энэ үзүүлэлтийг идэвхижүүлэх нь хэвлэх хурдыг удаашруулж магадгүй. Таны сонгосон цаасны төрөл ба хэвлэлтийн чанарын тохиргооноос хамаарч, хэвлэгчийн оновчлолын түвшинд ялгаа гарахгүй байж болзошгүй.

❏ Windows

Чимээгүй Горим-г принтерийн драйверийн **Үндсэн** дээрээс идэвхжүүл.

❏ Mac OS

Системийн тохиргоо-ийг цэс > **Принтер & Сканнер** (эсвэл **Хэвлэх & Сканнердах**, **Хэвлэх & Факс**)-ээс сонгоод дараа нь принтерийг сонго. **Сонголт & Хангамж** > **Сонголт** (эсвэл **Драйвер**) дээр дар. **On**-ыг **Чимээгүй Горим** тохиргоогоор сонго.

Программ хангамжийг Firewall хаах (Windows-т зөвхөн)

Программ хангамжийн Windows Галт ханын зөвшөөрөлтэй аюулгүй байдлын программд нэмж **Хяналтын самбар дээр** тохируулна.

Хавсралт

Техникийн тодорхойлолт

Принтерийн үзүүлэлт

Принтерийн толгойд цорго суурилуулах		Хар бэхний хошуу: 180 Өнгөт бэхний хошуу: 59 өнгө бүрт
Цаасны жин*	Ердийн цаас	64 – 90 гр/м² (17 – 24 фунт)
	Дугтуйнууд	Дугтуй #10, DL, C6: 75 – 90 г/м² (20 – 24 фунт)

* Цаасны зузаан энэ хүрээнд байсан ч гэсэн цаасыг принтерт татахгүй эсвэл хэвлэлтийн чанар цаасны үзүүлэлт болон чанараас хамаарч буурч болзошгүй.

Хэвлэх талбай

Дан хуудсан дээр хэвлэх талбай

Принтерийн механизмаас шалтгаалж сүүдэртэй талбай дээр хэвлэлийн чанар муудаж болно.

Хүрээтэй хэвлэх



A	3.0 мм (0.12 инч)
B	3.0 мм (0.12 инч)
C	40.0 мм (1.57 инч)
D	32.0 мм (1.26 инч)

Хүрээгүй хэвлэлт



A	43.0 мм (1.69 инч)
B	35.0 мм (1.38 инч)

Дугтуйн дээр хэвлэх талбай

Принтерийн механизмаас шалтгаалж сүүдэртэй талбай дээр хэвлэлийн чанар муудаж болно.



A	3.0 мм (0.12 инч)
B	5.0 мм (0.20 инч)
C	18.0 мм (0.71 инч)
D	40.0 мм (1.57 инч)

Сканнерийн үзүүлэлт

Сканнерийн төрөл	Хавтгай суурьтай
Фото цахилгаан төхөөрөмж	CIS
Баримт бичгийн дээд хэмжээ	216×297 мм (8.5×11.7 инч) A4, Letter
Нягтрал	1200 dpi (үндсэн скан) 2400 dpi (дэд скан)
Өнгөний зузаан	Өнгө ❏ 48 битийн пиксель бүрт дотоод (дотоод өнгөний 16 битийн пиксель бүрт) ❏ 24 битийн пиксель бүрт гадаад (гадаад өнгөний 8 битийн пиксель бүрт) Саарал хүрээ ❏ 16 битийн пиксель бүрт дотоод ❏ 8 битийн пиксель бүрт гадаад Хар, цагаан ❏ 16 битийн пиксель бүрт дотоод ❏ 1 битийн пиксель бүрт гадаад
Гэрлийн эх үүсвэр	LED

Интерфэйсийн үзүүлэлт

Компьютерийн хувь	Өндөр хурдны USB

Сүлжээний функцийн жагсаалт

Сүлжээний функц ба IPv4/IPv6

Функц			Дэмжсэн	Тэмдэглэгээ
Сүлжээний принтер	EpsonNet Print (Windows)	IPv4	✓	-
	Standard TCP/IP (Windows)	IPv4, IPv6	✓	-
	WSD хэвлэлт (Windows)	IPv4, IPv6	✓	Windows Vista буюу түүнээс хойших
	Bonjour хэвлэлт (Mac OS)	IPv4, IPv6	✓	-
	IPP хэвлэлт (Windows, Mac OS)	IPv4, IPv6	-	-
	UPnP хэвлэлт	IPv4	-	Мэдээллийн зүйлс
	PictBridge хэвлэх (Wi-Fi)	IPv4	-	Дижитал камер
	Epson Connect (Э-шуудан хэвлэх, Алсаас хэвлэх)	IPv4	✓	-
	Google Cloud Print	IPv4, IPv6	✓	-
Сүлжээний сканнер	Epson Scan 2	IPv4, IPv6	✓	-
	Event Manager	IPv4	-	-
	Epson Connect (Үүл рүү сканнердах)	IPv4	-	-
	ADF (2 талаар сканнердах)		-	-
Факс	Факс илгээх	IPv4	-	-
	Факс хүлээн авах	IPv4	-	-

Wi-Fi Үзүүлэлтүүд

Стандарт	IEEE 802.11b/g/n*1, *2
Үелзлийн хүрээ	2.4 гГц
Хамгийн дээд радио давтамжийн цахилгаан дамжсан	19.8 dBm (EIRP)
Зохицуулах горим	Дэд бүтэц, Wi-Fi Direct (Энгийн AP)*3
Утасгүй сүлжээний аюулгүй байдал*4	WEP (64/128bit), WPA2-PSK (AES)*5

*1 Худалдан авалтын байршлаас хамааран IEEE 802.11b/g/n юмуу IEEE 802.11b/g-г мөрдлөгө болгоно.

*2 IEEE 802.11n нь зөвхөн HT20 дээр боломжтой.

*3 IEEE 802.11b-г дэмжихгүй.

*4 Wi-Fi Direct нь зөвхөн WPA2-PSK (AES)-г дэмжинэ.

*5 Хувийн WPA/WPA2-г дэмжих WPA2 стандартуудыг хангана.

Аюулгүй байдлын протокол

SSL/TLS	HTTPS сервер/клиент

Дэмждэг гуравдагч талын үйлчилгээ

Google Cloud Print

Хэмжээс

Хэмжээс	Хадгалах ❏ Өргөн: 390 мм (15.4 инч) ❏ Зузаан: 300 мм (11.8 инч) ❏ Өндөр: 145 мм (5.7 инч) Хэвлэх ❏ Өргөн: 390 мм (15.4 инч) ❏ Зузаан: 504 мм (19.8 инч) ❏ Өндөр: 279 мм (11.0 инч)
Жин*	Ойролцоогоор 3.9 кг (8.6 фунт)

* Хорны картридж болон цахилгааны утасгүйгээр.

Цахилгааны Үзүүлэлтүүд

Загвар	100 – 240 В Загвар	220 – 240 В Загвар
Нэрлэсэн Давтамжийн Хамрах Хүрээ	50 – 60 Гц	50 – 60 Гц
Нэрлэсэн Гүйдэл	0.5-аас 0.3 А	0.3 А

Эрчим хүчний зарцуулалт (USB холболттой)	Дангаар хуулбарлах: Ойролцоогоор 12.0 W (ISO/ IEC24712) Бэлтгэх горим: Ойролцоогоор 4.0 W Унтах горим: Ойролцоогоор 1.6 W Тэжээл унтраах: Ойролцоогоор 0.3 W	Дангаар хуулбарлах: Ойролцоогоор 12.0 W (ISO/ IEC24712) Бэлтгэх горим: Ойролцоогоор 4.0 W Унтах горим: Ойролцоогоор 1.6 W Тэжээл унтраах: Ойролцоогоор 0.3 W

Тэмдэглэл:
Принтер дээрх шошгоноос хүчдэлийг шалгана уу.

Орчны үзүүлэлт

Үйл ажиллагаа	Доорх графикт харуулсан хүрээнд доторх принтерийг ашиглана.  Температур: 10 – 35°C (50 – 95°F) Чийгшил: 20 – 80% RH (конденсацигүйгээр)
Хадгалах	Температур: -20 – 40°C (-4 – 104°F)* Чийгшил: 5 – 85% RH (конденсацигүйгээр)

* Та 40°C (104°F) -т нэг сарын турш хадгалах боломжтой.

Хорны картриджийн байгаль орчны үзүүлэлт

Хадгалах температур	-30-с 40 °C (-22-с 104 °F)*
Хөлдөх температур	-16 °C (3.2 °F) Бэх царцах бөгөөд 25 °C (77 °F) дээр 3 цаг байлгасны дараа ашиглах боломжтой болно.

* Та 40 °C (104 °F) дээр нэг сарын турш хадгалах боломжтой.

Системийн шаардлага

❏ Windows 10 (32-бит, 64-бит)/Windows 8.1 (32-бит, 64-бит)/Windows 8 (32-бит, 64-бит)/Windows 7 (32-бит, 64-бит)/Windows Vista (32-бит, 64-бит)/Windows XP SP3 эсвэл сүүлийн үеийн (32-бит)/Windows XP Professional x64 Edition SP2 эсвэл сүүлийн үеийн

❏ macOS High Sierra/macOS Sierra/OS X El Capitan/OS X Yosemite/OS X Mavericks/OS X Mountain Lion/Mac OS X v10.7.x/Mac OS X v10.6.8

Тэмдэглэл:

❏ *Mac OS нь зарим програм хангамж, тохиргоог дэмжихгүй байж магадгүй.*

❏ *(UFS)-д зориулсан UNIX Файлын систем Mac OS нь дэмжигдэхгүй.*

Хууль журмын мэдээлэл

Европ загварын стандарт болон зөвшөөрөл

Европын хэрэглэгчдэд

Seiko Epson корпорац дараах радио техник төхөөрөмжийг 2014/53/EU-н заалтад нийцүүлсэн гэдгээ мэдэгдэж байна. ЕХ-ны заалтад нийцүүлсэн тухай мэдэгдлийг дараах сайтаас авах боломжтой.

http://www.epson.eu/conformity

C462Q

Зөвхөн Ирланд, Их Британи, Австри, Герман, Лихтенштейн, Швейцари, Франц, Бельги, Люксембург, Нидерланд, Итали, Португал, Испани, Дани, Финлянд, Норвеги, Швед, Исланд, Хорват, Кипр, Грек, Словени, Мальт, Болгар, Чех, Эстони, Унгар, Латви, Литва, Польш, Румын, Словак улсад ашиглахад зориулав.

Бүтээгдэхүүнүүдэд санал болгоогүй өөрчлөлт шинэчлэлийг хийснээс үүдэн хамгаалалтын шаардлагыг хангахгүй болсон аливаа тохиолдлын хариуцлагыг Epson хүлээхгүй болно.

CE

Хуулбарлахад тавигдах хязгаарлалт

Принтерийг хариуцлагатай, хуулийн дагуу хэрэглүүлэхийн тулд дараах хязгаарлалтыг тавьж байна.

Дараах зүйлсийг хуулбарлахыг хуулийн дагуу хориглож байна:

❏ Мөнгөн тэмдэгт, зоос, засгийн газрын хэвлэсэн, зах зээлд гаргах үнэт цаас, засгийн газрын бондын үнэт цаас болон хотоос гаргасан үнэт цаас

❏ Хүчинтэй шуудангийн тэмдэг бүхий ашиглаагүй шуудангийн марк, урьдчилан тамгалсан шуудангийн карт, бусад шуудангийн зүйлс

❏ Засгийн газрын хуулийн дагуу хэвлэсэн орлогын тэмдэг, болон үнэт цаас

Дараах зүйлсийг хуулбарлах үед тавих анхаарал:

❏ Зах зээлд худалдах хувийн үнэт цаас (хувьцааны гэрчилгээ, харилцан тохиролцсон тэмдэг, чек гэх мэт), сарын хураамж, концессийн тасалбар гэх мэт.

❏ Пасспорт, жолоочийн үнэмлэх, зохистой байдлын баталгаа, зам нэвтрэх, хүнсний зүйл, тасалбар гэх мэт.

Тэмдэглэл:
Эдгээр зүйлсийг хуулбарлахыг мөн хуулиар хориглосон.

Зохиогчийн эрхтэй баримт бичгийг хариуцлагатай ашиглах:

Зохиогчийн эрхтэй баримт бичгийг зүй бусаар хуулбарлаж принтерийг зохистой бусаар ашиглах аюул бий. Мэдлэг туршлагатай хуульчийн зөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулахгүй бол, хэвлэгдсэн баримт бичгийг хуулбарлахаас өмнө зохиогчийн эрх эзэмшигчээс зөвшөөрөл авч хариуцлагаа хүлээн хүндэтгэлтэй хандана уу.

Принтерийг зөөвөрлөх

Принтерийг зөөвөрлөх эсвэл засварт өгөх шаардлагатай үед, доорх алхмыг дагаж принтерийг баглаарай.

> ***Чухал:***
> ❏ *Принтерийг хадгалж, тээвэрлэх үед, үүнийг хазайлгах, босоо байрлалд тавих, хөмөрч тавихаас болгоомжлох хэрэгтэй.*
> ❏ *Бэхний картриджийг суулгаад орхино. Картриджийг салгавал принтерийн толгой хатаж, принтер хэвлэхгүй болж болно.*

1. ⏻ товч дээр дарж принтерийг унтраана.
2. Тэжээлийн гэрэл унтарсан эсэхийг шалгаж, тэжээлийн залгуурыг салгана.

> ***Чухал:***
> *Тэжээлийн гэрэл унтарсан үед тэжээлийн залгуурыг салгана. Эс бөгөөс, хэвлэх толгой үндсэн байрлалдаа шилжилгүй, бэх хатах, улмаар хэвлэх боломжгүй болоход хүргэнэ.*

3. Тэжээлийн залгуур, USB кабел зэрэг бүх кабелийг салгана.
4. Принтерээс бүх цаасыг авна.
5. Принтер дээр эх хувь үлдээгүй эсэхийг шалгана.
6. Баримтын тагийг хаалттай хэвээр сканнерийн нэгжийг нээнэ. Хорны картриджийн бэхлэгчийг наалддаг туузаар саванд нь бэхэлж хөдөлгөөнгүй болго.



7. Сканнерийн нэгжийг хаана.



8. Доор харуулсны дагуу принтерийг баглахад бэлтгэнэ.



9. Принтерийг хайрцганд нь хамгаалалтын материалаар баглаж хийнэ.

Принтерийг дахин ашиглахдаа, хорны картридж бэхлэгчийг бэхэлж тогтоосон наалтыг салгахаа мартуузай. Дараагийн удаа хэвлэх үед хэвлэх чанар муудсан байвал, хэвлэх толгойг цэвэрлэж тэгшигтэнэ.

Холбогдох мэдээлэл

➡ 15 хуудас дээрх “Эд ангийн нэр ба функцууд”

➡ 88 хуудас дээрх “Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх”

➡ 90 хуудас дээрх “Принтерийн толгойг тохируулна”

Хаанаас тусламж авах вэ

Техник туслалцааны вэбсайт

Танд нэмэлт тусламж хэрэгтэй бол, доор үзүүлсэн Epson-н тусламжийн вэбсайт руу орно уу. Улс, бүс нутгаа сонгоод өөрийн дотоодын Epson вэбсайтын тусламжийн хэсэг рүү орно уу. Хамгийн сүүлийн үеийн драйвер, тусламж, гарын авлага эсвэл бусад татаж авах боломжтой материал энэхүү вэбсайт дээр байх болно.

http://support.epson.net/

http://www.epson.eu/Support (Европ)

Таны Epson бүтээгдэхүүн зохих ёсоор ажиллахгүй бөгөөд та асуудлыг шийдвэрлэж чадахгүй байвал, туслалцаа авахын тулд Epson-н тусламжийн хэсэгтэй холбогдоно уу.

Epson-н тусламжтай холбогдох

Epson-той холбоо барихаас өмнө

Таны Epson бүтээгдэхүүн зөв зүйтэй ажиллахгүй, та бүтээгдэхүүний гарын авлага дээрх асуудлыг шийдэх мэдээллийг ашиглан асуудлыг шийдэж чадахгүй байвал, тусламж авахаар Epson-н дэмжлэгийн үйлчилгээг авахаар холбоо барина. Танай бүс нутаг дахь Epson-н дэмжлэгийг доор харуулаагүй байвал, бүтээгдэхүүнээ худалдаж авсан худалдааны газартай холбоо барина.

Та дараах мэдээллийг тэдэнд өгвөл Epson-н дэмжлэгийн үйлчилгээ танд илүү хурдан туслах болно:

- ❏ Бүтээгдэхүүний серийн дугаар

  (Серийн дугаарын шошгыг гол төлөв бүтээгдэхүүний ард байрлуулдаг.)
- ❏ Бүтээгдэхүүний загвар
- ❏ Бүтээгдэхүүний программ хангамжийн хувилбар

  (**About**, **Version Info** дээр дарах, эсвэл бүтээгдэхүүний программ хангамжийн ижил төстэй товчин дээр дарна.)
- ❏ Таны компьютерийн брэнд ба загвар
- ❏ Таны компьютерийн үйлдлийн систем ба хувилбар
- ❏ Та байнга бүтээгдэхүүнтэйгээ хамт хэрэглэдэг программ хангамжийн нэр ба хувилбар

Тэмдэглэл:
Бүтээгдэхүүнээс шалтгаалж, сүлжээний тохиргоог бүтээгдэхүүний санах ойд хадгалж болно. Бүтээгдэхүүний эвдрэл гэмтэл эсвэл засвараас болоод тохиргоог алдаж болно. Epson нь баталгаат хугацааны туршид хүртэл аливаа мэдээлэл, тохиргоог хадгалах, эсвэл сэргээх асуудлыг хариуцахгүй. Та өөрийнхөө хадгалах мэдээллийг хийж, тэмдэглэл хөтлөхийг санал болгож байна.

Европын хэрэглэгчдэд тусламж үзүүлэх

Европ дахины баталгааны мэдээллээс Epson-н тусламж үйлчилгээтэй хэрхэн холбогдох талаар уншина уу.